

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Эзэгтэй нар бодит тоог
илүүд үзэж байна

Экспортын татвар эдийн
засгийг эмчилнэ

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2011. 11 сар. №009

www.mongolianeconomy.mn



Бэлэн мөнгөнд живсэн жил айсуй



Nissan Motors Co., Ltd.
www.nissan.com



PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.

УУРХАЙН ТОНОГЛОЛ БҮХИЙ

FORD RANGER 2011

ХҮЧИН ЧАДАЛ + АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Вагнер Ази Автомотив ХХК
Хаяг: Нарны зам 55/ Тээвэрчдийн гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
Утас: 99118375, 99108368, 99108303, 99108386, 99118301



Feel the difference



САНХҮҮГИЙН ТҮРЭЭС

— машин механизм, тоног төхөөрөмж —

ТАНЫ АМЖИЛТЫН ХӨДӨЛГҮҮР



Хэмжээ

30 сая төгрөгөөс дээш

Сарын хүү

1.4%–2.0% /төгрөг/ 1.3%–1.6% /ам.доллар/

Хугацаа

6–60 сар хүртэл

OMEGA

GEORGE CLOONEY'S CHOICE.




OMEGA

www.omega.com
Swiss Watch Boutique
Наран Пойнт Дэлгүүр, Хувьсгалчдын гудамж
Утас: 326435



Онцлох сэдэв

Эзэгтэй нар бодит тоог илүүд үзэж байна

И.Отгонжаргал

Сонгинохайрхан дүүргийн Там-гын газартай хаяа нийлэн сүндэрлэсэн “Орчлон” хорооллоос “Хүчит шонхор” зах хүрэхэд ойролцоогоор арав гаруй км-ын зайтай. Сүүлийн үед амралтын өдөр ч гэсэн замын ачаалал буурахгүй байгаа болохоор заримдаа тус зах руу явахдаа нэг, хоёроор ч тогтохгүй цаг зарцуулж, бухимдах нь бий. Тэгэн тэгэн зөвхөн мах авахын төлөө хаа байсан Чингэлтэй дүүрэгт байршилтай “Хүчит шонхор”-ыг зорьдог нь учиртай. Манай өрхийн төсвийн нэг сарын хүнсний хэрэглээнд махны үнэ нэлээд жин дардаг. Тийм болохоор цалин маань инфляцын өсөлттэй энэ үед хаанаа ч хүрэлцэхгүй учраас махаа “Хүчит шонхор” захаас авах нь илүү хэмнэлттэй тусдаг гэх үү дээ. Эндээс мах авах нь хотын төвийн бусад хүнсний зах болон дэлгүүрийн махнаас нэг кг тутамд 200-300 төгрөг, зарим тохиолдолд 500 төгрөгөөр ч хямд байдаг.

Тэгээд ч үнээс гадна махны нийлүүлэлтийн төв зах гэдэг утгаараа /хөдөө, орон нутгаас

оруулж ирж буй махны бөөний төв гэсэн үг/ сонголт сайтай. Мөн малын гаралтай түүхий эд түлхүү борлуулдаг хэрнээ төрөлжсөн болоод ч тэр үү эрүүл ахуй, ариун цэврийн хяналт гайгүй санагддаг. Худалдагч нарынх нь хүнсний аюулгүй байдлыг хангах ухамсар нь ч бусад зах, дэлгүүрийнхнээс арай л өөр байдаг юм” гэж нөхөр маань олзуурхдаг.

Саяхны мах худалдан авч явж байгаад худалдагч нар нь хоорондоо ийн ярихыг нь сонслоо. Яриа өрнүүлсэн эмэгтэйчүүдийн нэрийг нь сайн мэдээгүй учраас нэг дэх, хоёр дахь, гурав дахь хүн гэж нэрлэе. Нэг дэх нь “Зурагт асаахаар л эдийн засгийн өсөлт өндөр байна. Гадаадын хөрөнгө оруулалт тэгж нэмэгдлээ. Нүүрсний экспортын хэмжээ зэсийнхээс давлаа гээд л чихэнд чимэгтэй сайхан сайхан юм ярихын. Үнэхээр манай эдийн засаг тэгж өсөөд байгаа юм байх даа” гэв. Хоёр дахь хүн буюу түүний залгаа лангууны 40 эргэм насны эмэгтэй “Харин тиймээ, манай Монгол чинь эдийн засгийн өсөлтөөрөө бараг

дэлхийд гайхуулаад байгаа юм биш үү. Заримдаа ч энэ сэтгүүлч нь худлаа мэдээлэл бэлтгээгүй байгаа даа гэж эргэлздэг юм” гэж хариуллаа.

Нэг дэх эмэгтэй “Үнэхээр дэлхийд гайхуулсан эдийн засгийн ийм өсөлт гараад байгаа юм бол бид нар шиг бор зүрхээрээ болгох гэж зүдэрч яваа ард иргэдийн амьдралд жаахан ч гэсэн өөрчлөлт мэдрэгдмээр юм”. Хоёр дахь эмэгтэй “Манайх л болсон хойно ярихаас цаашгүй байдаг биз дээ. Ээ мэдэхгүй, тэр талаар гарт баригдах юм байдаггүй байх аа” гэв.

Ярианд гуравдагч хүн орж ирэв. Залуухан 20 гаруй насны эмэгтэй. “Хэрвээ эдийн засаг өсөж байгаа бол юмны үнэ ингэж өдрөөс өдөрт нэмэгдэж, инфляци өсөхгүй шүү дээ. Цалин өндөр аваад ч нэмэргүй юм билээ. Манай эгч “Мобиком”-д гайгүй ажил хийдэг. Нөхөртэйгээ хоёулангийнх нь сарын орлого бараг хоёр сая төгрөгт хүрдэг гэж байсан. Тэгсэн хэрнээ л хэрэгцээнд нь таараад байх шиг харагддаг. Тэгэхээр бидний олж байгаа хэдэн төгрөг хаанаа ч хүрэхгүй байх нь аргагүй юм байна даа гэж би бодсон” хэмээн сонирхууллаа. Нэг дэх эмэгтэй “Төрөөс бэлэн мөнгө өгөөд ч нэг их нэмэр болж байгаа юм алга. Банкинд үүрээр очиж урт дараалалд зогсож байж, хэдэн төгрөг авна. Тэр нь нэг удаа хүнс цуглуулаад л дуусчихаж байгаа юм чинь. Одоо өвлийн хүйтэнд яаж 21 мянга авч байна даа. 2012 онд бэлэн мөнгө бүр их тараахаар байгаа юм билээ ш дээ. Хөөрхий муу Баярцогт сайд зөв ч юм хийгээд байгаа юм уу, буруу ч юм хийгээд байгаа юм уу, бүү мэд. Их л зэмлүүлж харагдах юм байна шүү дээ. Энэ байдлаараа ▶

► байх юм бол хэчнээн бэлэн мөнгө тараагаад ч өөдлөхгүй байх” гэв. Гурав дахь нь “Уг нь бэлэн мөнгө их тараах чинь муу гэсэн. ОУВС-гаас манай Засгийн газарт анхааруулж, зөвлөмж өгсөн юм билээ. Бэлэн мөнгө тараахаа багасга гэж”. Хоёр дахь эмэгтэй “Инфляци гэж яг юуг хэлээд байдаг юм бэ? Би хүүхдүүдээсээ асуухаар сайн тайлбарлаж мэдэхгүй юм даа, ээж минь гэхийн”. Гурав дахь эмэгтэй “Би хувьдаа юмны үнэ өсөхийг л хэлдэг байх гэж ойлгоод байгаа шүү дээ. Манай үйлчлүүлэгчид хүртэл махны үнэ нэмэгдэж байгаад бухимдаж, өдөр бүхэн биднийг ууртай харцаар шилбүүрдээд л байгаа биз дээ. Зарим нь бараг барьж авч зодох нь холгүй. Уг нь бол стрессгүй, хангалуун сайхан амьдралтай нийгмийн иргэд бол хоол хүнсийг нь залгуулж байгаа хүмүүст талархах ёстой байх л даа. Даанч манайд тийм биш юм даа. Бид нар шуналтайдаа үнэ нэмээд байгаа юм шиг л ойлгохын. Гэтэл махны бөөний үнэ нь нэмэгдээд байдаг. Бид нар ч гэсэн худалдан авагч нартай адилхан л үнэ нэмэгдээд байгаад уур хүрч байгаа юм чинь” хэмээв. Нэг дэх эмэгтэй “Тэгээд тэр бахархан яриад байгаа түмний амьдралд нэмэргүй эдийн засаг өссөн гэсэн худлаа тоон үзүүлэлт хэнд хэрэгтэй юм бол. Төр, засгийнханд энд тэндээс зээл тусламж авах, гаднын хөрөнгө оруулагчдыг татах зэрэгт нь л хэрэг болдог юм байлгүй дээ. Ёстой чөтгөр бүү мэд. Уг нь ард түмний амьдралд жаахан нийцсэн юм ярьж байвал хэрэгтэй л байх” гэв.

Худалдагч нарын яриа нэг талаасаа хөгжилтэй ч нөгөө талаас бодит амьдралын гүнээс ундрэн гарч буй үнэн үг болохоор нь өрх гэрийн сангийн захирлуудын санаа бодлыг төр, засгийн шийдвэр гаргагч нарын сонорт хүргэхэд илүүдэхгүй болов уу гэдэг үүднээс тэвчээр гарган сонссон юм. Манайхны хэлдгээр ёстой нөгөө “Хоёр идэж, хоосон хонохгүй” болгож яваа эгэл амьдралтай монголчуудын төлөөллийн эдийн засаг үнэхээр өсөж байгаа гэж үү? Өсөж байгаа бол бидний амьдралд яагаад ямар нэгэн өөрчлөлт мэдрэгдэхгүй байна вэ гэсэн асуултын бодит хариу энэ байлаа.


Нээрээ сүүлийн жилүүдэд бялууртлаа сонсох болсон эдийн засгийн өсөлт төдөн хувьтай гарлаа гэсэн статистикийн хуурай тоо, хоосон яриа хэнд хэрэгтэй юм бол. Эзэгтэй нар бодит тоог илүүд үзэж байна. Дээрх яриаг өрнүүлсэн эмэгтэйчүүдийн мэдлэг боловсролын түвшинг хэлж мэдэхгүй, гаднаас нь хараад. Гагцхүү эндээс өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн талаарх төр, ард түмний бодол хийгээд бодит амьдрал ямар их зөрүүтэйг тод харж болно. Нэг үгээр хэлбэл, ард иргэд бэлэн мөнгө аваад амьдрал дээрдэхгүй байгаагаа хэлж байна. Ажил хөдөлмөргүй битгий хэл, дундаас дээш түвшний орлоготой өрх өнөөдрийн үнийн хөөстэй нийгэмд дөнгөн данган болгож явааг бас тэмдэглэв.

Инфляцийн өсөлт, эдийн засгийн халалт явагдаж байгаа энэ үед төр, засгийн түшээд маань орлого, зарлага, өсөлтийн том тоо ярьж, сонгуулийн амлалтаа гүйцэлдүүлэх гэж бэлэн мөнгө тараахдаа гол нь биш, зөв шийдвэр гаргаж, улсынхаа эдийн засгийг ангалд унагачихгүй байгаасай гэж хүсэж байна, олон нийт. Тийм ч учраас төсөв, мөнгөний бодлого төр, засгаар шүүгдэх үед “Mongolian Economy” сэтгүүл ирэх онд “Өглөгч аав, өвчинд нэрвэгдсэн ард түмнээ” эдгээж илааршуулах чиглэлд түлхүү ажиллаасай гэсэн зорилгоор “Төсөв-2012”-ыг онцлох сэдвээ болголоо.

Уул уурхайн хөгжлийн хурд нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ өсөж байгаатай холбоотой манай улсын төсвийн тогоо томорсоор. Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн нийт орлого 477.9 тэрбум төгрөг, нийт зарлага 892.1 тэрбум төгрөгт хүрч тус сангийн тэнцэл -414.2 тэрбум төгрөгийн баланстай гарч байгааг юу гэж ойлгох вэ. 2012 онд Засгийн газраас ард түмнийхээ дээрээс мөнгөөр бороо оруулж, халамж, хайр зарлах нь. Гэвч бодит амьдрал дээр үр дүн багатайг наймааны арга ухаантай эмэгтэйчүүд шинжин тольдож байна. Эзэгтэй нар уг нь өрх гэртээ бол сангийн сайдын албыг хашдаг хүмүүс. Нөхрийнхөө цалингийн картыг эзэмшинэ. Хүүхдийнхээ сургалтын төлбөр, хоол, унааны мөнгийг нь

хуваарилна. Шинэ жилийн баярын ширээ ямар байх, Цагаан сараар ууц тавих үгүйг зөвхөн эзэгтэй нар л шийддэг.

Эцэст нь саяхны сургамжит явдлыг төр, засгийн завгүй эрхмүүдэд цухас эргэн сануулахад илүүдэхгүй болов уу. Өнөөдрийн байдлыг ажиглахад ерөнхийдөө 2008 оны эдийн засгийн хямрал манайд дахин айлчлахгүй гэх газаргүй. 2007 оноос манай Засгийн газар бэлэн мөнгө эрчимтэй тарааж эхэлсэн санагдана. Гэтэл жилийн дараа юу боллоо. Инфляци 34 хувьд хүрч, сандаргасан. Засгийн газар бүсээ чангалж, Төвбанк бодлогын хүүгээ шат дараалалтайгаар өсгөснөөр дээрх гаарсан инфляцийг чөдөрлөж чадсан. Түүнчлэн тухайн жил зөвхөн инфляци айдаст автуулаагүй. Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ хямралаас болж навс унахад Монголын эдийн засаг хүнд цохилтод орж, хүүхдийн мөнгөө ч тарааж дийлэхээ байсан шүү дээ. Тэр үед нэг хүнд тарааж байсан бэлэн мөнгө, үзүүлж байсан нийгмийн халамж нь өнөөдрийнхөөс хэд дахин бага байв. Тухайн үед олгож байсан хүүхдийн мөнгө гэхэд л 3000 төгрөг байсан. Гэтэл өнөөдөр нэг хүнд хамгийн багадаа сард 21000 төгрөгийн халамж үзүүлж байна. Тэгээд цаашлаад далан мянга, таван зуун мянга, нэг сая, сая таван зуун мянга гээд халамжийн том тоонууд ар араасаа хөвөрнө. Хэрвээ эдийн засгийн хямрал боллоо гэхэд сүүдэр нь дайрах төдийд Монголын хэт өөдрөг эдийн засаг хиар цохиулахаар байгаа юм. 2008 онд Монгол Улсыг аз түшсэн. Урд хөрш хямралд барьц алдаагүй учраас манайх харьцангуй гайгүй өнгөрсөн гэдгийг эдийн засагч, мэргэжилтнүүд хэлдэг. Тэгвэл одоо Хятадын инфляци өнгөрсөн долдугаар сард 6.5 хувьд хүрсэн. Энэ нь сүүлийн гурван жилийн дээд үзүүлэлт бөгөөд тус улсын эрх баригчдын толгойны өвчин болоод зогсохгүй дэлхийг сандаргаж байгаа билээ. Энэ нь хэрвээ муу юм болвол Монголын эдийн засагт аврагдах нуувч үнэхээр байхгүй гэсэн үг. Үүнийг манай төр, засгийн шийдвэр гаргах түвшний хүмүүс гадарлаж л баймаар. Гэтэл тэдний Монголын эдийн засгийг унаж, босоход нь үргэлж хамт байсан ►



Шог зургийг А.Амарсайхан

Төсөв

Бэлэн мөнгөнд живсэн, бизнес хавчигдсан жил айсуу

Д.Мөнхчимэг

Улстөрчдийн сонгуулийн синдром эхэлчихэж. Зурагт асаахаар л нүүр дүүрэн малийсан эрхэм гарч ирээд, мянган хүнд түмэн янзын халамж үзүүлэх гэж буйгаа гайхуулах болжээ. Улс их баян болсон гэнэ.

Ирэх онд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 53 хувиар нэмэхийн зэрэгцээ тэтгэврийн насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрт нэг нэг сая төгрөг, бүх оюутанд сард 70 мянган төгрөгийн стипенд олгоно гээд л... 2012 оны төсвийн төслийг олж харсан мэргэжилтнүүд популизм Монголд газар авч байгааг гайхаж, ▶

▶ олон улсын байгууллагынхны төсвийн зардлаа хэт тэлэхгүй, халамжаа хавтгайруулахгүй байхтай холбоотой өгч байгаа санал зөвлөмжийг огтхонч тоосон шинжгүй авирлаж байгаа нь саяхны явдлаа умартаа юу гэлтэй.

Эзэгтэй нар инфляци гэж юу болохыг мэдэхийг хичээж байна. Амьдрал таагүй байгаа болохоор асуудлын учрыг олохыг нийгэм шаардаж байна. Тэгвэл МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар “Инфляци юунаас болж өсдгийг мэдэхгүй хүмүүс төрд ажиллаж, шийдвэр гаргаж байна шүү дээ” хэмээн халаглаад, инфляцийг ийн тайлбарлажээ. “Инфляци өсөх олон шалтгаан бий. Жишээ нь, Монголын

зах зээлд нийлүүлж байгаа нийт элсэн чихрийн 75 хувийг ганцхан компани дангаараа хянадаг. Тэд элсэн чихэр үйлдвэрлээгүй хэрнээ зөвхөн зөөснийхөө төлөө үнийг нь 400 дахин нэмж байна. Төр дампуу байгаа учраас шуналтай хүмүүс ингэж давардаг. Үүнийг л инфляци гээд байгаа юм. Хамгийн энгийнээр хэлбэл, иргэд өнөөдөр хоёр талхны үнээр нэг талх авч байна” гэжээ. Энэ үнэн.

Өссөөр байх нь ойлгомжтой болсон инфляцийг 2008 оных шиг “ногтолж” чадах уу, Төвбанк, Засгийн газар. Дэлхийн эдийн засгийн хямрал цаашилснаас хойш дээрх хоёр байгууллага төсөв, мөнгөний бодлогоо уялдуулах

талаар хуруугаа ч хөдөлгөхгүй өнөөдрийг хүрэв. Хуруугаа ч хөдөлгөхгүй гэснээс Монголбанкны хувьд асуудлын шийдлийг хамтдаа хайх, гарц олох талаар эрэлхайгуул хийе гэдгээ хэвлэлийнхэнтэй хүртэл уулзаж учирладаг. Харамсалтай нь Сангийн яам тэдний ийм сайхан санал санаачилгад ургаа чулуу шиг суух нь урамгүй. Төвбанкны хувьд төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах, инфляцийг бууруулахын төлөө чадах бүхнээ хийж буй. Гэхдээ эдийн засагт халалтын шинж тэмдгүүд илэрч байгаа энэ үед Монголбанк идэвх санаачлагатай ажиллалаа гээд Засгийн газар бүсээ чангалах талаар ам ангайхгүй бол гаарсан инфляцийг тогтоон барина гэдэг юу л бол. ■

▶ толгой сэгсэрч байна. Түүхэнд байгаагүйгээр тэлсэн төсвийн төслөө УИХ-д өргөн барихдаа Ерөнхий сайд С.Батболд “Сонгуулиар амласан бүхнээ бүрэн биелүүлэхийн тулд нөөц боломжоо ихээхэн дайчиллаа” гэнэ билээ. Гэхдээ хэний мөнгийг ийнхүү хуваарилаад байгаагаа тэрбээр онцолсонгүй. Өөрсдийнх нь мөнгийг төсвөөр дамжуулан хэрхэн зарцуулж буйг татвар төлөгч бизнесмэнүүд болоод иргэд мэдэх, хянах эрхтэй.

Том том тоо

Дэлхийн ихэнх орон болзошгүй хямралаас сэргийлж, төсвөө танаж, хуримтлалаа базааж байх зуур Монгол Улс тэс хөндлөн явж байна. Ирэх онд эдийн засгийн бодит өсөлт 25.6 хувьд хүрнэ гэсэн өөдрөг гэхэд хэтэрхий багадаа таамаглалд үндэслэн бүхэл бүтэн төсөв боловсруулчихлаа. Энэ тухай Сангийн сайд С.Баярцогтоос асуухад “Яагаад болохгүй гэж? Энэ онд эдийн засгийн өсөлт бидний таамаглаж байснаас хоёр дахин өндөр гарчихсан байгаа шүү дээ” гэв.

Нэгдсэн төсвөөс 2012 онд 7.1 их наяд төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн нь орлогоосоо 740.9 тэрбумаар давж байна. Энэ бол монголчуудын өмнө нь хэзээ ч сонсоогүй том тоо. Өнгөрсөн онд зарлагын хэмжээ “ердөө” дөрвөн их наяд төгрөг байхад зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш үзэгдээгүй данхар төсөв боллоо хэмээн шүүмжилж байсан мэргэжилтнүүд одоо бүр хэлэх үгээ олохоо байв. Энэ их мөнгийг хаанаас олох гээд байна вэ?

Мэдээж ашигт малтмал төсвийн орлогын нэлээд хэсгийг бүрдүүлдэг. Тэр дундаа ирэх онд уул уурхайн салбарын нийт татварын орлогын 90 хувь нь зөвхөн зэс, нүүрснээс төвлөрөхөөр байгааг анхаарах хэрэгтэй. 2012 онд тонн зэсийн үнэ 9760 ам.доллар, нүүрсний ханш төрлөөсөө хамаарч 75-199.9 ам.доллар байхаар төсөөлж төсөвт суулгажээ. Харин унци алт 1723.75 ам.доллар байх аж. Гэтэл эдүгээ Лондоны металлын бирж дэх тонн зэс 7500 ам.доллараас доош, Нью-Йоркт унци алт 1650 ам.доллараас бага үнээр арилжаалагдаж буйг сануулах юун. Ер нь дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ санаанд оромгүйгээр савлах нь бий. 2008 оны долдугаар сард 9000 долларт хүртлээ цойлж байсан зэсийн ханш хямралаас болоод хагас жилийн дотор 2770 доллар болтлоо шалдаа буухад манай төсөв алдагдалтай гарч, эдийн засаг уналтад орсон. Сандарсан эрх баригчид тоогоо алдталаа төсвөө тодотгосон. Тэгвэл ирэх жил ийм байдал давтагдахгүй гэх баталгаа хаа байгааг Сангийн сайдаас асуухад “Хямрал жил бүр тохиолдоод байдаггүй шүү дээ” хэмээн хариуллаа.


Цалин, тэтгэвэр, бэлэн мөнгө

Засгийн газар цалинг хоёр дахин нэмнэ гэсэн амлалтаа биелүүлэхийн тулд ирэх онд төрийн албан хаагчдын цалин хийгээд тэтгэвэр, тэтгэмжийг 53 хувиар нэмэх гэж байна. Үүнд 700 тэрбум төгрөг буюу төсвийн нийт зарлагын 10 хувийг зориулах юм.


Гэхдээ монгол иргэдийн тоо 2.8 саяд хүрч байхад түүний ердөө 5.6 хувь болох 156 мянган төрийн албан хаагчийн цалинг нэмлээ гээд ард иргэдийн амьдрал сайжрах нь юу л бол. Түүнчлэн энэхүү шийдвэр хувийн хэвшлийнхэнд хүнд цохилт болох тухай мэргэжилтнүүд анхааруулж байна. Учир нь, төрийн албан хаагчдын цалин огцом нэмэгдчихээр хувийн хэвшилд зүтгэж байгаа хүмүүс ч хөдөлмөрийн хөлсөө голж эхлэх нь дамжиггүй.

“Жижиг, дунд үйлдвэрүүд цалингаа нэмэхийн тулд ажилтнуудаасаа халах хэрэгтэй болно. Нэгийгээ халаад нөгөө ажилтныхаа цалинг нэмлээ гэхэд үйлдвэрийнх нь хэвийн үйл ажиллагаа доголдож, үр ▶

Төсвийн зардал (ДНБ-д эзлэх хувиар)



ДНБ-ий өсөлт (хувиар)



Эх сурвалж: Сангийн яам

дүнд нь нийт эдийн засгийн идэвх ерөнхийдөө сулардаг” хэмээн Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл ярьж байна.

“Засгийн газар цалин нэмэх нь тодорхой боллоо. Тиймээс шоконд орохгүйгээр давж гарах бэлтгэлээ хангаарай гэж ажил олгогч эздэд хандан эртхэн мэдээлэл өгье. Тэд чинь төсвийн биш, өөрсдийнхөө мөнгөөр бизнес эрхэлж байгаа хүмүүс шүү дээ” хэмээн Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар онцолсныг “Монцамэ” агентлаг дамжууллаа.

Ер нь Засгийн газрын ирэх онд зарцуулах 7.1 их наяд төгрөгийн гуравны нэг нь цалин, тэтгэврийн өсөлт, нийгмийн халамж, бэлэн мөнгө хэлбэрээр иргэдийн гар дээр очих гэж буй. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг урд, хойд хөршөөсөө базаадаг монголчууд энэ их мөнгийг улсынхаа эдийн засагт шингээж чадна гэдэг эргэлзээтэй. Энэ нь инфляцийг гааруулахаас цаашгүйг мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

“Засгийн газар төсвийг их хэмжээгээр тэлж байгаа нь инфляцийг хөөргөх нь тодорхой” хэмээн Монголбанкны мөнгөний бодлого, судалгааны газрын дарга Б.Болдбаатар тайлбарлав. Үнийн өсөлттэй тэмцэхийн тулд өнгөрсөн аравдугаар сарын 25-нд Төвбанк бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар нэмж, 12.25 болгох шийдвэр гаргаснаа ч зарлалаа. Энэ нь арилжааны банкуудын тэртэй тэргүй өндөр байгаа зээлийн хүүг тэнгэрт хадахад хүргэх нь ойлгомжтой. Тэгэхээр үндэсний үйлдвэрлэгчид өсөж томрох боломж улам л давчуу болох буюу.

Популист төр

“Хэрэгжих нөхцөлгүй, хэрэгжсэн ч улс орны хөгжилд хор хохирол учруулах утгагүй мөртлөө сонсоход сайхан амлалтыг популизм гэдэг. Энэ бол хямд улс төр юм” хэмээн Баабар бичиж байв. Үүний тод жишээ өнөөгийн Грек билээ. Олон улсын валютын сан, Европын холбоо, Европын Төвбанкнаас авч буй зээлээрээ амь зогоож буй тус улсын эрх баригчид яаж “нусаа хацартаа нааж” байгааг харахад л хангалттай. Дампуурлын ирмэгт ирсэн эх орноо аврахын тулд Грекийн Засгийн газар төрийн албан хаагчдынхаа тоог цөөлж, цалин тэтгэврийн хэмжээг танаж, гудамжаар нэг жагсаал, цуглаан зохион байгуулж буй иргэдтэйгээ “тэмцэж” байна.

Энэ бүхний эхлэл 30 жилийн өмнө тавигджээ. Хоёр нам нь төрийн эрхэнд гарахын тулд ард түмэндээ “улс төрийн чихэр” өмхүүлж, сайхан амлалтаар булж байлаа. Дараа нь тэрхүү амлалтуудаа биелүүлэхийн тулд Грекийн өнөөгийн Ерөнхий сайдын эцэг Андреа Папандреу засгийн эрх авахдаа төрийн албан хаагчдын тоог нэмж, төрөл бүрийн хөнгөлөлт үзүүлж эхэлжээ. Энэ нь хүнд суртал, авлигыг өөгшүүлж, хувийн хэвшлийнхнийг боомилж, үр дүнд нь ДНБ-ийхээ тал хувийг төр нь бий болгодог болсон байна. Нэг сонгуулиас нөгөө сонгуулийн хооронд амлалт биелүүлж явсаар байгаад их хэмжээний өрөнд унаж, төсвийн хямралд орсны зэрэгцээ бэлэнчлэх сэтгэлгээтэй, босож тэмцэх дуртай ард түмэнтэйгээ нүүр тулж хоцорсон нь энэ.

Европын хөгжингүй орон хүртэл популизмаас болж ийнхүү дампуурлын хаалга татахдаа тулж байхад буурай орны ангиллаас дөнгөж гарч буй Монгол Улс яах бол?

“Улс төрийн амлалт биелүүлж буй нь хоёр талтай. Орлого багатай хүмүүсийн амьжиргаанд сайнаар нөлөөлж байна. Нөгөө талаас монголчуудыг залхуу болгож байгаа нь үнэн л дээ” хэмээн С.Баярцогт тайлбарлав.

“Төсвийг их хэмжээгээр тэлж, Засгийн газар бүх зүйлд оролцоод байвал хувийн хэвшлийнхэн хийх ажилгүй болж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг руугаа буцах нь уу гэж бодогдох юм” хэмээн Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэн онцоллоо.

Сонгуулийн дараа...

Сайн мэдээ гэвэл намууд 2012 оны сонгуульд бэлэн мөнгөний амлалтаар өрсөлдөхгүй байх санамж бичигт гарын үсэг зурцаасан. Гэвч сонгуулиас өмнө бэлэн мөнгө тараахгүй гэж хэн ч хэнд ч яриагүй гэсэн шиг хариуцлагагүй төсвийг Засгийн газар боловсруулжээ. 2012 оны төсвийг мэргэжилтнүүд “амлалтын төсөв”, “сонгуулийн төсөв” зэргээр шүүмжилж буй. “Ганцхан жилийн төсвийг хараад шүүмжлээд байж болно л доо. Гэхдээ улс төрийн тогтвортой байдал Монгол орны хувьд чухал. Нэгэнт л 2013 оноос байдал шал өөр болох нь тодорхой учраас одоо бид өмнөх амлалтаа биелүүлж дуусгах хэрэгтэй” гэж С.Баярцогт сайд тайлбарлалаа.

Үнэхээр 2013 оноос байдал шал өөр болно гэдэгт олон хүн эргэлзэж байна. Ирэх сонгуулиас эхлээд бэлэн мөнгө амлахгүй гэж улстөрчид ярьж байгаа боловч яг цаг дээрээ тулахаар яагаа ч билээ. Улстөрчид өөрсдөө хуулиа баталдаг шүү дээ. Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг 2013 оноос мундаг хэрэгжүүлээд эхэлнэ гэдэгт ч мэргэжилтнүүд итгэж чадахгүй байна. Тухайлбал, уг хуулийн дагуу 2013 оноос төсвийн алдагдал ДНБ-ий хоёр хувиас хэтрэх ёсгүй. Гэтэл өмнөх жилүүдэд нь төсвийн алдагдал өндөр байсан учраас 2013 оноос энэхүү заалтыг хэрэгжүүлэх боломжгүйг Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч Рожер ван дэн Бринк анхааруулж, энэ нь яг л архи тамхинд автсан хүн “Маргааш гарна” гэж ярьдагтай ижил үнэмшилгүй сонсогдож байгааг хэлсэн билээ. “Санаа зовох юмгүй. Төсвийн алдагдал 2011 онд 9.8 хувьтай, 2012 онд 4.1 хувьтай гарахаар байна. Үе шаттайгаар багасахаар байгаа биз дээ? Тиймээс 2013 онд ДНБ-ий хоёр хувиас дээшгүй байлгаж болно гэж үзэж байгаа” хэмээн С.Баярцогт сайд сөрөх ажээ.

Тэгэхээр бидний өмнө ирээдүйг маш өөдрөгөөр харж буй Сангийн яам, маш муугаар зөгнөж буй Монголбанк болоод олон улсын байгууллагууд, мөн амлалтаа биелүүлж, нэр хүндээ өсгөхийн тулд улайран зүтгэж буй УИХ байна. Монголчуудын өмнө нь хэзээ ч үзээгүй үлэмж цараатай төсвийг хэлэлцэх цаг ойртсоор... ■

**-Түүхэнд байгаагүй алдагдалтай төсөв батлагдах нь ээ.
Энэ нь эдийн засагт хэрхэн нөлөөлөх бол?**



С.Оюун /УИХ-ын гишүүн/:

-2008 оноос төрийн эрх барьж байгаа хоёр нам бэлэн мөнгөний амлалт авснаас болж байхгүй юмыг амлаж, сүүлдээ төсөв ачааллаа дийлэхээ больж байна. Алаагүй баавгайн арьсыг хувааж, олон нийтийн дунд бий болоогүй бодит бус хүлээлт үүсгэж байна. Өнгөрсөн жилд иргэн тус бүрт тараасан 120 мянган

төгрөгийн тал нь Оюутолгойн урьдчилгаа байсан. Одоогийн 21 мянган төгрөг ч гэсэн Тавантолгойн урьдчилгаа шүү дээ.

Эдийн засаг халж байгаа энэ үед бэлэн мөнгө тарааж, төсвөө тэлэх нь орлогогүй, орлого багатай, ядуу хүмүүсээ хорлож байна гэсэн үг. Инфляцийн өсөлт нийгмийн ядуу хэсэгт хамгийн хүндээр тусдаг.



**Корали Геверс
/Дэлхийн банкны Монголыг хариуцсан
менежер/:**

-Монгол Улсын эдийн засаг сайхан гэрэл гэгээтэй ирээдүйтэй. Олон нийт ч эдийн засгийн өндөр өсөлтөд өөдрөг итгэлтэй байна. Гэвч эдийн засагт бүх зүйл хэт сайн байх нь бас аюултай гэж үздэг. Жишээ нь эдийн засаг халах, инфляци хэт өсөх, худалдан авах чадвар муудах зэрэг сөрөг зүйл илэрдэг.

Зардлын хувьд ихээхэн өндөр, орлогын хувьд нэлээд өөдрөг итгэл

2012 оны төсөв нь эдийн засгийг халаах магадлалтай. Монголын сайхан ирээдүйд олон зүйлийг санхүүжүүлэх шаардлага байгаа гэдэгт эргэлзэх зүйл алга. Тэгэхдээ дэлхийн эдийн засаг тодорхойгүй байгаа одоогийн нөхцөлд Засгийн газар ухаалгаар хандаж, урт хугацаанд хийгдэж чадахгүй зүйлсэд хүчин чармайлтаа үрэхээс сэргийлэх хэрэгтэй. Мөн инфляци хэт өсөх буюу төлөвлөсөн орлого орж ирэхгүй тохиолдолд зардлын төлөвлөгөөндөө өөрчлөлт хийх бэлтгэлтэй байх нь чухал.



**Х.Ганбаатар /“Монголын ажил олгогч эздийн
нэгдсэн холбооны ерөнхийлөгч/:**

Төр, засагт мөнгө хэрэгтэй болоод л энэ их мөнгийг төсөвлөж байгаа биз ээ. Үнэхээр хэрэгтэй бол төсөвлөхгүй гээд яах вэ. Харин тэр мөнгөө Монгол Улсад тулгамдаад байгаа асуудлыг шийдэхэд л зарцуулах хэрэгтэй. Тухайлбал, хувийн хэвшлийг дэмжих нь зайлшгүй тулгамдаад байгаа асуудал мөн. Өнөөдөр цалин нэмж, томоохон

хөрөнгө оруулалтад ихээхэн анхаарч байна. Энэ нь зөв л дөө. Гэвч жижиг, дунд үйлдвэрлэл, хувийн хэвшлийнхнийг орхигдуулаад байх шиг. Хувийн хэвшил хэцүүхэн л байдалд байна шүү дээ. Үүнийг хүн бүр мэдэж байгаа. Тиймээс энэ талаар тодорхой бодлогын түвшинд авч үзэж, хөрөнгө мөнгөөр дэмжээд өгөх хэрэгтэй. Тухайлбал, эдийн засаг, мөнгө санхүүгийн нэгдсэн бодлого энэ салбарт дутагдаж байна гэдгийг хэлье.



**Д.Батжаргал
/СЭЗДС-ийн захирал/:**

-7.1 их наяд төгрөгийн алдагдалтай төсөв баталж байгаа нь шууд инфляцид нөлөөлнө. Инфляцийг хөөрөгдөнө гэсэн үг. Алдагдалтай төсөв их баталж явах нь ямар хор уршигтайг дэлхийн эдийн засгийн өнөөгийн тодорхойгүй байдлаас харж болно. Грек, Испани, Итали улс олон жилийн туршид алдагдалтай төсөв баталснаас болж эдийн засаг нь хүнд байдал орлоо. Энэ нь Европын эдийн

засагт сөргөөр нөлөөлж байна.

Манай улсын хувьд бүтээн байгуулалтын олон ажлыг Хөгжлийн банкны 800 тэрбум төгрөгийн бондоор санхүүжилнэ гэсэн хүлээлттэй байгаа. Гэтэл төсөв алдагдалтай байгаа учраас Засгийн газрын бондын арилжаанд сөргөөр нөлөөлнө. Бонд авах гэсэн хөрөнгө оруулагч Засгийн газрын өр, төсвийг л нь харна шүү дээ. Тиймээс хэт өндөр алдагдалтай төсөв батлах нь бүтээн байгуулалтыг сааруулна. Эдийн засгийг ч хямрааж мэдэх юм. ■



Фотог Б.Бяма-Очир

Өрхийн төсөв

Бүсээ чангалж чаддаг гэр бүл

Э.Зоригт, Б.Энхцэцэг

Манай сэтгүүл энэ дугаараасаа эхлэн “Өрхийн төсөв” булан нээж байна. Энэ удаа Д.Эрдэнэцогтын гэр бүлийн өрхийн төсвийг сонирхлоо.

Монголд ээж нар өрх гэрийн “Босс” байдаг. Аавын цалин мөнгийг хураана мөн захиран зарцуулна. Өнөөдөр юу идэж уух, маргааш гэртээ ямар шинэ тавилга авах гээд ээжүүдийн гарт өрхийн санхүүгийн бүх эрх мэдэл оршдог гэж хэлж болно. Манай улсын хувьд өрхийн хэмжээнд тулгарч байгаа аливаа асуудалтай холбоотой шийдвэрийн талаас илүү хувийг эзэгтэй нар гаргадаг гэвэл нэг их дэгс дүгнэлт болохгүй байх. Энэ утгаар Д.Эрдэнэцогтын гэр бүлийн өрхийн төсвийг эхнэр Л.Цэцэгжаргал нь барьдаг.

Тэрбээр гэр бүлийн дөрвөн гишүүний хэрэглээндээ сарын орлого болох нэг сая орчим төгрөгийг хэрхэн хүргэх, хадгаламж яаж үүсгэх тал дээр Монголбанк, Засгийн газраас дутахааргүй төсвийн бодлого явуулна. Тухайлбал, дараа сард хэдэн төгрөг хэрэглээндээ зарцуулах буюу “Төсөв батлах” цаашлаад бусад төрлийн тогтмол бус зарлагаа тооцох /Төсвийн тодотгол/ гэсэн дараалалтай. Тэрбээр гэр бүлийнхээ нэг сарын төсвийн зарлагыг гаргахдаа 800 орчим мянган төгрөгөөр тооцдог. Гэвч энэ дүнг барьж чадалгүй сарын орлогоо тэр чигээр нь хэрэглээндээ үрээд дуусгах нь ч бий. Заримдаа хүнээс мөнгө зээлэх эсвэл хадгаламжиндаа “гар дүрэх” хэрэг гардаг. Үр хүүхдийнхээ ирээдүй болоод гэр бүлийн зорилгынхоо нэгээхэн хэсгийг биелүүлэх гэж хадгалсан цөөхөн хэдэн төгрөг нь идэж уух ойр зуурын хэрэглээнд зарцуулагдах нь гэрийн эзэгтэй Цэцэгжаргалыг хааяа бухимдуулна. Тэрбээр “Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр эдийн засаг есөөд ▶

байна гэж байгаа боловч бид “Атар” дугуй талхаа идсээр л байна. Харин ч инфляци өсөөд мөнгөний үнэ цэнэ унаж, сарын орлого маань улам л хүрэлцэхгүй талдаа болсон” гэлээ. Өнөөдөр инфляцийн түвшин хоёр оронтойтоондхүрч, Монголбанкнаас бодолгын хүүгээ өсгөөд байгаа энэ үед эдний гэр бүл мөн мөнгөний бодлогоо хатууруулахаар шийджээ. Энэ нь өрхийн гишүүдийн хэрэглээг хянах гэнэ. Тухайлбал, гар утасны нэгжийн хэрэглээг багасгах үүднээс гэрийн эзэгтэй өөрийн гар утаснаас гэр бүлийн гишүүддээ нэгж илгээж байгаа аж. Энэ арга нь үр дүнгээ

Сардаа сая төгрөгийн орлоготой гэр бүл бол Монголын хувьд дундаж түвшний айл. Гэхдээ инфляцийн галзууралтай энэ үед ийм хэмжээний орлоготой өрхүүдийн эхнэр их л ухаантай зөв хөдлөхгүй бол тун горьгүй. Жаахан бийлэгжүү загнавал хоногийн хоол ч үгүй болох санхүүгийн хямрал хаалга тогшино.

өгч байгаа талаар баяртай өгүүлж байв. Том охин Э.Уянга нь өнгөрөгч аравдугаар сард хурим хийж, бүл нэмжээ. Гэхдээ л “Хоёр идэж хоосон хонохгүй” гэдэг шиг өөр өөрсдийн хөдөлмөрлөж олсон орлогоороо амьдралаа болгож, удахгүй мэндлэх шинэ хүнээ хүлээн гурван өрөө байрандаа багтахгүй баяр хөөртэй сууцгаана.

Наймаа хийж амьжиргаагаа залгуулдаг байсан Эрдэнэцогт эхнэрийн хамт 2000 оны эхээр БНСУ-д очиж ажиллаж, амьдарчээ. Хүний нутагт барилгын туслах, айл нүүлгэх, хэвлэлийн үйлдвэрт ажиллах гээд эхнэр, нөхөр хоёрт хийж үзээгүй ажил ховор. Бага хүү Э.Ирмүүн нь ч Хан улсад төрж өсчээ. Тэд жил гаруйн өмнө эх орондоо ирсэн. Эрдэнэцогт

“Монголдоо ирээд эрхлэх ажил одохгүй хэцүү л байсан. Солонгост цуглуулсан хэдэн төгрөгөөрөө машин аваад, айл нүүлгэдэг ажил хийж үзлээ. Тэгсэн манайхан чинь соёлын тал дээр тааруу дээрээс нь таньдаг энэ тэр гээд үнэ мөнгөө тохирохгүй хэцүү юм билээ. За тэгээд хүний нутагт хийж болоод байсан юм чинь өөрийн нутагт хийж бололгүй дээ гээд барилга дээр ажиллалаа. Гэтэл ажлын нөхцөл гэж авах юм байхгүй. Хамгийн наад зах нь ажлын бээлий өгөхгүй. Дээр нь цалин бага болохоор үнэхээр хичээгээд ч хэцүү юм билээ. Ийм учраас л манай залуучуудын гадагшаа явах урсгал өнөө ч буурахгүй байгааг мэдэрсэн. Харин эхнэр маань “Нарантуул” захын хүнсний лангуунд худалдагчаар ажилд орсон. Ах нь одоогоор нэг бичил уурхай ажиллуулах санаатай зүтгээд байна” гэсэн юм. Халуун дулаан уур амьсгалтай энэ гэр бүл том охиныхоо хуримыг 10 гаруй сая төгрөгөөр хийжээ.

Гэр бүлийн хоёр хоёулаа хүний нутагт хөдөлмөрлөж мөнгөний үнэ цэнийг мэдэрсэн болоод ч тэр үү хадгаламжтай болох тал дээр бусад монгол гэр бүлээс арай өөр ханддаг. Цэцэгжаргал “Ер нь амьдрал гэдэг хэцүү шүү дээ. Хэзээ юу тохиолдохыг хэн мэдэх билээ. Тэр бүх нөхцөл байдалд мөнгө гэдэг зайлшгүй хэрэгтэй. Тийм болохоор бид хадгаламжтай байх нь хамгийн зөв. Хэрвээ би өвдвөл манай эгч мөнгөтэй юм чинь гээд найдаад сууж болохгүй. Тус тусдаа амьдралтай хүмүүс. Миний эгч мөн л бусдын жишгээр амьдрах гэж тэмцэж яваа хүн. Гэвч манай нөхцөлд мөнгөн хуримтлал үүсгэнэ гэдэг бидний түвшний амьдралтай хүмүүст хүндрэлтэй” гэлээ. Учир нь, дөрвөн хүний өдрийн хоол, унааны мөнгө мөн том охин Э.Уянгын их сургуулийн сургалтын төлбөр, бага хүү Ирмүүний цэцэрлэгийн мөнгө гээд хэрэглээ барагдахгүй, ар араасаа хөвөрнө.

Харин Эрдэнэцогтын гэр бүлийн урсгал зардалд улсаас өгч буй “Хүний хөгжил сан”-гийн 21 мянган төгрөг дээр нь оюутнуудад өгөх 500 мянган төгрөг их нэмэр болдог аж. Энэ гэр бүлийн хамгийн өндөр зарлага нь байр, ус, цахилгааны төлбөр. Ийм зардлуудад сардаа

ойролцоогоор 150 орчим мянган төгрөг зарцуулдаг. Тиймээс тэд төсөв хэмнэх хэд хэдэн арга олжээ. Тухайлбал, “Нарантуул” захаар үйлчлүүлэх. Гэрийн эзэгтэй “Би Монголд ирээд дандаа супермаркетаар үйлчлүүлдэг байсан. Харин захад ажилладаг болсноос хойш “Нарантуул”-аас бүх юмаа авдаг болсон. Захад бараа бүтээгдэхүүний үнэ харьцангуй хямд дээрээс нь чанарын ялгаа бараг байхгүй гэдгийг мэдсэн. Дэлгүүрт өндөг 280 төгрөг бол зах дээр 240 төгрөг байх жишээтэй” гэв.

Таван кг будаа, хоёр кг гурил, 10 орчим кг мах, төрөл бүрийн хүнсний ногоо нь тэдний 10 гаруй хоногийн хүнс гэсэн. Харин өдөр тутмын ойр зуурын хүнсээ базаах ажил таван настай Ирмүүн хүүд ногддог. Ирмүүн дэлгүүрээс өдөртөө хоёр талх, нэг кг нарийн боов тогтмол авдаг ажилтай.

Олж байгаагаараа болгоод хатуу нийгмийн дундаж давхаргаас чадан ядан зүүгдэж буй энэ гэр бүлийн хамгийн ойрын мөрөөдөл нь зуслангийн хаустай болох. Цэцэгжаргал “Манай Улаанбаатар арай хэтэрхий утаатай байна. Улаанбаатарт сүүлийн үед өндөр барилгууд сүндэрлээд байгаа ч хотын өнгө үзэмж дээрдэхгүй байна шүү дээ. Тийм болохоор зуслан гарч амьдармаар санагддаг” гэж ярьсан юм. Харин энэ мөрөөдлөө биелүүлэхэд мөнгө чухал тул эднийх өдөр тутмын хэрэглээний зардлаа багасгах тал дээр бодож боловсруулсан бодлого төлөвлөгөө цөөнгүй. Бенжамин Франклин “Олсноосоо бага зар” гэж хэлсэн байдаг.

Сардаа сая төгрөгийн орлоготой гэр бүл бол Монголын хувьд дундаж түвшний айл. Гэхдээ инфляцийн галзууралтай энэ үед ийм хэмжээний орлоготой өрхүүдийн эхнэр их л ухаантай зөв хөдлөхгүй бол тун горьгүй. Жаахан бийлэгжүү загнавал хоногийн хоол ч үгүй болох санхүүгийн хямрал хаалга тогшино. Энэ гэр бүлийн сангийн сайд нь нэлээд хатуу чанга. Шаардлагатай үед бүсээ чангалж чаддаг эзэгтэй. Сангийн сайдын тогтоол шийдвэрийг нь өрхийн гишүүд нь ч үг дуугүй дагаж, ажил хэрэг болгож чаддаг гэсэн шүү. ■

Татвар

Экспортын татвар эдийн засгийг эмчилнэ

Б.Баяртогтох

Манай улсын уул уурхайн салбараас олборлож буй бүтээгдэхүүн бараг бүхэлдээ гаалийн татваргүй хил давж байгаа гэж хэлж болно. Монголын ашигт малтмалын экспортыг энэ онд нүүрс өнгөлж байна. Харин дотоодод үйлдвэрлэсэн арьсан цүнх, гутал, ноолууран бүтээгдэхүүнд Ази, Европын зах зээлийн аль аль нь ашигт малтмал шиг нээлттэй биш. Манай экспорт сүүлийн жилүүдэд тоон утгаараа хурдацтай өсөж байгаа хэдий ч чанарын хувьд төдийлөн ахиц дэвшил харагдахгүй байгааг мэргэжилтнүүд учирладаг. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүнээс нүүрс, зэс, төмрийн хүдэр, жонш гээд тодорхой тооны металлын экспортын харгуй тодхон зураих ажээ. Монгол Улсын нийт экспортыг аваад үзэхээр эрдэс баялгийн бүтээгдэхүүн бараг 80 хувийг эзлэх болсон. Гадаад худалдааны баланс уул уурхайн түүхий эдээр хэт төрөлжиж байгаа нь сайн хэрэг ч түгшүүртэй гэдгийг Монголбанкны Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн дарга С.Болд хэлсэн.

Ийн уул уурхайн бүтээгдэхүүний экспорт гэрлийн хурдаар өсөж байгаад баярлаад суугаад байж таарахгүй. Учир нь, ашигт малтмалын гадагшаах урсгалыг өнгөлөх болсон нүүрс л гэхэд нийт экспортын 40 хувьд хүрч байх жишээтэй. Гэтэл экспортод жин дарж буй уул уурхайн гол нэрийн бараа, бүтээгдэхүүнд гаалийн татвар байхгүй байна. Эсвэл нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэргээд дэлхийд тоогдсон эрдсүүд Монголд арвин нөөцтэй учраас экспортын татвар хэрэггүй юм уу? Эрэлт үүсэхээр нийлүүлэлт хомсдож, үнэ өсдөг. Харин зэс, нүүрс, төмрийн хүдэр эх нутагтаа ийм хямдхан, үнэ цэнэгүй баялаг аж. Гэтэл баялагтай орнууд гадагшаа гаргадаг бараа бүтээгдэхүүндээ экспортын татвар

гэж эдийн засгийн том хөшүүрэг хэрэглэдэг. Тэрхүү экспортын татвар нь эх орондоо ахиу орлого авчраад зогсохгүй импортлогчдыг шаардлагатай үед сүрдүүлж бас айлгаж болдог “илд бамбай” нь юм. Хойд хөрш өнгөрсөн хавар нефтийн бүтээгдэхүүний экспортоо гэнэт зогсоож, шатахуун импортлогч

барааныхаа гаалийн тарифаа тэглэсэн нь бодит амьдралд нийцэхгүй гэдэг нь харагдаад удлаа. Хөрөнгө оруулагчдын Монголд үйл ажиллагаа явуулах сонирхлыг экспортын татваргүй орчин нь илүү татдаг байж ч болох.

Экспортын ашигт малтмалаа ямар ч татваргүй хил давуулчихдаг



орнуудыг тэвдүүлсэн. Үүнд манайх бэлэн байгаагүй. Цочирдсон, бүр хүнд цохилтод орсон. Ийнхүү тэвдэж, төөрөлдөж суухдаа нүүрсээ нэрээд шингэн түлш үйлдвэрлэх боломж, бололцоог гэнэт л эрж хайсан.

Байгалийн баялгаа татваргүй экспортолсоор байх уу, Монгол Улс. Тэгсэн мөртлөө улсын төсөв нь алдагдалтай, дэд бүтцийн салбар нь ядруухан, иргэдийнх нь амьдрал тарчигхан, инфляци өндөр, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үнэтэй.

Ноолуурмэтийн зарим экспортын

хэрэг үү гэсэн асуултын хариуг олохыг хичээлээ. Гаалийн ерөнхий газраас гаргасан тоон мэдээлэл дотроос уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хураамжаар улсын төсөвт 40 гаруй тэрбум төгрөг төвлөрүүлсэн байхыг олж үзэв. Нүүрсний нэг тонн тутмаас 1500 төгрөгийн, бусад уул уурхайн бүтээгдэхүүний тонн тутмаас 1000 төгрөгийн хураамж авдаг журмаар дээрх хэмжээний мөнгийг улсад төвлөрүүлжээ. Эндээс эх орныхоо баялгийг үнэхээрийн харамлах, харамсах сэтгэл төрснийг нуух юун. Монголын ашигт малтмал бараг ▶

зүгээр шахуу л хил давж байна шүү дээ.

ОХУ шиг нефтийн бүтээгдэхүүнийхээ экспортын татварыг байнга нэмдэг биш юмаа гэхэд зарим бүтээгдэхүүний экспортын татварыг сайн нэмээд өгөхөд буруу нь юу байна вэ. Манайх ДХБ-ын гишүүний хувьд бусад оронтой хийх худалдаандаа уян хатан хандах, экспортоо дэмжих гэх мэтчилэн экспортын татварыг хэн нэгний санал санаачилгаар ч юм уу, дур зоргоороо нэмж болохгүй гэрээ байдаг л даа. Сангийн яам болон бусад холбогдох байгууллагынхан дээрх шалтгааныг учирлах нь бий. Гэхдээ нүүрс мэтийн дэлхийд эрэлт хэрэгцээ ихтэй бүтээгдэхүүндээ өнөөдрийнх шиг арай ч нэг тонн тутмаас 1500 төгрөгийн хураамж аваад сууж таарахгүй. Албаныхны хэлж байгаагчлан уул уурхайн бүтээгдэхүүнээс олж байгаа хэдэн "ногоон"-доо сэтгэл цадаад суумааргүй байна. Учир нь, манайх уул уурхайн бүтээгдэхүүнээ өмнөхөөс их хэмжээгээр экспортолж байгаа боловч түүхий эдийн зориулалтаар дэлхийн зах зээлийн ханшаас хамаагүй хямд үнээр гаргадаг.

Гэтэл ард нь байгаль экологи нөхөн сэргээлт дээд зэргээр хийгээд ч эргэж анх байсан шигээ эрүүл, үзэсгэлэнт төрхөндөө хэзээ ч орохгүйгээр сүйдэж байгаа шүү дээ. За нөхөн сэргээлтийн асуудлыг бүр орхиё гэхэд ашигт малтмалын хураамж авсан нэр зүүж байгаа үйл ажиллагаагаа арай чангатгаж, татвар болгож 40 тэрбум биш, 400 тэрбумыг олдог больё л доо. Төсвийн орлого нэмэгдэхэд дургүй улс орон гэж байхгүй шүү дээ. Улсад тийм их татварын орлого онцын хэрэггүй юм бол шууд л Нийслэлийнхээ зам харгуйг засах, хог шороог цэвэрлэх бүтээн байгуулалтын ажилд зарцуулбал бодит үр дүн харагдаад сайхан л байна байх. Адаглаад л нийслэлчүүд маань хоёр хөршийнхөө иргэдийн адил сайхан замаар давхиж, хог шороогүй цэмбийсэн хотод амьдарч үзмээр байна шүү дээ. Тэгвэл ядаж л "Уул уурхайн орлого нэмэгдэхэд хотын замыг ийм гоё болгож, хоггүй болгосон юм" хэмээн өөр хоорондоо болон үр хойчдоо бахархан ярих нэг ч гэсэн юмтай байа л даа.

Ажил хариуцсан албаны хүмүүс бүгдээрээ уул уурхайн бүтээгдэхүүний экспортын татварт дургүй юу гэвэл, үгүй. Тухайлбал, Гаалийн ерөнхий газрынханд зөв санал, санаачилга гаргасанд нь талархах хэрэгтэй байх. Тус байгууллагын холбогдох хүмүүс зарим бүтээгдэхүүнд экспортын татвар тавих тухай хуулийн төсөл боловсруулж, Сангийн яаманд хүргэсэн боловч харамсалтай нь дэмжигдээгүй байна. Уг нь бол Сангийн сайдаар ахлуулсан Гаалийн тарифын зөвлөл экспортын татвартай болох асуудлыг хэлэлцэж, Засгийн газар, УИХ-д хуулийн төслийг өргөн барих бүрэн эрх, үүрэгтэй юм билээ.

Гаалийн ерөнхий газраас боловсруулж холбогдох байгууллагуудад хэдэн сарын өмнө хүргэсэн "Зарим бараанд экспортын гаалийн ялгавартай тариф тогтоох тухай хуулийн төслийн үзэл баримтлал"-д экспортын гаалийн тарифыг ерөнхийд нь "0" байлгаж, стратегийн ач холбогдол бүхий зарим бараанд экспортын татвар тогтоох. Өөрөөр хэлбэл, дээрх хуульд ямааны боловсруулаагүй ноолуур, модон бэлдэцийг нэмэх. Түүнчлэн маш бага үнээр гадагш гарч байгаа мөртлөө Монгол Улсын нийт экспортын тал шахам хувийг эзэлж байгаа уул уурхайн эрдэс бүтээгдэхүүнд экспортын гаалийн ялгавартай тарифыг татвараас

зайлсхийх боломжгүй байдлаар тогтоох шаардлагатай байна" гэжээ. Дээрх төслийг Сангийн яаманд нэг биш удаа хүргүүлсэн ч дэмжигддэггүй байна.

Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтсийн дарга Ж.Ганбатаас энэ талаар лавлахад, "Манайх Дэлхийн худалдааны байгууллагатай байгуулсан гэрээгээ мөрдөх ёстой. Ер нь татварын реформ хийж, үүгээрээ дамжуулан экспортын татвартай болох шаардлага бол бий. Уурхайгаас түүхий нүүрс зөөхөд тийм ч их өндөр зардал гарахгүй шүү дээ. Тиймээс энэ оны төсвийн орлогыг бүрдүүлэхээр нүүрсэнд татвар тогтоох санал оруулсан боловч батлаагүй. Экспортын татвар бол эдийн засгаа дэмжих маш том тулгуур" хэмээн хэлсэн.

Экспортын гаалийн албан татвар бүхий барааны жагсаалтыг дор хүснэгтээр сонирхууллаа. Тэмээний боловсруулаагүй эр, эм ноос, ямаа, ишигний боловсруулаагүй арьс, бөөрөнхий мод, гуалин гэх мэт 4-5-хан тооны түүхий эдийн экспортод татвар ногдуулдаг байгаа. Өөр нэг жишээ татахад экспортын татварын бодлогоор өөд нь татаж, өндөр амжилт гаргаж болох салбарт мал аж ахуй, тэр дундаа ноос, ноолуурын үйлдвэрлэл орох учиртай. Монгол ноолуур дэлхийн брэнд болоход тун ойрхон байгаа. Тэгвэл уг бүтээгдэхүүний дэлхийн

Экспортын гаалийн албан татвар бүхий бараа

д/д	Түүхий эдийн	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
1	Тэмээний ноос /эр/ боловсруулаагүй	кг	100
2	Тэмээний ноос /эм/ боловсруулаагүй	кг	200

д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
1	Бөөрөнхий мод, гуалин	шоо метр	150000
2	Дүнз	шоо метр	150000
3	Зүсмэл материал	шоо метр	150000

Эх сурвалж: ГЕГ

Зах зээлийг тэлэх, тогтвортой болгох бодлогод мөн л түүхий эдийн экспортын татвар сайн нөлөөтэй нь дамжиггүй.

Экспортын татвар тавьснаар дэлхийд чанараараа гайхуулдаг ноолуураа зөвхөн урд хөршдөө түүхийгээр нь нийлүүлээд байх биш, өндөр чанартай, өрсөлдөх чадвар сайтай үндэсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд анхаарах шаардлага бий. Дээрх экспортын татвар ногдуулдаг гарын таван хуруунд багтаах түүхий эдийн дотор ноолуур байхгүй байгаа. Манайх 2008 онд боловсруулаагүй ноолуурын экспортын татвар болох 4000 төгрөгийг УИХ-ын шийдвэрээр тэглэсэн билээ. Дэлхийн зах зээл дээр ноолуурын үнэ унасантай холбоотой малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор гаргасан дээрх төрийн түшээдийн шийдвэр нь дэмжлэг гэхээсээ илүүтэй сонгуулийн шоу байсныг хүмүүс мартаагүй л байх. Бодлогогүй шийдвэрийн балгаар дотоодын зах зээлээс бэлтгэсэн нийт ноолуурын бараг 80 хувь нь урд хөрш рүү урссаар. Эцэст нь үндэсний үйлдвэрүүд түүхийн эдийн хомсдолд орж, захиалгат бүтээгдэхүүнээ үйлдвэрлэхийн тулд Хятадаас ноолууран утас худалдан авахад хүрсэн. Хэрвээ төр, засгаас ноолуурын экспортын татварыг тэглэх биш, арай өөр эдийн засгийн хөшүүрэг хэрэглэсэн бол ямаагаар баян Монголын үндэсний үйлдвэрийнхэн өрсөлдөгчийнхөө өмнө арай ч тэгж муухай царайлахгүй байх байсан биз. Бохир болон угаасан ноолуурт экспортын татвартай болсноор улсын төсөвт жилд 10 гаруй тэрбум төгрөгийн орлого сул орж ирэх боломжтойг УИХ-ын гишүүн, Монголын ноосноолуурын холбооны тэргүүн Д.Ганхуяг тэмдэглэсэн юм. Тэрбээр ноолууранд экспортын татвар тавих, хуучин экспортын татварыг ч сэргээх талаар ярьсан.

Өөрөөр хэлбэл, уул уурхайн бүтээгдэхүүн болон мал аж ахуйн гаралтай экспортод ахиу жин дардаг түүхий эдийн хувьд татвартай болгох нь чухал байна гэдгийг мэргэжилтнүүд ярьж байна. Эцсийн бүтээгдэхүүний экспортын хувьд гадагшаах урсгалыг нь төрийн бодлогоор дэмжих нь мэдээж.

Монголын баялгийг бас онцлогыг илэрхийлэх түүхий эдийн экспортод татварын чанга бодлого явуулах нь нүүрсний ч бай, ноолуурын ч бай салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, улмаар аж үйлдвэр, ажил эрхлэлтэд ч сайн нөлөөтэй

байх билээ. Нөгөө талаасаа Манай нүүрс, ноолуурын экспортын ганц зах зээлийн хэт хамаарлыг хязгаарлахад ч тустай байх болов уу. Нэг үгээр хэлбэл, экспортын татвар эдийн засгийг эмчилнэ. ■



Азийн хөгжлийн банкны 20 жилд

Монголчуудын тулганд гал ноцоосон “ачтан”

Азийн хөгжлийн банк. Энэ нэрийг сонсох бүрийдээ бид тэвдэж явсан эдийн засгийн хүндрэлтэй он жилүүдээ санадаг. Ядуурал, ган зуд, эрчим хүчний хомсдолтой гээд цөөнгүй бэрхшээлийг монголчууд даван туулахад тэд ямагт хамт байсан. Өдгөө зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн арвин баялгаараа дэлхийн шинэ од болоход ч энэ байгууллага биднийг орхисонгүй. Хамтдаа Азийн Монголыг Дэлхийн Монгол болгохоор явна. Үүний нэг илэрхийлэл нь АХБ-наас өнгөрсөн онд Улаанбаатар хотын Нийтийн тээврийн мэдээлэл, харилцаа холбооны технологийг сайжруулахад 500 мянган ам.долларын төсөл хэрэгжүүлсэн явдал юм. Энэ мэтчилэн хамтын ажиллагаа тэлсээр.

Өнөө жил Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын хамтын ажиллагааны 20 жилийн ой, Монголд Азийн хөгжлийн банкны Суурин төлөөлөгчийн газар байгуулагдсаны 10 жилийн ой тохиож байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Сорил бүхнийг боломж болгох дараагийн 20 жилийн хамтын ажиллагаанд амжилт хүсье” хэмээн Азийн хөгжлийн банкны ойн дээд хэмжээний уулзалтын үеэр онцолж байв. Энэ нь ирэх 40 жил, цаашаа үргэлжлэх 50, 100... жилийн түншийн харилцаанд итгэлтэйгээр амжилт хүссэн хэрэг.

“Монгол Улс 20 жилийн өмнө Азийн хөгжлийн банкинд гишүүнээр элсэх үед эдийн засгийн хувьд сүйрлийн ирмэгт тулсан байв. Хуучнаар Зөвлөлт Холбоот улсын санхүүгийн дэмжлэг үгүй болсноор ▶

Монголын иргэд өвлийн цагт халаалтгүй өнжих зэрэг бараан нөхцөл байдал бүхий амьдралын тодорхойгүй байдалтай тулгарч байсан” хэмээн АХБ-ны дарга, Зүүн Азийн газрын дарга Клаус Герхойзер Монголын эдийн засгийн хөндүүр цаг үеийг дурссан билээ. Тэрбээр “Монгол Улсад тулгамдсан томоохон асуудлууд байгаа хэдий ч 1991 онтой харьцуулахад Монголын эдийн засаг дэлхийн бизнесийн үүд хаалгыг тогшсон, илүү хүчирхэг, илүү бат бөх болжээ” хэмээн тэмдэглэсэн.

АХБ-ныхан манайд өгсөн тусламжийн хөтөлбөртөө хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд “Монголын эдийн засаг, нийгмийн өндөр үзүүлэлтүүдэд зохих хувь нэмрээ оруулсан” гэсэн зэрэг дүгнэлт гарчээ. Өөрөөр хэлбэл, тус байгууллагын монголчуудад өгсөн зээл, тусламж иргэн хүний амьдралд ажлын байр болж, нийгмийн хангамж, үйлчилгээ, аятай таатай орчин бий болох хэлбэрээр бодит зүйлд зориулагдсан байна. Тэд өнгөрсөн 20 жилийн хугацаанд эрүүл мэнд, аж үйлдвэр, харилцаа холбоо, эрчим хүч, боловсрол, хөдөө аж ахуй, тээвэр гэх мэт хүний хэрэгцээ болсон, нийгэм эдийн засгийн голлох салбарыг хөгжүүлэхээр манай улсын Засгийн газартай хамтран ажиллаж ирсэн билээ. Ирээдүйд үргэлжлэх он жилүүдэд дэлхийд данстай энэ байгууллага Монголд ямар олон баяртай үйл явдал, үр дүнг авчиргахыг таашгүй.

АХБ-ны ерөнхийлөгч Харухико Курода өнөөдөр Монгол Улсын ирээдүй гэрэл гэгээтэй харагдаж байгаа боловч эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлж, хөгжлийн ач тусыг бүх иргэддээ хүргэх нь чухал. Эдийн засгийн өсөлт чухал шаардлагатай хэдий ч үр өгөөжийг нь хүн амд тэгш хүртээхийн тулд илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэйг зөвлөлөө

Түүний энэ удаагийн айлчлал Монголын нийгэм, эдийн засагт олон боломжийг нээнэ гэдэгт улс төр, эдийн засаг, нийгмийн салбарынхан итгэлтэй байсан.

Манай улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2004 онд 638 ам.доллар байсан бол энэ тоо өнгөрсөн оны байдлаар гурав дахин

өсөж, 2200 ам.долларт хүрчээ. Цаашид АХБ нь манай улсын орон нутгийн дэд бүтэц, эрчим хүчний салбарт үзүүлэх тусалцаагаа сэргээн, тэргүүлэх салбарын тоонд оруулах зорилгоор Засгийн газраас удахгүй батлах эрчим хүчний мастер төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлэхээр болжээ. Эрчим хүч гэдэг үйлдвэрлэл хөгжих, ажлын байр нэмэгдэх, дэд бүтэц хөгжих “амин дэм”. Азийн хөгжлийн сангаас өнгөрсөн хугацаанд 172.2 сая ам.долларын буцалтгүй тусламжийн 12 төслийг баталсан нь үүнийг илэрхийлж буй хэрэг юм. Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээс эхлээд үндэсний үйлдвэрээ өөд нь татах хэмжээний зээл, тусламжийг бидэнд харамгүй өгсөөр ирсэн, тэд.

АХБ нь 1966 онд байгуулагдсанаас хойш өдгөө 67 орныг эгнээндээ нэгтгэжээ. Үүнд бүс нутгийн 48 орон багтдаг. Тэдний нэг нь Монгол Улс. Сангийн сайд С.Баярцогт АХБ-наас зөвхөн бага хэмжээний хөнгөлөлттэй зээл авдаг байсан үеийг “төгсгөж”, дараагийн шатны хамтын ажиллагааны хэлбэрт шилжих шинэ цагийн дохио ирснийг дуулгав. Тэрбээр, нэн тэргүүнд нефть, нефтийн бүтээгдэхүүний зуун хувь импортын хараат байдлаас гарах зорилгоор хүрэн нүүрсийг хийжүүлэх том хэмжээний төслийг АХБ, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналтай

байгаагаа илэрхийлсэн.

Монголын Засгийн газрын эдийн засгийн нэг хөшүүрэг, итгэж болох түнш нь АХБ. Эдийн засгийн хямралын жил иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад манай улсад гурван сая ам.долларын буцалтгүй тусламж олгосон байх жишээтэй. Энэ үед дэлхийн санхүүгийн төв болох АНУ хүртэл бүсээ чангалж байж. Дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкууд хаалгаа барьж, зарим нь хөрөнгийн дутагдалд орж байв. Монголд гар сунгах олон улсын байгууллага, улс ховор байсан цаг үе. Бараг л амь, амиа бодохоос аргагүй нөхцөл байдал үүсчихсэн байлаа. Эдүгээ монголчууд эрс тэс уур амьсгал, дотоодын зах зээлийн хэмжээ, хүний нөөцийн хязгаарлалт, дэд бүтцийн сул дорой хөгжил, авлигал, хууль эрх зүйн орчны асуудалтай тулгарч байна. Үүнээс гадна, тээвэр болон эрчим хүчний салбарын зохицуулалтын орчин нь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зорилгод хүрэхэд хамгийн том саад болохыг АХБ-ныхан хэллээ. Эдийн засгийн хамтын ажиллагаа улам батжиж шинэ шатанд гаргах нь АХБ-ны зорилтоос тодорхой харагдана. Монголчуудын тулганд гал ноцоон, эдийн засагт илч дулаан өгсөн АХБ бидний маргаашийн сайн сайхны төлөө ажилласаар. ■

Монгол Улсад АХБ-ны олгосон нийт зээл /2010 оны арванхоёрдугаар сарын 31-ний байдлаар/



Эх сурвалж: АХБ



Д.Энхбатын булан

Дэлхийн “бохир” аварга болчихлоо ... Одоо яахав?

Харамсалтай нь энэ тухай дахиад л ярих хэрэгтэй болж байна. Сингапурын “Страйт таймс” сонинд дэлхийн хамгийн бохир агаартай хотуудын тухай нийтлэл гарчээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанд үндэслэн гаргасан графикт Монгол Улс маань дэлхийн үнэмлэхүй “бохир” аварга болчихсон байгааг Та харж байгаа биз.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах талаар УИХ-ын тогтоол гарч, хөрөнгө мөнгө төлөвлөж, Үндэсний комисс байгуулагдан ажиллаж байгаа ч ажил туйлын урагшгүй явж байна. Сарын өмнө УИХ дээр агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сонсоход 2011 онд төлөвлөгдсөн ажил ердөө тавхан хувийн биелэлттэй явж байлаа.


Шуудхан хэлэхэд, жил бүр л бүх түвшинд яригддаг энэ асуудал өнөөг хүртэл олон яам, байгууллагын дунд орхигдсон байдалтай, олон жижиг дарга нарын мөнгө идэж үрэх бас нэгэн компант ажил байхаас нэг их хэтрэхгүй байна. Бид энэ байдлаар “ажиллаад” асуудлыг шийдэж огт чадахгүй бололтой.

Тэгээд яахав?

Ямар нэгэн томоохон асуудлыг шийдэж эхлэх хамгийн эхний алхам бол түүний төлөө персонал хариуцлага хүлээх лидерийг тодорхой болгох явдал байдаг.

Улаанбаатар хотын нэг сая иргэний эрүүл мэнд, амь настай холбоотой, нийгэм, эдийн засаг, технологийн энэ том цогц асуудлыг

Улс орнуудын агаарын бохирдол /нэг шоо метр талбайд, микрограммаар/



системтэйгээр зангидан шийдэж чадах, түүний төлөө персонал хариуцлага хүлээх ёстой хүн бол Монгол улсын Ерөнхий сайд гэж би боддог. Түүнд л энэ асуудлыг шийдэж чадах эрх мэдэл, хөрөнгө санхүү, хүн хүчний бололцоо бий.

Мэдээж, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг нэг жилийн дотор шийдчих бодит бололцоо Монголд байхгүй. Гэхдээ асуудлыг системтэй шийдэж эхлэх, агаарын бохирдлыг жил тутам ядахдаа таван хувиар багасгах замаар ахиц гаргаж явах бололцоо Засгийн газарт бүрэн бий. Үүний тулд Монгол Улсын Ерөнхий сайд хотын нэг сая иргэнийхээ өмнө маш тодорхой үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг жилд таван хувиар бууруулж чадаагүй Ерөнхий сайд огцорч байх ёстой.

Агаарын бохирдлыг жил тутам дээрх хэмжээгээр бууруулж, асуудлыг 20 жилдээ багтаан шийднэ гэх нь биелүүлэхийн аргагүй

Агаарын хорт бодисын хэмжээний илэрц олон оронд 10 микрограммаас бага байна.

ДЭМБ-аас амьсгалын замын ноцтой өвчин үүсгэж болох энэхүү тоосонцрыг хамгийн ихдээ нэг шоо метрт 20 микрограммаас ихгүй байхыг зөвлөдөг.

Эх сурвалж:
Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/

том зорилт огт биш байх.

Саймон Фразерийн их сургууль, Монголын эрдэмтдийн судалгаагаар, Улаанбаатар хотын иргэдийн нас баралтын 10 хувь нь агаарын бохирдолтой холбоотой байна. Энэ бол аймшигтай тоо. Үүнийг өөрөөр томьёолон хэлбэл, иргэн таны насыг 10 хүртэл хувь богиносгох экологийн доройтлын аюултай нөхцөл Монголын нийслэлд бүрджээ гэсэн үг.

Та үүнийг зүгээр л яриад өнгөрнө гэж үү?

Иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын хамгийн наад захын шаардлагыг хангах талаар тодорхой үүрэг хүлээн ажиллаж чадахгүй Засгийн газрыг бид байлгаж байх ямар ч хэрэггүй. Чадах хүмүүс үргэлж олддог. Одоо бүгдээрээ утааны тухай биш, харин хариуцлагын тухай ярих цаг болжээ. Тоолуураа залгаж тооцоогоо цагт нь нэхэж явах хэрэгтэй болж байна даа. ■



Эдийн засагч

С.Дэмбэрэл: Баялаг бүтээгчдийн дуу хоолой болно

**МҮХАҮТ-ын дарга
С.Дэмбэрэлтэй ярилцлаа.**

-Эдийн засаг халж байгаа талаар ярих боллоо. Эдийн засагч, мөн бизнесийнхнийг төлөөлж ажилладаг хүний хувьд эдийн засаг үнэхээрийн халж байна уу?

-Өнөөдөр толгойтой бүхэн эдийн засаг халж байгаа талаар ярьж байна. Тэгвэл эдийн засаг халах гэж юу вэ? Бид хэрэгцээнээсээ давсан тийм их хэмжээний үйлдвэрлэл явуулаад байна уу? Үгүй шүү дээ, харин ч эсрэгээрээ байгаа. Эдийн засаг халаад байгаа юм бизнесийнхэнд мэдэгдэхгүй л байна. Тухайлбал, барилгын салбарынхан мөнгө хэрэгтэй байгаагаа л ярьдаг. Тэгэхээр инфляцийг тодорхойлж байгаа хэлбэр, түүнтэй тэмцэж буй арга барил учир дутагдалтай байна гэж хэлж болох. Хэрвээ эдийн засаг халсан бол бүх сектор одоо ид

арзаганаж, оволзож байх ёстой. Гэтэл өнөөдөр байдал ямар байна вэ. Бүгд л мэдэж байгаа. Гадаадын зээл, хөрөнгө оруулалт, уул уурхай дагасан их хөрөнгө оруулалт орж ирж байна. Энэхүү энгийн явагдаж байгаа зүйлийг эдийн засгийн халалт гэж үзээд байна. Тэгээд эндээсээ үндэслээд эдийн засаг дахь мөнгийг татаж авснаар мөнгөний эрэлт буурч, инфляцийг удирдаж болно гэсэн ойлголт 2006 оноос хойш явж ирлээ. Өөрөөр хэлбэл, Монголбанк бодлогын хүүг нэмэх хэлбэрээр инфляцийг хазаарлах гэж оролддог. Тэгвэл бодлогын хүүг нэмлээ гээд инфляци хоёр оронтой тооноос салсан уу. Сүүлийн жилүүдэд байнгын л арав гаруй хувьтай явж ирсэн. Ийм аргаар тэмцэх нь хоцрогдсон арга. Үүний оронд хэрэглэгч тал руугаа бэлэн мөнгө цутгахгүйгээр

үйлдвэрлэгч, бүтээгч талд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Ингэж байж л эдийн засгийн өсөлт зөв явж, инфляци буурах юм.

Мөн эдийн засаг халж байгаа болон инфляци өссөнд төрөөс тарааж байгаа Хүний хөгжлийн 21 мянган төгрөг нөлөөлж байна гэж Монголбанк үзсэн. Засгийн газар одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөн өндөр настнуудад бэлэн мөнгө тараах, тэтгэвэр тэтгэмжийг нь нэмэхээр төлөвлөсөн. Миний хувьд тэдэнд мөнгө өгөх хэрэгтэй гэж үздэг. Учир нь, мөнгөний эргэлт л нэмэгдэнэ. Манайхан нэг хэсэг бид “Солонгон” эдийн засаг руу явж байна гэж ярьж байсан. Тэгвэл бид энэ зүг явахын тулд жижиг, дунд үйлдвэрлэлээ дэмжих, уул уурхайн бус экспортын барааны хэмжээг нэмэгдүүлэх гээд олон ажил хийх ▶

▶ хэрэгтэй. Миний энэ бүх яриад байгаа зүйл бол шийдэл юм шүү. Бид энэ бүх асуудлыг зөв бөгөөд хурдтай шийдэх хэрэгтэй байна.

-Түүхэнд байгаагүй их алдагдалтай төсвийн төслийг Та юу гэж үзэж байна вэ?

-Энэ удаагийн төсвийг цэвэр эдийн засгийн үүднээс нь тайлбарлаж болохгүй. Чадах ч үгүй. Өнөөдөр манайд “Улс төрийн бизнес цикл” гэдэг ойлголт газар авлаа. Энэ нь улстөрчид сонгуулийн өмнө эдийн засгийг их хэмжээгээр тэлж өгдөг мөртлөө сонгуулийн маргааш хамгийн бага хувьд хүртэл хумьдаг. Өнөөдрийн төсөв аялманд хандагтай байна. Тиймээс энэ төсвийг шууд л сонгуульд зориулсан төсөв болно гээд дүгнэхэд буруудахгүй. Гэхдээ ерөнхий ханыг нь нураахгүйгээр доторх агуулгынх нь хувьд янзалж, байршуулж болно. Тухайлбал, Засгийн газар үйл ажиллагааны хувьд бичил бизнес эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэлийн эдийн засгийн орчныг сайжруулах хэрэгтэй. Хамгийн гол нь цэвэр өрсөлдөөн, эдийн засгийн “ардчилал” бий болгох ёстой. Харин эдгээрийг дэмжихийн тулд нөгөө инноваци буюу мэдлэгт суурилсан эдийн засгийг бүтээн байгуулах нь чухал асуудал болно. Гэтэл өнөөдөр яагаад мэдлэгтэй хүмүүс дэмжигдэхгүй байна. Энэ бүхэн асуудал юм. Экспортын хөтөлбөрүүд бэлэн болсон ч мөнгө нь байхгүй байна. Ноолуурын хэдэн төгрөг л хэрүүлтэй уруултай батлагдах байх. Яагаад өнөөдөр бусад барилга, аялал жуулчлал, үйлдвэрлэл, программ хангамжийн салбарыг дэмжихгүй байна вэ.

-Бизнесийн орчныг сайжруулах талаар нэлээд ярьж, хэлэлцэж байснаа сүүлийн үед таг боллоо. Эсвэл бизнесийн орчин сайжирчихсан, асуудалгүй болчихсон юм уу?

-Энэ тал дээр нэг тийм заримдаг ажил л хийгдчихсэн байгаа. Төрөөс бизнесийн орчныг сайжруулах жил гэж зарласан. Тухайн жилдээ жаахан ярьж байснаа жил нь өнгөрөхөөр таг болсон нь үнэн л дээ. Уг нь байнгын л ярьж, асууж, хэлэлцэж, шийдвэрлэж байх ёстой. Гэтэл сайжруулах жил гээд зарлалаа, бүх зүйл болчихсон гэж бодоод байх шиг.

Өнөөдөр бид бизнес болон бусад хүчин зүйлтэй холбогдуулан “Европ

стандарт” гэж яриад байгаа. Тэгвэл энэ стандартыг мөрдөхийн тулд юу хийх ёстойгоо тодорхойлох хэрэгтэй. Адаглаад ямар хууль эрх зүйн орчин бий болгох тал дээр анхаарах нь чухал. Өнөөдөр Засгийн газраас уул уурхайн бизнесийн орчинг сайжруулахын тулд эмх замбараагүй лицензийг цэгцлэх талаар арга хэмжээ авч байгаа. Мөн мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулахыг хичээж байна. Энэ нь томоохон компани бизнес эрхлэгчид болон бусдын нүдэнд ил байдаг бизнесийн салбарынханд нөлөөлж, үр дүн гарахын хувьд гарч байна. Тэгвэл одоо энгийн иргэдэд мэдрэгдэх, мөн далд бугшмал зүйлст нөлөөлөх хэмжээнд хүртэл авах арга хэмжээ шийдвэрүүд шаардлагатай байна

Ер нь аливаа эдийн засгийн өсөлт, бууралт, халалт явагдлаа л гэнэ. Хамгийн гол нь энэ бүхэн энгийн иргэдийн амьдралд нөлөөлөх нь чухал. Тэр үед хүмүүс “аан эдийн засаг ингэж халдаг, өсдөг, буурдаг юм байна” гэдгийг ойлгоно. Өнөөдөр манай эдийн засаг 17 орчим хувь өссөн л гэнэ. Гэтэл энэ өсөлт жирийн иргэдийн амьдралд нөлөөлсөн үү. Мөнгөн утгаар бус таны бизнес сайжирсан уу. Үүнийг мэдэхийн тулд ажлын байр нэмэгдсэн эсэх, аль эсвэл таны бизнесийн борлуулалт хэр нэмэгдсэн зэргээр тодорхойлж болно. Энэ бол хамгийн энгийн ойлголт. Өнөөдөр эдийн засгийн ойлголтуудыг маш энгийнээр ойлгодог мөн ойлгуулдаг болмоор байна.

-Өнөөдөр манай бизнес явуулж байгаа хүмүүс төрөөс яг юуг хүсээд байна вэ?

-Нэгдүгээрт, хөрөнгө мөнгө, цаг хугацааг бага зарцуулж ажиллах орчин бүрдүүлж өгөөч. **Хоёрдугаарт**, миний бизнес өсөж томрох тэр боломжийг бий болгооч өгөөч. Түүнээс биш, надад мөнгө өгөөч гэсэн хүн ховор байна. Тухайлбал, бизнес явуулах шударга, эдийн засгийн тааламжтай орчинг бий болгоод өгөөч гэж үнэн сэтгэлээсээ хүсэж байна. **Гуравдугаарт**, боловсон хүчний асуудал. Хөдөлмөрийн зах зээл, хүнээ үнэлэх нь чухал. Өнөөдөр бид уул уурхай гэж хошуураад баахан гагнуурчин ээлтгээд бусад салбараа мартлаа. Нэг хэсэг нь Оюутолгой, Тавантолгой

гээд ажиллаж амьдарч болно. Гэтэл нөгөө хэсэг нь яах вэ. Нөгөө талаас өнөөдөр ажиллах хүч буюу боловсон хүчний соёл, хүмүүжил маш муу байна. Нэг албан байгууллагад тогтож ажиллаж чадахгүй энд тэнд үсэрч очиж ажиллаад л. Тогтворгүй байдал эрсдэл дагуулдаг. Тиймээс энэ талын мэдлэг, мэдээллийг сайжруулах нь чухал байна. Мөн энэ олон компанид сэтгэл гаргаад, юу хийх ёстой талаар сэжиг гаргаад өгвөл хөгжих боломж бий. Тухайлбал, усыг эргүүлэн ашиглах, байгальд ээлтэй бизнес эрхлэх гэх мэтчилэн олон ажил хийх шаардлагатай. Энэ мэт асуудлыг хэн нэгэн сайд лекц уншаад өөрчлөхгүй. Байгаль орчин сүйдэж байгаа энэ үед эргүүлж ашиглах, хэмнэх, ашигтай ажиллах, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулахад бүх тал хамтран ажиллаж шийдэх хэрэгтэй. Үүний тулд хувийн хэвшлийнхэнд дэмжлэг үзүүлэх нь чухал.

-Байгаль орчин сүйдэж байгаа энэ үед төр, засаг, иргэдийн дунд байгальд ээлтэй хөгжлийн талаар тун бага ойлголттой байна. Та л ганцаараа ногоон сэтгэхүй, ногоон эдийн засаг гэж их ярих юм. Хэрхэн өөрчлөх вэ?

-Үнэхээр энэ талын ойлголт халдварлаагүй байна. Иргэд ч байгаль орчны асуудал болохгүй байна гэдгийг мэдрээгүй байна. Нөгөө талаас ногоон эдийн засгийг тухайлбал, БОАЖЯ-нд дангаар нь хариуцуулаад явъя гэхээр энэ ойлголт тухайн байгууллагын хувьд ердөө нэг салбарын жижиг асуудал болоод хувирчихна. Өнөөдөр ногоон эдийн засгийн гол зарчим юу вэ? Мэдээж “Таван хорийн зарчим”. Энэ зарчмаар ногоон эдийн засаг нь Сангийн яамтай шууд холбоотой. Уг зарчимд ногоон худалдан авалтыг 20 хувь болгох заалт орсон. Тэгэхээр Сангийн яамтай холбоотой асуудал болно. Тиймээс ганцхан БОАЖЯ-нд даалгаж болохгүй юм. Одоо дотоодын нийт бүтээгдэхүүн өслөө гээд л баярлаад байна. Гэтэл энэ бүтээгдэхүүн үнэхээрийн чанартай байж чадаж байна уу? Хариуг олох ёстой. Эхлээд чанар гэж юу вэ гэдэг асуултад хариулах хэрэгтэй. Энэ ойлголт нь нөгөө л байгаль орчинд ээлтэй, эрүүл мэндэд хор нөлөөгүй гэсэн ногоон хөгжилтэй холбогдоно. Тэгэхээр ногоон хөгжил ▶

► нь бүх салбар хоорондын уялдаа холбоо юм. Олон судалгаанаас харж болно. Манай орны хувьд байгаль орчны доройтол газар авсан. Эрүүл мэндийн хувьд архаг таван өвчин хүн амын 90 хувийг зовоож байна. Ой мод устаж цөлжилт ихэссээр. Гарц нь юу байх вэ. Ногоон эдийн засаг гэдэг ойлголтыг яаралтай ажил хэрэг болгох нь л хамгийн чухал ач холбогдолтой.

Өнөөдөр монгол хүн бүр Засгийн газар ч тэр байгалиасаа л аваад байгаа боловч өгөхгүй байна. Төр татвар авах замаар их мөнгө олдог мөртлөө байгальдаа эргээд хөрөнгө оруулалт хийхдээ маш бага 10 хүрэхтэй үгүйтэй хувийг зарцуулдаг. Энэ бүхний ард маш чухал нэг асуудал дутагдаад байна. Энэ нь бидний хамгийн сайн мэдэх тогтвортой хөгжил болоод олон талын оролцоо юм. Гэтэл өнөөдөр байдал эсрэгээрээ байна шүү дээ. Тиймээс л бид хөгжихгүй байна. Дээрх хоёр ойлголтыг нэгтгэвэл “Ардчилсан өсөлт” гэдэг шинэ ойлголт гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдөө эзэн нь байж баялгийг бий болгоно гэсэн үг. Ийм баялаг л ирээдүй хойч үеийнхэнд ашиг тусаа өгнө. Сонгууль ойртож буй өнөө үед Засгийн газар энэ талын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрэгжүүлэхийн тулд олон орны туршлагаас судлах ёстой.

-Сонгууль гэснээс Та улс төрд орох алхмаа хийж, Иргэний зориг намыг сонгосон. Яагаад?

-Би өнөөг хүртэл, өнөөдөр ч ингэх тэгэх хэрэгтэй гээд л их зүйл ярилаа шүү дээ. Ярьсан зүйлс маань амьдралд хэрэгжихгүй болохоор өөрийн ярьснаа ажил хэрэг болгохын тулд яалт ч үгүй улс төрд орох шаардлага гарч ирлээ. Миний өмнөөс хэн нэгэн юу ч хийж өгөхгүй. Би энд яриад суугаад байж болно. Тодорхой шийдвэр гаргахгүй бол хэрэггүй л болно биз дээ. Энэ бол улс төрд орох шалтгаан. Тэгээд л либерал үзэлтэй Иргэний зориг намд элссэн. Би 1990 онд либералчлах, либерал үзлийг анхлан Монгол Улсад дэлгэрүүлж байсан цөөхөн хүний нэг. Тухайн үед би МҮДН-ын суурь болсон Үндэсний шинэ дэвшилт холбоо, либерал үзлийг сурталчилдаг эдийн засгийн клубчдын анхны гишүүн байсан. Энэ үзэл нь хувь хүнд эдийн засгийн болон улс төрийн эрх чөлөөг дээд зэргээр хангаж өгөх, харин

төр эдийн засагт хязгаарлагдмал бөгөөд үр ашигтай оролцох явдал юм. Энэхүү үзэл бодлоо дагаж, сонголтоо хийсэн. Иргэний зориг нь Лондон хотноо болсон либерал интернациональ чуулганаас албан ёсны гишүүнчлэлээ авсан, мөн нийгэмд намын хатуу гишүүнчлэлээс татгалзах талаар анхлан дуугарч дэвшил хийсэн нам. Одоо дарга нар нь намын хатуу гишүүнчлэлгүй болгохоор хууль санаачлаад явж байна.

-Та сүүлийн үед ногоон үзэл бодлыг түлхүү баримталж яваа биз дээ?

-Энэ хоёр үзэл бодол хоорондоо таарахгүй гэсэн ойлголт байхгүй. Харин ч таарна. Хэдэн жилийн өмнө би органик гэдэг ойлголтыг ярьж эхэлсэн. Өнөөдөр бараг бүх хүн энэ үгийг хэрэглэж байна. Телевизийн реклам хүртэл их ашигладаг болжээ. Яг л үүнтэй адилхан хэдэн жилийн дараа ногоон үзлийг, либерал үзэл бодолтой найрамдуулсан аль аль талыг нь хамарсан ойлголт гарах байх. Иргэний зориг нам ч ногоон үзэл баримтлалыг ярьж хэрэгжүүлдэг. Тиймээс миний бие иргэдэд байнгын өвчнөөр өвдөж, байгаль орчин бохирдож яваад санаа зовниж явдаг учраас дуу хоолойгоо нэгтгэхийн тулд ийм шийдвэр гаргасан.

-Танд Ардын нам, МАН-ынхан санал тавьж байсан шүү дээ? Энэ хоёр том намд орох боломж байсан байх?

-Санал ирдэг байсан. Гэхдээ би энэ намуудад хэзээ ч элсэхгүй нь тодорхой байсан. Яагаад гэвэл би эдгээр намд юм горьдож, албан тушаал царайчилсан байдлаар явж суудал бөглөхийг хүсээгүй. Энэ хүүсэл, мөн өөрийн үзэл бодол, найз нөхдийнхөө зөвлөгөөгөөр сонголтоо хийсэндээ баяртай байгаа.

-Улстөрчдийн туршлагаас харахад хийж бүтээхийн тулд улс төрд орж байна гэж ярьдаг. Та ч мөн тэгж ярьж байна л даа. Тэгээд УИХ-ын гишүүн болоод л сураггүй болж, эсвэл үзэл бодлоосоо урвах нь бий?

-Энэ нь бидний төлөвшсөн үзэл бодолгүйгээс шалтгаалдаг. Юу хийх ёстой гэдгээ мэдэхгүй. Гэхдээ мэдээж хаа ч гэсэн үзэл бодлын зөрчил гарна. Харин аль нь зөв гэдгийг мэдэх хэрэгтэй. Өнөөдөр УИХ-ын гишүүн гэдэг угтаа ард

түмний гүүр байх ёстой. Ганц хүний ашиг сонирхол биш олон түмнийг хамарсан зөв зүйл ярих, түүнийг ажил хэрэг болгохын төлөө зүтгэж байгаа цагт тухайн хүнийг нэг их үзэл бодлын зөрчилтэй этгээд гэж хэлэхгүй байх. Бас юм хийхгүй байна ч гэж хэлэхгүй. Эдийн засаг, улс төрийн эрх чөлөөг дээдэлсэн, хүмүүс нь өөрөө өөрсдийнхөө амьдралыг өөд татахад төр тэгш боломжоор хангаж өгдөг хөгжлийн загварыг хүсэж байна.

Миний хувьд Монголын бизнесийн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн эрх ашгийг төлөөлөх туршлага хуримтлуулсан, өөрөөр хэлбэл, хувийн хэвшлийнхний жаргал зовлонг мэдэрдэг ойлгодог хүний хувьд засаглалд, баялаг бүтээгчдийн дуу хоолойг маш тодорхой дамжуулах чадвартай гэж өөрийгөө үзэж байна. Улс төрд орж байж санасан бодсоно хийх боломжтой юм байна, өнөөгийн манай нөхцөлд. Түүнээс бизнесийн шинэчлэл, төр, хувийн хэвшлийн түншлэл гэж хэчнээн яриад хэрэггүй байна шүү дээ. Төрд бизнесийн дуу хоолойг хүргэх үнэндээ амаргүй юм байна. Тэнд зах зээлийг ойлгодог, эдийн засгийг зөв замаар хөтлөх олон хүн хэрэгтэй байна. Тийм хүмүүстэй хамтран ажиллаж, хэтэрхий данхайсан төрийг хязгаарлах зорилго агуулж ийм зам руу орлоо. Ард иргэд зүгээр суугаад мөнгө авдаг, ямар ч хөрөнгө оруулалт хийлгүй хувьцаа эзэмшигч боллоо. Ийм нийгэм бүтээчихээд түүнийгээ зөв гээд яваад байна. Эдийн засагч, иргэн хүний хувьд ийм гажгийг хөндлөнгөөс хараад гараа хумхиад суухыг хүссэнгүй.

УИХ бол мэдлэг, туршлага бүхий хүмүүсийн өрсөлдөөний талбар байх ёстой. Өнөөдрийнх шиг төндөр хувааж иддэг, хувийн бодлоо гүйцэлдүүлэхийн төлөө дэвшдэг байдал хэвээр байвал улс төр үүнээс хойш улам бохирдоно. Энэ муу муухайг цэвэрлэхийн тулд Иргэний зориг намтай хамтарч ажиллахыг хүссэн. Гэхдээ ард иргэд улс төрийг бохир заваан гэж харахаасаа илүүтэй зөв хүнээ сонгох нь чухал юм. Гаднынхан Монгол Улсад дэндүү их анхаарал хандуулж байна. Энэ нь сайн муу хоёр талтай. Сайн сайхныг хүсэхийн зэрэгцээ Монголыг залгих гэж улайрч байна. Үүнийг ойлгодог, ухаардаг хүмүүстэй хамтарч ажиллаж, ирээдүй хойч үедээ эвдэгдээгүй Монгол орныг хүлээлгэн өгөхөд гар бие оролцохыг хүсэж байна. ■

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт**-Эдийн засаг халж байгаа юу?**

Манай эдийн засагт халалтын шинж тэмдэг илэрсэн

Б.Түвшинтөгс /Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, Монголбанкны орон тооны бус зөвлөх/:

-Эдийн засгийн халалт гэж үүнийг хэлнэ гэсэн онол байхгүй ч халалтын шинж тэмдэг бол манайд илэрсэн. Инфляци өндөр байгаа энэ үед өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөөд байвал эдийн засагт халалт үүснэ. Бэлэн мөнгө тарааж байгаа одоогийн нөхцөлд эдийн засаг халах тийшээ л явна.

Эдийн засгийн өндөр өсөлтийг шингээх үйлдвэрлэл манайд алга. Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжээд эхлэхээр үйлдвэр, үйлчилгээ нэмэгдээд эдийн засаг одоогийнхоосоо илүү өснө

л дөө. Олон улсын валютын сангийн тооцоолсноор Монгол Улсын эдийн засгийн жилийн өсөлт ирэх гурван жилийн дотор 30 хүртэлх хувьд хүрнэ гэж гарсан. Манайд хэрэгжих төслүүд том зах зээлтэй учраас эдийн засгийн өсөлт гарцаагүй авчирна. Одоо бол бид эдийн засгийн өндөр өсөлт гарна гэдэгт сохроор найдаж байна. Иргэд ажилтай болно. Ажилтай болж байгаа учраас цалинтай залгах нь мэдээж. Цалинтай учраас ядуурал буурна л гэж найдаж байна.

Эдийн засаг дахь үйл явцыг хэт халалт гэж нэрлээд байгаа

О.Чулуунбат /УИХ-ын гишүүн/:

-Зах зээлийн орны эдийн засгийн халалт гэдэг сонгодог утгаараа бол нийгэм дэх үйл ажиллагаа хэт эрчимжих, мөнгөний нийлүүлэлт эрс нэмэгдэж буй эдийн засаг дахь үйл явцыг л хэт халалт гэж нэрлээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, мөнгөний нийлүүлэлтээс үүдэн инфляцийг хөөргөдөх нь халалтын нэг шинж тэмдэг. 10-аас дээш инфляцитай үед халалтын тухай ярьдаг. Гэхдээ манайх шиг жижиг зах зээлтэй орны хувьд төдийлэн халалт хүчтэй мэдрэгдэхгүй. Тэр тусмаа барааны хангамж нь импортоос хамааралтай байгаа нөхцөлд эдийн

засгийн халалт хүчтэй үүсэхгүй. Манайд мөнгө олдог цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүн нь нүүрс, зэс, төмрийн хүдэр, ноолуур байна. Халалт ямар үед бий болдог вэ гэхээр ажлын байр нэмэгдээд, хөдөлмөрийн бүтээмж өндөр, үйлдвэржсэн, гадаад худалдаа нь далайцтай, төсөв нь их алдагдалтай болж байгаа үед эдийн засаг халдаг. Төсвийг их алдагдалтай батлах нь халалт үүсэхийн нэг гол шалтгаан нь. Ирэх оны төсвийг баримжаатай, бага хэмжээний алдагдалтай батлах санал байнга тавьж байгаа. Ер нь бол манай эдийн засаг халах тийшээ явж байгаа гэж ойлгож болно.

Эдийн засаг халаагүй

Л.Оюун /МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш/:

-Эдийн засаг хална гэдэг чинь худалдан авах чадвараас нь давсан бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэхийг хэлж байгаа юм. Ийм үед борлуулалт муудаж, үүнийг дагаад эдийн засаг хямарч, үйлдвэрийн газрууд үүд хаалгаа барьдаг. Гэтэл Монгол Улс үндэсний хэчнээн үйлдвэрлэгчтэй,

бүтээгдэхүүнийхээ хэдэн хувийг дотооддоо үйлдвэрлэж байгаа билээ. Ийм нөхцөлд эдийн засаг хэт халах зүйл байхгүй л дээ. Харин манай эдийн засаг бүтцийн доголдолтой байна. Инфляцийн өндөр өсөлт бол доголдол шүү дээ. Түүнээс эдийн засаг халаад үйлдвэрлэлийн борлуулалт сулраад байгаа юм биш ээ.

Эдийн засгийн өсөлт нь зогссон улсуудад халалт том асуудал болж мэднэ

Б.Загал /“Голомт” банкны дэд захирал/:

-Эдийн засгийн халалтыг сав гэж бодоход саванд буй ус халихыг хэлж байгаа юм. Монголын эдийн засгийн савны хэмжээ томорч байна. Тиймээс тэлж байгаа саваа эдийн засгийн өсөлттэй харьцуулах нь зүйтэй байх. Одоо эдийн засагт халалтын шинж тэмдэг байж болох ч ирэх оноос халалт биш болж

хувирна. Өөрөөр хэлбэл, одоогийн эдийн засгийн халалтыг 2012, 2013 оны эдийн засгийн өсөлттэй харьцуулахаар тийм ч сөрөг нөлөө үзүүлэхгүй болов уу. Харин эдийн засгийн өсөлт нь зогссон улсуудад халалт том асуудал болж мэднэ. Хөгжиж буй манайх шиг улсад тоон үзүүлэлтээ өнгөрсөн, эсвэл одоо байгаатайгаа харьцуулж болохгүй. Ирээдүйн хөгжилтэйгээ холбох шаардлагатай. ■

Шинжээч бичиж байна



Л.Бямба /“Purplebook.mn”-ийн шинжээч/

Өрийн хямрал Монголд хэрхэн нөлөөлөх вэ?

Том захуудын сентимент айдсаар дүүрэн байна

Энэ нь Европын зарим орны төсвийн зарлага сүүлийн жилүүдэд хэт тэлж, орлогоороо нөхөж чадахгүй болсонтой холбоотой. Улмаар алдагдлыг нөхөхийн тул эдгээр орон Засгийн газрын бонд ихээр гаргаж, дотоор өр хуримтлуулсаар нэг мэдэхэд өрөө эргэн төлж дийлэхгүй хэмжээнд хүрсэн юм. (Үйл явдлын өрнөлийг хавсралтаас үзнэ үү). Өрийн хямрал санхүүгийн захуудыг унагааж, Европын төдийгүй дэлхийн бүх захыг тогтворгүй байдалд оруулж байна.

Том захуудыг авч үзвэл:

АНУ

Обама эдийн засгаа сэргээх гэж үзээд олигтой амжилт олоогүй байж байтал дотоод өрийн асуудлаас болж өнгөрсөн наймдугаар сард S&P улсын зээлжих чадварын зэрэглэлийг нь нэг шатлалаар бууруулчихав. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулж зах зээлд том цохилт үзүүлэв. Залгуулаад еврозоны өрийн хямрал Америкийн санхүүгийн захуудын уналтыг даамжруулж байна.

Европ

Европын орнуудын хувьд Грек толгойны өвчин болсоор хэдэн сарын нүүрийг үзэв. Грекийн Засгийн газар өрөө барагдуулж чадахгүйд хүрээд байгаа нь ганц Грек төдийгүй Европын Холбоо, ОУВС, Европын Төвбанкны хувьд тун хүндрэлтэй асуудал болоод байна. Грек дампуурлаа зарлавал Европын Холбооны бусад оронд сөргөөр нөлөөлөх нь ойлгомжтой. Үүнээс гадна, Грекийн засгийн газрын бондыг худалдаж буй бүх банк, санхүүгийн байгууллага алдагдал хүлээнэ гэсэн үг. Энэ айдсаас улбаалан Европын захуудын индекс бүгд хэдийнэ доошилж, еврогийн ханш тасралтгүй унаж байна. Европын зарим орон бүр еврогоос татгалзаж эргээд үндэсний валютаа сэргээх талаар ч ярьж эхэлжээ.

Япон

Угаас дотоод өрийн хэмжээ асар өндөр байгаа дээр өнгөрсөн гуравдугаар сард болсон газар хөдлөлт зогсонги байдалд орсон байсан Японы эдийн засагт хүндээр туссан. Сэргээн босголтын ажлыг хэрхэн санхүүжүүлэх талаар одоог хүртэл олигтой шийдэлд хүрч чадаагүй байна.

Хөгжиж буй орнуудын тухайд байр суурь зөрөлдсөөр

BRIC-ийн орнуудын тухайд захууд том захуудыг дагаад уналттай байгаа хэдий ч эдгээр орны талаарх хөрөнгө оруулагчдын сентимент янз бүр байна. Тухайлбал, зарим нь дэлхийн зах зээлийн байдал тогтворгүй, таамаглахад хэцүү байгаа учир эрсдэлтэй хөрөнгө оруулалтаас татгалзаж, өгөөж хөөцөлдөхөөс илүүтэйгээр хөрөнгөө хадгалж үлдэхийг эрмэлзэж байгаа юм. Эдгээр нь хамгийн найдвартайгаар нэг бол банкны хадгаламжид бэлэн мөнгө байршуулж, нэг бол алт ихээр худалдаж авч байна. Улмаар хөгжиж буй орнуудын хувьцааны хөрөнгө оруулалтын сангуудаас зөвхөн есдүгээр сарын сүүлийн долоо хоногт л гэхэд хөрөнгө оруулагчид 2.6 тэрбум ам.доллар буцаан татсан тухай мэдээ байх юм.

Харин үүний эсрэгээр зарим нэг нь үнэ ханш буурч байгаа дээр нь хөгжиж буй орнууд руу хөрөнгө оруулалт хийх нь ашигтай гэж үзэж байна. Учир нь, эдгээр орон дэлхийн эдийн засгийн өсөлтийг хөтөлж яваа, цаашид ч хурдацтай хөгжих магадлал өндөр, үүгээрээ хөгжилтэй орнуудаас ялгаатай гэж бодож байгаа аж. Жишээлбэл, дэлхийн хамгийн том улсын тэтгэврийн сан болох 1.5 триллион ам.долларын хөрөнгө бүхий Японы улсын Тэтгэврийн хөрөнгө оруулалтын сангийн ерөнхийлөгч Такахио Митани “Энэ оны сүүлчээс эхлэн бид хөгжиж буй орнуудын хувьцаанд хөрөнгө оруулж эхэлнэ, эдгээр орны хөгжил хурдацтай байна гэдэг нь хөрөнгө оруулалтын өгөөж өндөр байна гэсэн үг” гэж хэлжээ.

Харин Монгол яах бол?


2008 оны дэлхийн санхүүгийн хямралын үеэр гаднын хөрөнгө оруулагчид мөнгөө Монголоос буцаан татсан учир санхүүгийн салбар бэлэн мөнгөний хомсдолд орсон. Энэ нь эдийн засагт нөлөөлж, ДНБ 2009 онд 1.3 хувиар буурсан байдаг. Байдал үүнээс ч илүү муудаж болох байсан ч бидний хамгийн их хамааралтай байдаг хоёр хөрш хямралд харьцангуй бага өртсөн тул гайгүй өнгөрсөн. Энэ удаагийн өрийн хямрал Монголд ямар нөлөө үзүүлэх бол? Хөрөнгө оруулагчид 2008 онтой адил мөнгөө буцаан татах болов уу? Уул нь одоогоор Японоос бусад Азийн орнуудын эдийн засгийн үндэс суурь боломжийн сайн байгаа. Тэгэхээр санаа зовох хэрэггүй ч байж мэднэ. Гэхдээ л АНУ, Европын эдийн засаг хямарч даамжирвал хөгжиж ▶

Эдийн засаг

► буй орнуудын эдийн засагт, тэр дотроо Хятадын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Наад зах нь эдгээр орны бүтээгдэхүүний эрэлт дэлхий даяар буурч өсөлт нь төдийлөн эрчимтэй явж чадахгүйд хүрнэ. Жишээ нь, “Хятад ганцаар дэлхийг аварч дийлэхгүй. АНУ, Европын эдийн

засгийн гурван хувийн уналтыг нөхөхийн тулд Хятад 18 хувийн өсөлттэй байх ёстой, энэ бол боломжгүй зүйл” гэж Дойче банкны Хятадыг хариуцсан эдийн засагч Жун Ма хэлсэн байна. Хөгжиж буй орнуудын тухайд хөрөнгө оруулагчдын санал зөрөлдөж буйтай адил Монголын тухайд ч хөрөнгө оруулагчдын байр суурь янз бүр байхаар байна. Нэг талаас ашигт малтмалын үнэ өсч байгаа өнөө үед Монголыг сонирхох хөрөнгө оруулагчид байсаар байна. Нөгөө талаас, өгөөж хэдий өндөр байж болох ч, Монгол угаасаа өндөр эрсдэлтэй орнуудын тоонд ордог. Дээр нь хөрөнгө оруулалтын дийлэнхийг татдаг гол салбар болох уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин тогтворгүй, мөн улс төрийн нөлөөлөлд автсан шийдвэрүүд гарч байгаа нь хөрөнгө оруулалтаа тэр чигээр нь алдах вий гэсэн болгоомжлолыг хөрөнгө оруулагчдын дунд төрүүлж байна. Тэгэхээр нөхцөл байдал өөрчлөгдөхгүй бол харзнах байр суурь хөрөнгө оруулагчдын дунд давамгайлж болзошгүй. Хэрэв сөрөг хандлага давамгайлбал, 2008-2009 оны дүр зураг давтагдаж ч магад. Тиймээс мөнгөний нийлүүлэлт, эдийн засгийн үзүүлэлтүүд сайн байгаагаа ашиглан тэлэлтийн бодлого явуулах бус хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч нөөц бүрдүүлэхэд анхаарах нь чухал юм. ►

Дотоод өр/ДНБ, хувь 2010 онд



Салбар	Дүн / тэрбум төгрөг	Эзлэх хувь
Хөнгөн үйлдвэрлэл	3.10	51.7%
Хүнсний үйлдвэрлэл	1.80	30%
Барилгын материалын үйлдвэрлэл	0.51	8.5%
Эмийн үйлдвэрлэл	0.03	0.5%
Бусад	0.56	9.3%
Нийт	6.00	100%

Еврогийн ханш долларын эсрэг суларсаар USDEUR сүүлийн 3 сард



АНУ-ын гол захуудын индекс, сүүлийн 1 жил: Dow, S&P500, Nasdaq



Монголд мөн адил, төгрөг чангарчээ EURMNT 4 сараас хойш



Гадаадын шууд хөрөнгө оруулалт, сая доллар



► **Үйл явдлын өрнөлийг Reuters, WSJ зэргээс шүүн үзвэл:**

2011 он

Дөрөвдүгээр сарын 6. Португал Европын холбооноос санхүүгийн тусламж хүслээ.

Гуравдугаар сарын 29. Standard & Poor's Грекийн зэрэглэлийг BB- болгож бууруулав.

Хоёрдугаар сарын 4. Герман, Франц хоёр бүс нутгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн шинэчлэлийг хийх санал тавив.

2010 он

Арваннэгдүгээр сарын 21. Ирландын Засгийн газар ОУВС болон хамгаалалтын тусламжийн сангаас 10 тэрбум евро хүсэх болсон тухайгаа зарлалаа. Үүний зэрэгцээ 15 тэрбум еврогоор төсвийн зарлагыг дөрвөн жилийн хугацаанд бууруулж төсвийн алдагдлыг 2011 ДНБ-ийн 9.1 хувьд хүргэхээр болов.

Арваннэгдүгээр сарын 12. Сангийн сайд нар 2013 оноос өмнө гаргасан бондуудад өөрчлөлт орохгүй талаар мэдэгдэв.

Есдүгээр сарын 7. Грекийн Үндэсний банк 2.8 тэрбум еврогийн санхүүжилт татах болсон тухайгаа мэдэгдэв.

Наймдугаар сарын 24. Ирландын зэрэглэлийг бууруулж AA- болголоо.

Долдугаар сарын 23. Европын банкуудын стресс тестийн дүн зарлагдлаа. 91 банкаас долоо нь хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатай нь харагдав.

Долдугаар сарын 9. Португал Засгийн газрын оруулсан багцыг баталлаа. Хамгаалалтын сангаас тусламж авахаас татгалзав.

Долдугаар сарын 7. Меркелийн хамтарсан Засгийн газар төсвийг бууруулах, татвар нэмэх хөтөлбөрийг зөвшөөрч 2012 онд гэхэд төсвийн алдагдлыг хэвийн байдалд оруулахаар болов.

Тавдугаар сарын 29. Эсэргүйцлийн жагсаал боллоо.

Тавдугаар сарын 28 Fitch Испанийн зэрэглэлийг нэг шатлалаар бууруулж AAA болгов.

Тавдугаар сарын 27. Испанийн парламент 15 тэрбум еврогийн хэмнэх багцыг ганцхан саналын давуутайгаар баталлаа.

Тавдугаар сарын 25. Италийн Засгийн газар 24 тэрбумын бүсээ чангалах хөтөлбөр баталж төсвийн алдагдлыг 2012 он гэхэд ДНБ-ийн 2.7 хувьд хүргэх зорилт тавив.

Тавдугаар сарын 18. Германы тэргүүлэх 10 банк санхүүгийн байгууллагын хувьцаа, Засгийн газрын бонд, дампуурлын своп зэргийн үнийн уналтад дээр тоглосон арилжаа хийхийг хориглов.

Тавдугаар сарын 11. Хамгаалалтын санд Германаас нэг улсаас оруулсан хамгийн том дүн буюу 123 тэрбум еврог гаргахыг Засгийн газар нь зөвшөөрөв.

Тавдугаар сарын 10. Дэлхийн бодлого боловсруулагчид Грекийн хямралыг тархаахгүйн тулд нийт 750 тэрбум еврогийн хамгаалалтын сан бүрдүүлэв. 440 тэрбум евро нь Европын орнуудаас гаргасан

баталгаа, 60 тэрбум нь зээлийн хэрэгслээс бүрдэнэ. Үүний дээр ОУВС-гаас 250 тэрбум еврог гаргахаар болов.

Тавдугаар сарын 6. Грекийн парламент бүсээ чангалах хөтөлбөрийг баталлаа.

Тавдугаар сарын 4-5. Төсвийн ажилчид 48 цагийн ажил хаялт зарлаж Афин хотноо 50 мянга орчим хүн жагсав. 3 хүн амь үрэгдсэн байна.

Тавдугаар сарын 2-3. - Жилийн хугацаанд нэмж төсвөөс 30 тэрбумын хэмнэлт гаргахыг зөвшөөрсний үндсэн дээр 110 тэрбум еврогийн тусламжийн мөнгийг хүлээн авах боломжтой болсон тухай Папандреу мэдэгдэв.

Дөрөвдүгээр сарын 27. Standard & Poor's Грекийн зэрэглэлийг бүр доош бууруулав. Дараагийн өдөр нь Испаний зэрэглэл ч буурлаа.

Дөрөвдүгээр сарын 23. Папандреу тусламжийн хөтөлбөрийг идэвхижүүлэхийг хүсэв.

Дөрөвдүгээр сарын 22. Грекийн 2009 оны төсвийн алдагдал 12.7 бус, харин ДНБ-ийн 13.6 хувь байсан тухай Евростат мэдэгдлээ.

Дөрөвдүгээр сарын 11. Евробүсийн сангийн сайд нар 30 тэрбумын тусламжийн хөтөлбөрийг баталсан боловч Грек түүнийг идэвхижүүлэхээс татгалзав.

Гуравдугаар сарын 25. Евробүсийн орнуудын тэргүүнүүд, ОУВС хамтарч Грект туслалцаа үзүүлэх талаар тохиролцов.

Гуравдугаар сарын 5. Нэмэлт 4.8 тэрбум евро хэмнэхийн тулд төрийн салбарын цалинг бууруулах, татвар нэмэх шинэ багцыг баталлаа.

Хоёрдугаар сарын 5. Тэтгэвэрт гарах насыг 65-аас 67 болгож хойшлуулах санал гаргасан боловч төр, засгийн эсрэг олон нийтийн жагсаал, эсэргүйцэл өрнөв.

Нэгдүгээр сарын 29. 50 тэрбум евро хэмнэх хөтөлбөр хэрэгжүүлэх болсон тухайгаа Испанийн Засгийн газар зарлав. Хөтөлбөрт төрийн албан хаагчдын цалинг дөрвөн хувиар бууруулах арга хэмжээ багтсан байна.

Нэгдүгээр сарын 14. 2012 он гэхэд дотоод өрийг ДНБ-ий 2.8 хувь болтол бууруулах хөтөлбөрийг Грек танилцуулав. 54 тэрбум еврогийн өрийг дахин санхүүжүүлэх бэлтгэл хийж эхлэв.

2009 он

Арванхоёрдугаар сарын 16. Standard & Poor's мөн Грекийн зэрэглэлийг BBB+ болгож бууруулав.

Арванхоёрдугаар сарын 8. Fitch Ratings Грекийн зээлжих чадварын зэрэглэлийг BBB+ рүү буурууллаа.

Арваннэгдүгээр сарын 20. Төсвийн тодруулга гаргасан бөгөөд түүнд алдагдлыг 8.7 хувь руу бууруулж төсвийн эрүүл байдлыг сэргэх талаар арга хэмжээ авч байгаа талаар тусгасан байна.

Арваннэгдүгээр сарын 5. Грекийн төсвийн алдагдал 2009 онд ДНБ-ийн 12.7 хувьд хүрнэ, энэ нь өмнө нь мэдэгдэж байснаас хоёр дахин их болохыг Папандреу зарлаж тусламж хүсэв. ■

Purplebook.mn-ийн шинжээч энэхүү нийтлэлийг өнгөрсөн аравдугаар сард бичсэн болно.

Ногоон эдийн засаг



1. “Сараана цэцгийн дэлбээ” хэмээх сонсголонтой нэртэй төсөл нь эдгээр гайхамшигийн эхэнд яах аргагүй жагсана. Хэдийгээр бодит амьдрал дээр биеллээ олтлоо удах магадлалтай боловч дурдахгүй байхын аргагүй гайхамшигтай төсөл юм. Энэхүү төслийн гол санаа нь өөрийгөө цахилгаанаар бүрэн хангадаг, хөвдөг, эко-арал барих. Үүнийг далайн хаана ч барих боломжтой бөгөөд нэг дэлбээнд 50,000 орчим хүн амьдрах боломжтой. Дэлбээний төвд байрлах усан санд далайн усыг цэвэршүүлэн хуримтлуулж, арлын усны хэрэгцээг хангана. Далайн усны түвшин нэмэгдэж зарим нэг арал, эргийн орнуудад аюул учирч байгаа өнөө үед энэхүү эко-арал нь хамгийн зөв шийдэл ч байж болох юм.

Ногоон технологи

Ногоон технологийн долоон гайхамшиг

С.Жавхлан

Сүүлийн үед дэлхий нийтээр ярих болсон “Ногоон” тодотголтой технологи нь нар, салхи гэх мэт сэргээгдэх эрчим хүч ашигладаг, байгаль орчинд хор хөнөөлгүй технологийн шийдэл юм. Дөнгөж хөгжлийнхөө шатанд явж байгаа энэхүү “Цэвэр” технологи нь бидний өдөр тутмын амьдралыг өөрчилж ирээдүйд илүү гэрэл гэгээтэй орчныг санал болгож байна. Дэлхий нийтээр байгалийн баялаг хомсдож, байгаль орчин доройтож байгаа энэ үед ногоон технологи нь нийгмийн цорын ганц ирээдүй гэдэг талаар мэргэжилтнүүд ярьж байна.

Ногоон технологийн төрлүүд

- Энерги, эрчим хүч
- Барилга, архитектор
- Байгальд ээлтэй бүтээгдэхүүн
- Хими
- Нанотехнологи гэх мэт салбаруудад ногоон технологи хөгжиж байна

2. Бахрайны дэлхийн худалдааны төвийн хамгийн гайхалтай шийдэл бол хоёр өндөр цамхагийн дунд байрлах гурван салхин сэнс юм. Тус бүр 25 метр урттай энэхүү сэнсүүд нь хоёр цамхагийг холбодог гүүрнээс гардаг. Уг хоёр цамхаг нь өөрөө агаарын урсгалыг гол руугаа чиглүүлж илүү их энерги үүсгэх боломжийг бий болгоно. Энэхүү дизайн нь одоогоор хамгийн том салхин цэнэгээр ажилладаг барилга юм.



3. Маглевийн салхин сэнс нь дэлхийн салхины энергийн салбарт хийгдэж байгаа томоохон алхам юм. Соронзон орон ашиглан сэнсний үрэлтийг бууруулснаар илүү их цахилгааныг үүсгэж чадна. Маглев сэнс нь нэлээд бага давтамжтай эргэлддэг бөгөөд хэдэн зуун жил ажиллаж 750,000 хүртэлх айлыг цахилгаанаар хангаж чадна. Хэдийгээр энэхүү төслийг хэрэгжүүлэхэд хэдэн сая ам.долларын хөрөнгө шаардах боловч үр өгөөж нь маш өндөр юм. »



4. Нарны цамхаг хэмээх энэхүү технологийн шийдэл нь яг л үлгэрт гардаг шиг өөрөөсөө гэрэл цацруулан харагдана. Европын хамгийн анхны нарны энергийг цуглуулах цахилгаан станц. Түүнийг тойрон хүрээлж буй 600 гаруй ган толинд ойсон нарны гэрэл цамхагийн нэг цэгт төвлөрч түүний дотор байрлах усыг буцалгана. Буцалсан усны уур сэнсийг хөдөлгөөнд оруулан энерги үүсгэнэ. Сонирхолтой боловч маш үр дүнтэй арга юм. Одоогоор 6,000 орчим айл өрхийг цахилгаанаар хангаад байгаа уг төслийг 2013 он гэхэд 300 орчим мегаВатт цахилгаан гаргах боломжтой болгоно хэмээн төлөвлөж байна.



5. Хотын тэнгэр баганадсан өндөр барилгууд дотор тариалангийн талбай барих санаа нь ердөө санаа төдий боловч онолын хувьд байж болох, гайхалтай санал юм. Тэдгээр тариалангийн талбайд ургасан хүнсний бүтээгдэхүүн нь хотын иргэдийн хэрэглээг бүрэн хангах боломжтой гэж энэхүү санааг гаргагч үзэж байна. Уг барилга нь нар болон борооны усыг хураах технологитой бөгөөд усалгааны үеэр ууршсан усыг дахин хураах системийг суурилуулах дахин ашиглах гэх мэт дэвшилт байгаль орчинд хор хөнөөл багатай аргуудыг ашиглан бүтээгдэхүүний гаралтыг сайжруулах боломжтой. Дэлхийн хөгжиж буй орнуудад нэгэнт дэлгэрсэн ногоон дээврийн санааг дэлгэрүүлэн тариан талбай болгоход байгуулахад хөрөнгө мөнгө маш ихээр шаардаж байна. Энэхүү шалтгааны улмаас хараахан хэрэгжиж амжаагүй байгаа боловч ирээдүйтэй санаа учир тус жагсаалтад багтжээ.



6. Дэлхийн хамгийн анхны Эко-хот болох Шанхай хотын Донгтаны эко-хот нь зөвхөн байгаль орчны хувьд ч биш, нийгэм, эдийн засаг, соёлын хувьд ч биеэ даасан хот байхаар эрмэлзэж байна. Хөдөө аж ахуйгаар хүрээлэгдсэн хөгжил энэ хотод сүндэрлэж, 130 ам.киломер талбайг эзлэн оршино. Хот бүхэлдээ салхи болон нарны энергиэр цахилгаанаа хангаж, тариалангийн талбайгаасаа хоол хүнсээ авна. Нийтийн тээвэрт явж буй тээврийн хэрэгслүүд ч мөн адил ямар нэгэн хор хөнөөлгүй байх бөгөөд ирээдүйн томоохон ногоон хотуудын анхны загвар болж өгч байгаагаараа онцлогтой.



7. Гэрэлт цамхаг хэмээх 300 гаруй метр өндөр, оффисын зорилгын барилга нь жирийн өндөр барилгын цахилгаан, усны хэрэглээний хагастай тэнцэх хэмжээний ус, цахилгаан ашиглахаар зохиогдсон билээ. Барилга нь нарны энергийг цуглуулахын зэрэгцээ суурилагдсан салхин сэнсний тусламжаар цахилгаанаа өөрөө хангах зорилготой юм. ■



Эх сурвалж: <http://weburbanist.com/>



Сэргээгдэх эрчим хүч

Фотог Э.Зоригт

Танай орны сэргээгдэх эрчим хүчний нөөц шавхагдашгүй юм

Дэлхийн салхины эрчим хүчний зөвлөл /ДСЭХЗ/-ийн нарийн бичгийн дарга Стив Соьер /Steve Sawyer/ “Ньюком” группын урилгаар манай улсад зочлоод буцсан юм. Дэлхийн салхины эрчим хүчний бодлого тодорхойлогчтой уулзан ярилцсан юм.

-Монгол Улсад хөл тавьсан анхны сэтгэгдлээс ярилцлагаа эхлэх үү?

-Танай орны нар, намайг хамгийн их баярлуулсан. Мөн монгол хэл, Аляск нутгийн аялгатай төстэй сонсогдсон, их гайхсан шүү. “Ньюком”-ын барьж буй салхин станцтай танилцахаар явах замдаа Чингис хааны “Цонжин болдог” хөшөөг үзэх завшаан олдсонд баяртай байна. Улаанбаатар хотын хувьд түгжрэл маш их, дээрээс нь зам нь бартаатай гэх мэт сонин зүйлс байсан. Гэхдээ надад Монгол орон таалагдаж байна.

-Монгол Улсад анх удаа ирж байгаа танд манай орны хөгжил ямар харагдсан бэ?

-Монгол Улсын эдийн засаг уул уурхайтай салшгүй холбоотой.

Үүнээс хамаарч маш их хэмжээний хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлт авчирч байна. Харин орж ирсэн тэр их мөнгийг хэрхэн зөв ашиглах вэ гэдэг юу юунаас чухал. Уул уурхайн баялаг гэдэг тодорхой хугацаандашиглаадлнөөцнүдууна. Тухайлбал, Африкийн зарим орон баялгийн хараалд өртсөн. Үүнтэй холбоотой авлигал, тэгш бус байдал гээд олон хортой үр дагаврууд гарч ирсэн. Мөн байгаль орчин бохирдож экологийн тэнцвэрт байдал алдагдах сөрөг үр дагаврууд ч илэрдэг. Гэхдээ Монгол Улсын шийдвэр гаргах түвшнийхэнтэй уулзахад ийм байдал учирч болзошгүйг сайн мэдэж байсан бөгөөд урт хугацааны төлөвлөлт хэрхэн хийх ёстой тал дээр ярьж байсан. Хамгийн гол нь уул уурхайгаас орж ирэх ашгаа хэрхэн зөв зүйтэй зарцуулах нь л чухал.

-Манай орны уул уурхайн хөгжил хурдацтай өсөж байна. Харин байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний асуудал сайн хөгжихгүй байгаа?

-Тийм ээ. Гэхдээ хувийн хэвшлийн компаниуд тухайлбал, “Ньюком” энэ талын ойлголтыг

өөрчилж байгаа болов уу. Тухайн компанийн салхин парк баригдсанаар Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарт нэг ч гэсэн дорвитой бүтээн байгуулалт бий болно. Мөн энэ төсөл сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой бусад олон төслийг араасаа дагуулах байх. Ерөнхийдөө Монгол Улс эрдэс баялгийн арвин нөөцтэй ч энэ нөөц хэзээ нэгэн цагт дуусна. Харин салхи, нар гээд танай оронд байгаа сэргээгдэх эрчим хүчний нөөц шавхагдашгүй юм. Тийм болохоор урт хугацааны төлөвлөлт хийхдээ уул уурхайн хөгжлөөс гадна сэргээгдэх эрчим хүчний тал дээр анхаарах нь зүйтэй.

-Та дэлхий нийтийн шинэ хандлага болох ногоон хөгжлийн талаар ярина уу?

-Ер нь ногоон хөгжлийн хувьд улс бүр өөр өөрийн гэсэн харилцан адилгүй түвшинд явж байна. Хамгийн урт хугацаанд энэ замналаар явсан улс бол Герман, Дани хоёр юм. Дани улсыг аваад үзэхэд 1970-аад онд тулгарсан газрын тосны асуудлаасаа үүдэн ногоон хөгжилд хөл тавих шаардлагатай болсон. Тухайн үед тэдэнд тогтвортой эдийн засаг, экологийн тэнцвэрт байдал хамгийн их шаардагдаж байсан юм. Харин Герман улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч ногоон эдийн засгаа дэмжиж ирсэн.

Ер нь дэлхийн олон улс ногоон хөгжилд ямар шалтгаанаар орж байна гэдэг нь харилцан адилгүй байгаа ч хамгийн гол нь НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенци буюу “Киотогийн” протоколыг баталсан нь их түлхэц болсон юм. Тухайн гэрээ нь байгаль орчны өөрчлөлтийн улмаас хийгдсэн боловч эдийн засгийн хөгжил рүү хандсан байсан. Уг гэрээнд яагаад хатуу түлшнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих ёстой талаарх таван гол шаардлага байдаг. **Нэгдүгээрт**, уур амьсгалын өөрчлөлт. **Хоёрдугаарт**, дотоодын байгаль орчны доройтол. Тухайлбал, Энэтхэг, Хятад зэрэг оронд хатуу түлш их хэрэглэсний улмаас нүүрстөрөгчийн давхар исэл их хэмжээгээр ялгарч эрүүл мэнд болоод байгаль экологит хор хохирол учруулж байсан. **Гуравдугаарт**, эрчим хүчний аюулгүй байдал. Энэ нь эрчим хүч хатуу түлшнээс хамаарал бага болох тусам эдийн засаг өсдөг. Нэг зүйлээс хэт ▶

► хараат байх нь тухайн эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. **Дөрөвдүгээрт**, макро эдийн засгийн хамаарал. **Тавдугаарт**, сэргээгдэх эрчим хүч ирээдүйд эрчим хүчний салбарт томоохон байр суурийг эзлэх зэрэг юм. Иймээс л БНХАУ, ХБНГУ, Энэтхэг, Бразил гээд дэлхийн олон улс орнууд ногоон хөгжлийн бодлогыг түлхүү баримтлах боллоо.

-Өнөөдөр Монгол Улсын хувьд агаарын бохирдол гэдэг тулгамдсан асуудал болоод байна. Мөн манай эдийн засаг нүүрснээс улам хараат болж байгаа?

-Монгол Улсын хувьд нэг томоохон боломж байна. Энэ нь танай орны газрын доорх баялгийг худалдаж авах эрэлт маш өндөр. Уг эрэлт ойрын хэдэн жилд буурахгүй. Хатуу түлшнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих үйл явц тийм ч хурдан байдаггүй. Монгол орон салхи, нарны эрчим хүчний нөөц асар ихтэй. Тиймээс боломж их байна гэсэн үг. Гэхдээ технологийн хувьд танай улс, хоёр хөрш оронтойгоо эрчим хүчээ холбох гэдэг хэцүү зүйл юм байна. Би Монголд ирэхээсээ өмнө энэ талаар огт санаа зовохгүй байсан. Гэтэл маш чухал асуудал юм байна. Үүнтэй холбоотойгоор хот төлөвлөлтийн асуудал яригдах нь зайлшгүй. Тухайлбал, 2020 он гэхэд Улаанбаатар хотын хүн амын тоо хэд хүрэх, эндээ байх уу үгүй юу гээд асуудал бий. Энэ бүгдээс хамаарч шаардлагатай үед зөв хөрөнгө оруулалт хийхийг шаарддаг.

-Өнөөдөр дэлхий нийт салхины эрчим хүчийг хөгжүүлэх тал дээр хэрхэн анхаарч байна вэ?

-Салхины эрчим хүч бусад сэргээгдэх эрчим хүч дундаас хамгийн хурдан хөгжиж байна. Дэлхий нийт салхинаас гурав хүрэхгүй хувьтай цахилгаан гарган авч байна. Салхины эрчим хүчний хөгжлөөр Европ тэргүүлж байсан бол өнөөдөр Ази тэр дундаа Хятад тэргүүлж байна. Мөн саяхнаас Латин Америк хүч түрэн орж ирсэн. Тэр дундаа Бразил, Мексик хоёр улс шинэ зах зээл гэгдэж байна. Бразилын хувьд найман жилийн өмнөөс энэ салбарт хөл тавьсан хэдий ч сүүлийн хоёр жилд салхины эрчим хүчний салбарын хөгжил нь маш хурдтай хөгжиж яваа. 2015 он гэхэд 10 мянган мВт-ын салхи үйлдвэрлэх боломжтой гэж тогтоогдсон. Мөн Европ сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 20 хувиар өсгөх зорилт тавьсан. Түүнчлэн

Европын нийт сэргээгдэх эрчим хүчний 17 орчим хувийг салхинаас гаргаж авдаг. Харин бусад орны хувьд тодруулбал Африк, Тунис зэрэг улс салхины эрчим хүчийг хөгжүүлэх тухайд анхаарлаа хандуулж ирсэн. Энэ бүгдийн үндсэн дээр салхины эрчим хүч хөгжсөөр байна. Ер нь дэлхий нийтийн салхинаас эрчим хүч гаргаж авах хөгжлийг харахад хоёр зүйлийг тодруулах хэрэгтэй байх. Нэгдүгээрт, Хойд Америк салхины эрчим хүчний салбарт тэргүүлэгч байсан. Гэхдээ Америк болоод Канад улсын хувьд улс төрийн тогтолцоо нь урт хугацааны төсөл боловсруулахад нэлээд төвөгтэй байдаг. Тухайлбал, тодорхой төсөл нэг хэсэг амжилттай явж байгаад Засгийн газар солигдоход унадаг. Хоёрдугаарт, Японы Фүкүшимад үүссэн нөхцөл байдал салхины эрчим хүчийг хөгжүүлэх боломжийг бий болгосон. Тус улсын улс төрийн хүчнүүд цөмийн эрчим хүчнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих гэсэн эрмэлзлэл их байна. Гэхдээ энэ нь нэлээд маргаан дагуулах байх.

-Японд сэргээгдэх эрчим хүчийг дэмжих улс төрийн хандлага хүчтэй байгаа бол манай улс цөмийн эрчим хүчийг ашиглах тал дээр их ярьж байгаа. Энэ талаар таны бодлыг сонсье?

-Цөмийн эрчим хүч гэдэг хүн төрөлхтний бүтээсэн хамгийн аюултай бөгөөд хамгийн үнэтэй зүйл. Танай улсад цөмийн зэвсэг үйлдвэрлэх хэрэгцээ сонирхол байхгүй л бол энэ төрлийн эрчим хүчийг ашиглах шаардлага байхгүй гэж бодож байна.

-Манай орны хувьд сэргээгдэх эрчим хүч гэдэг ойлголт дөнгөж л эхлэл төдий байна. Ийм үед төр, засгаас ямар эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай вэ?

-Би одоогоор Монгол Улсын хууль тогтоомжтой танилцаж амжаагүй л байна. Гэхдээ хүмүүстэй уулзахад сэргээгдэх эрчим хүчний хуулийн талаар ярьж байсан. Миний болоод бусад орны туршлагаас харахад, төрийн оролцоо болон хувийн хэвшлийн үүрэг зэргийг нарийн зааж өгөх хэрэгтэй. Ялангуяа хувийн хэвшлийн эрх үүргийг тодорхой зааж өгөх нь чухал. Танай орон сэргээгдэх эрчим хүчний салбарт орж байгаа нь сайшаалтай. Энэ нь гаднын хөрөнгө оруулалт татах нь зайлшгүй юм. Тиймээс уг салбарт

хэрхэн хамтарч ажиллах ёстой талаар бүх заалтыг нарийн тусгаж өгөх хэрэгтэй. Дараагийн асуудал бол урт хугацааны төлөвлөлт. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчийг 2020 он гэхэд 20 хувиар өсгөнө гэсэн байсан. Энэ бол үнэхээр сайн зорилт мөн. Гэхдээ үүнийг яаж хэрэгжүүлэх гэдэг нь чухал. Тухайлбал, энэ зорилтыг хэрэгжүүлэхэд эхлээд дэд бүтцээ шийдэх ёстой. Үүний дараа дараагийн асуудлыг шийдэх шаардлага гарч ирнэ.

-Та “Ньюком”-ын барьж буй салхин паркийг сонирхсон. Ямар сэтгэгдэл төрөв?

-Бүх бэлтгэл ажил нь сайн хангагдсан байсан. Гэхдээ логистикийн асуудал хүндрэлтэй байж болох юм. Гэвч хүндрэл гаргахгүй талаар бодолцсон гэдгээ хүмүүс нь хэлж байсан. Мөн салхин паркийн сэнс маш том шүү дээ. Түүнийг хэрхэн тээвэрлэж авчрах вэ гэдэг том асуудал гарах байх. Машин замаар тээвэрлэх хүндрэлтэй. Төмөр замаар зөөх боломж л байна. Тийм болохоор салхин паркийг төмөр замыг хэрхэн холбох вэ гэдэг бас том асуудал юм. Ер нь төлөвлөлт, салхины нөөцийн судалгааг их сайн хийсэн байна. Тиймээс энэ төсөл амжилттай болно гэдэгт итгэлтэй байна.

-Та байгууллагынхаа талаар товч танилцуулахгүй юу?

-Манай байгууллагын үйл ажиллагааг хэд хэдэн гол үзүүлэлтээр тодорхойлж болно. Нэгдүгээрт, олон улсын түвшинд сэргээгдэх эрчим хүч тэр дундаа салхины эрчим хүчний төлөөлөл болох. Хоёрдугаарт, бүс нутгийн хөгжлийг дэмжих юм. Энэ үүргийн дагуу өнгөрөгч зургадугаар сард болсон сэргээгдэх эрчим хүчний олон улсын хуралд оролцож байхдаа “Ньюком”-ын Б.Бямбасайхан захиралтай танилцсан. Тэрбээр өөрийн орны салхины эрчим хүчний талаар танилцуулж, Монгол Улсад айлчлахыг урьсан юм. Гэхдээ танай оронд ирсэн хамгийн гол зорилго маань Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт ямар боломж байна, мөн нөөц хэр байгаа зэргийг судлах. Түүнчлэн Монгол Улсад шинэ боломж байгаа талаар олон улсад сурталчлах юм. Тухайлбал, энэхүү айлчлалын дараа Бээжинд болох салхины эрчим хүчний томоохон хуралд танай улсын салхины эрчим хүчний хөгжлийн талаар сайтар танилцуулах болно. ■

Монгол манжингийн үлгэр



“Discover Mongolia”

Хөрөнгө оруулагчдын тэвчээр хаа хүрээд алдагдах бол?

Д.Мөнхчимэг

Монгол Улсын эдийн засаг хөгжлийн шинэ гараандаа ирснийг Ерөнхий сайд С.Батболд онцлоод, “Үүнийг бид өөрсдөө ярьж буй бус гадаад ертөнц ч гэсэн хүлээн зөвшөөрч байна” гэлээ. Саяхан л улсын төсөв улайсч, цалин тэтгэврээ тавьж чадахгүйдээ тулж байсан сан. Гэтэл өнөөдөр бид төсвийн орлого, зарлагаа хэдэн зуун тэрбумаар биш, хэдэн их наядаар нь ярьдаг болжээ. Саяхан л нүүр өгсөн болгоноос нь зээл, тусламж гуйдаг байсан бол эдүгээ “Тавантолгой”-н хувьцаагаа олон улсын хөрөнгийн зах зээлд гаргаж мөнгө босгоно гээд явж байна. Монгол Улс бага орлоготой орны ангиллаас сугарч гарч чадсан. Одоо манай улсыг гаднынхан “буурай орон” гэхээ больж, ашигт малтмалын асар их нөөцтэй гэдгээр нь таньдаг боллоо.

Монголын эрх баригчид гадагшаа явж төрийн томчуудтай нь уулзахдаа ч толгой дээгүүр байж чаддаг болж. Бүр

“гэртээ” ч мундаг томчуудыг нь урьж, залдаг болсон байна. Хэдэн жилийн өмнө Америкийн дэд ерөнхийлөгч, Германы Канцлерт урилга өгөх зориг байгаагүй шүү дээ, манай төрийн түшээдэд. За тэр ч яах вэ. Эдийн засаг энэ онд 20, ирэх жил 25.6 хувиар өсөх юм байх. Ингээд ДНБ 18 их наяд төгрөгт хүрнэ гэж байна. Гурван жилийн өмнө ёроолдоо тулах шахсан гадаад валютын нөөц маань 2.6 тэрбум ам.долларт хүрчихлээ. Тэгэхээр Монгол Улсыг баяжаагүй гэж хэн хэлэх вэ дээ.

Хэдийгээр дэлхий Монголыг өөр нүдээр хардаг болсон ч монголчуудын сэтгэхүй ердөө ч өөрчлөгдөөгүй ажээ. Ойрмогхоноос манай хэсэг улстөрч Оюутолгойгоор оролдох болов. Дараа нь бүр УИХ-ын есөн гишүүн гарч ирээд Ерөнхий сайд С.Батболдыг огцруулж, Засгийн газрыг унагах жүжиг тавилаа. “Гэнэт цадах гэдсэнд халтай” хэмээн монголчууд ярьдагчлан эдийн засгийн огцом өсөлт, их мөнгө арай улс төрийг үймээх юм биш байгаа?

Бусдын буруу

Уул уурхай хүрээгээ тэлэхийн хэрээр түүнийг эсэргүүцэгчид ч олширч байна. Уул ус, ургамал амьтдыг сүйтгэж байгаа энэ салбар ард түмний амьдралд ердөө ч сайн нөлөө үзүүлж чадахгүй байгааг иргэний нийгмийнхэн шүүмжилж, уриа лоозонгоо бариад л зурагтаар гарч байдаг болж. Сонгууль дөхөж байгаа учраас улстөрчид ч үүнийг дор нь өлгөж авах нь ойлгомжтой. Гэхдээ анхнаасаа байгаль орчны нөхөн сэргээлт хийх хууль эрх зүйн орчныг тодорхой болгоогүй тэд өөрсдийнхөө бурууг өрөөл бусдад тохохыг оролдох нь мэдээж. Эхний буруутан нь Оюутолгойн гэрээг байгуулж, хөрөнгө оруулагчдыг хэтэрхий олноор нь татсан хамтарсан Засгийн газар болж таарна. Дараагийнх нь Монголын баялгийг зөөж байгаа гадаадын хөрөнгө оруулагчид билээ. Байгаа олчихлоо, одоо дайрах цаг!

“Урт нэртэй” хэмээн хочлогдсон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны ▶

► сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль хоёр жилийн өмнө мөндөрсөн нь эхний дайралт болов. Өөрсдөө “Нааш ир” хэмээн даллаж авчраад, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл тарааж өгсөн компаниудаа одоо хөөж туугаад эхэллээ. “Урт нэртэй” хуулийн хүрээнд 1700 гаруй лицензийг хамруулж, тэдгээрээс эхний ээлжинд алтны шороон ордны 254 тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр гарсан боловч бодит амьдрал дээр хэрэгжиж чадалгүй өдий хүрэв. Уг хуулийн дагуу тусгай зөвшөөрлөө цуцлуулах компаниудын нөхөн олговорт 500 гаруй тэрбум төгрөг хэрэгтэй гэсэн тооцоо байхад хоёр их наяд төгрөг зарцуулна гэсэн мэдээлэл ч дуулддаг. Ийм их хэмжээний мөнгийг Монголын төр төлж дийлэхгүй учраас хууль хэрэгжих, эсэх нь тодорхойгүй хэвээр.

За тэгээд уул уурхайн салбарын “малгай хууль” болох Ашигт малтмалын тухай хуульд ч нэмэлт өөрчлөлт оруулна гэж байгаа. Гэхдээ яг юуг нь өөрчлөхөө мэдэхгүй байгаа болохоор мэдэж автлаа хайгуулын тусгай зөвшөөрөл хэнд ч өгөхгүй гэдэг шийдвэр гаргаад бүхэл бүтэн жил хагасыг үдэв. Мөн Тавантолгойн хөрөнгө оруулагчийг тодруулна гээд таван тивийн 15 компанийг уралдуулсны эцэст Засгийн газар албан ёсоор үр дүнгээ танилцуулсан. Төд удалгүй шийдвэрээ өөрчилчихөөд юу ч болоогүй юм шиг царай гаргаж сууна. Манай төр, засгийн эрхмүүдийн гаргаж буй хайш, яйш занг хөрөнгө оруулагчид хэрхэн хүлээж авч байгаа нь сонирхол татна.

Саяхан л монголчууд Оюутолгой, Тавантолгойгоо эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй муухай царайлж, хөрөнгө оруулалт татах гэж толгойгоо гашилгаж байсан бус уу? Харин өнөөдөр хөрөнгө оруулъя гээд мөнгөө бариад ирсэн хүмүүстэй нь муур, хулгана болж тоглох нь хэнд ашигтай байх вэ?

Галаар тоглох нь

Дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгдэх уул уурхайн “Рио Тинто” компани Монголд орж ирснээр бусад хөрөнгө оруулагчийг сурталчилгааны мөнгө зарахгүйгээр татаж байгаа тухай Сангийн сайд С.Баярцогт

онцлоод, “Энэ бол Оюутолгойн төслийн шууд бус давуу тал. Цаашдаа авах ногдол ашгаасаа ч сайн үр дагаврыг Монголд авчирж мэднэ” гэлээ. Үнэхээр Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг баталсан нь гадаадын баячуудын тархинд “Монгол бол бизнес хийж болдог газар юм байна” гэх ойлголтыг сайтар суулгаж дөнгөсөн юм. “Рио Тинто” хүртэл монголчуудад итгэж, 70 жилийн настай уурхайг хамтран ашиглахаар ханцуй шамлан орсон нь хөрөнгө оруулагчдын сэтгэлийг сэргээсэн билээ. Дэлхийн хэмжээний тоглогчтой хийсэн Монгол Улсын анхны гэрээ энэ байлаа. Үр дүнд нь Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж нэмэгдсэн. Оюутолгойн уурхайг ашиглалтад оруулахын тулд зөвхөн энэ онд л гэхэд 2.3 тэрбум ам.доллар зарцуулж буй агаад бүтээн байгуулалтын ажил нь 50 хувиа гэтлэв. Гэтэл энэхүү гэрээг хүртэл өөрчлөх тухай яриа сүүлийн үед газар авах боллоо.

“Маш их хөрөнгө мөнгө зарсан төсөлшүүдээ. Тиймээс гэрээг өөрчлөх талаар мэдээг хөрөнгө оруулагчид айдастайгаар хүлээж авсан. Би ч мөн адил. Монголд тодорхойгүй байдал үүсэж байна. Үүнээс болж хөрөнгө оруулагчид зугтаж магадгүй” хэмээн Хойд Америк, Монголын бизнесийн зөвлөлийн ерөнхийлөгч Эдвард Т.Стору учирлав.

“Гэрээ гэдэг нэг жил, хоёр жил, бүр 20 жилд ч өөрчлөөд байх эд биш. Энэ бол уурхайн амьдралын явцад хүчин төгөлдөр үйлчлэх бичих баримт байх ёстой” хэмээн “Behre Dolbear” группийн ерөнхийлөгч Бернгард Гуарнера онцлоод, “Хэрвээ Монголын Засгийн газар Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг өөрчлөнө гэвэл уул уурхайн хөрөнгө оруулалт нүд ирмэхийн зуур алга болж мэднэ” гэлээ. Энэ оны эхний хагас жилийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.9 дахин өсөж, 1.8 тэрбум ам.долларт хүрсэн байдаг. Үүний 80 гаруй хувь нь зөвхөн уул уурхайн гавъяагаар орж ирж байгааг онцлох нь зүйтэй болов уу. Эрдэс баялгийн салбар манай ДНБ-ий 30, экспортын 90 орчим хувийг бий болгож буйн зэрэгцээ уг салбарын “малгай хууль” нь хүртэл тодорхой бус байдалд байгаа өнөө үед Оюутолгойн үйл ажиллагаа улстөрчдийн шахалтаас болж зогсвол яах бол?

“Тэд шууд л Монголыг олон улсын шүүхэд өгчихнө. Тэгээд юу болох вэ? Хөрөнгө оруулагчид ч яах вэ, манай газарт булсан таван тэрбум доллараа л алдана. Оронд нь Монголыг олон улсын тавцанд онигоонд оруулаад, бидний нэр хүндийг шороотой хутгана шүү дээ” хэмээн Сангийн сайд С.Баярцогт тайлбарлаад, “Үр дүнд нь бид дараа нь орж ирэх олон арван тэрбум доллараа алдана” гэлээ.

Төгсгөлийн эхлэл...

Баялгаасаа болоод баяжсан орнууд байхад баларсан орны жишээ ч олон. Гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөж тууж, газрын тосноос олсон ашгаа ард түмэндээ тарааж ажлаа эхэлсэн Уго Чавес Венесуэлийг яаж баллаж байгааг хар л даа. Куба, Болив, Зимбабве, Иран гээд ийм замаар явсан орон мундахгүй бий. Иймэрхүү орны удирдагчид эхлээд баялгаа бэлэн мөнгө хэлбэрээр тарааж ард түмнийхээ дунд сайн нэртэй болдог, дараа нь эдийн засаг нь сүйрээд эхлэнгүүт гадаадын хөрөнгө оруулагчид болоод олон улсын байгууллагуудыг буруутнаар нэрлэж, хөөж тууж эхэлдэг. Тэгээд бүр болохоо байхаар нь дарангуйлал тогтоочихно. Ерөөсөө популизм гэдэг ийм л хямдхан, хялбархан улс төр билээ. Монгол Улс 2007 оноос яг энэ замыг сонгож үзсэн.

2004 онд амласан бүхнээ биелүүлэхийн тулд улстөрчид 2007 онд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар гэж 68 хувийн “аймаар татвар” санаачилж, түүнээс олсон орлогоо хүүхэд, залуучуудад бэлнээр нь тараагаад дууссан. Тэгээд хоёр жилийн дараа хямралтай нүүр тулахдаа хүүхдийн мөнгөө ч өгч чадахгүйд хүрч, төсвийн үлэмж алдагдал, эдийн засгийн уналт, валютын ханшийн савлагаатай нүүр тулсан билээ. Үр дүнд нь хоёр ч банкаа “чад хийлгээд” зогсохгүй олон зуун үйлдвэр хаалгаа барьж байхыг, олон мянган хүн ажилгүй болохыг харсан. 68 хувийн татвараа цуцалж, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг цагаа олж үзэглээгүй бол, ОУВС-гаас хөнгөлөлттэй зээл аваагүй бол өнөөдөр монголчууд ийм пээдгэр яваа ч үү, үгүй ч үү... Уг нь Монгол Улс “Баялгийн хараал”-аас хамгаалах урьдчилсан сэргийлэх тарилгыг ийнхүү сайн гэгч нь хийлгэж авсан ►

► юмсан.

Тэгвэл Америк, Австрали, Канад, Чилигээд баялгаа ашиглан тогтвортой хөгжилд хүрч чадсан орон ч олон байдаг. “Эдгээр оронд нийтлэг байдаг хэдэн зүйл бий. Эдийн засгийн эрх чөлөө, улс төрийн тогтвортой байдал, татварын бөгөөд зохицуулалтын тогтвортой байдал хөрөнгө оруулагчдад ая тухыг мэдрүүлж, энэ оронд нэмж мөнгө орууля гэсэн бодлыг төрүүлдэг” хэмээн Бернард Гуарнера тайлбарлав. Харин Монголд тэр бүхэн нь даанч алга.

Оюутолгойн гэрээг өөрчилнө гэж баахан сүржигнэснийхээ дараахан нь Засгийн газар “Рио Тинто” болон “Айвенхоу Майнз” компанитай хамтран бүх зүйл сайхан байгаа тухай мэдэгдэл гаргасан. Ингэснээрээ манай эрх баригчид “орон гаран”

гэдгээ харууллаа гэж эдийн засагч Д.Жаргалсайхан онцлоод, “Энэ бүхэн Монголын төр, засгийн нэр хүнд, монголчуудын нэр нүүрийг унагаж, улсаа дэлхий нийтийн элэг доог болгов” хэмээн бичжээ.

“Монгол Улсыг дэлхийн нүд, чих байнга харж байдаг болчихож” хэмээн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн. Тэгэлгүй яах вэ дээ. Энэ орон Австрали шиг хөгжих үү, Венесуэл шиг доройтох уу хэмээн гаднынхан сониучилж буй хэрэг. Монголын улс төрийн тоглоом үргэлжилсээр... “Хөрөнгө оруулагчдын тэвчээрийг шалгая” гэх сорилтын нөхцөл сонгууль ойртох тусам хүндрэх төлөвтэй. Тэдний тэвчээр хаа хүрээд алдагдах бол? Монголчуудын хүлээж буй үсрэнгүй хөгжил эхлээгүй байхдаа төгсөж мэдэх нь. ■

Төмөрлөгийн үйлдвэр үгүйлэхийн учир

Говь-Алтай аймгийн Цээл сумын нутаг дахь “Таяннуур”-ын ордоос “Алтайн хүдэр” компани өмнөд хөршид төмрийн хүдэр экспортлоод гурван жил гаруйн хугацаа өнгөрч байна. Өдөрт 80 тоннын даацтай 30 орчим “Норд Бэнц” маркын автомашин Алтайн өвөр говийг туулж, говийн хөрсийг “уйлуулан” Бургастайн боомтоор хөлхсөөр. “Нутаг орон сүйдлээ...” гэж нутаг усныхан цухалдах ч тэдний дуу хоолой уул талдаа шингэн замхрах ажгуу. Харин төмрийн хүдэр төрсөн нутагтаа тоосоо шилгээн, өмнө зүг рүү урссаар.

“Алтайн хүдэр” компани нь төмрийн хүдрээ хуурай баяжуулалтын аргаар олборлож байгаа нь “чулуун зэвсгийн үе”-тэй нэн төстэй. Өөрөөр хэлбэл, уурхайгаас гаргасан төмрийн хүдрээ хоёр дахин буталж, тээрэмдээд будаан чинээ болгосны дараагаар хуурай баяжуулах буюу соронзон төхөөрөмжөөр ялгагдаг байна. Уурхайд 30 хувийн агуулгатай байсан хүдэр хуурай баяжуулалтын дараа 40-51 хувийн төмрийн агууламжтай болох бөгөөд ашигтай агууламж нь 15-20 хувиар нэмэгдэх аж. Ерөнхийдөө дэлхийн түвшинд төмрийн агууламж нь 65-68 хувь байвал төмрийн хүдрийн баяжмал хэмээн үздэг байна.

Төмрийн хүдрийн нойтон баяжуулалт нь угааж ялгагдаг бол өөр нэг хэлбэр нь хөвүүлэн баяжуулах технологи. Одоо бол манай төмрийн хүдрийн олборлолт эрхэлдэг компаниуд зөвхөн хуурай баяжуулах аргыг л хэрэглэдэг гэсэн үг. Уг нь бол нойтон баяжуулалтын технологийг ашиглах нь төмрийн хүдэр үрэгдэж, хаягдахгүй, эдийн засгийн үр ашиг нь өсөж, үйлдвэрийн орчин нөхцөл ч сайжрах сайн талтай аж. Солонгосчууд ган, төмөрлөгөөр усан онгоц, япончууд ган торосон утас үйлдвэрлэж буй билээ. Энэ мэтчилэн төмрийн зах зээл Азид ирээдүй харагдаж байгаа билээ. Төмөрлөгийн үйлдвэрлэлийн хувьд зөвхөн урд хөрш гэлтгүй, хоёрдогч, гуравдагч зах зээлийн тухай одооноос ярихад эртдэхгүй нь. Хэдий усан онгоц, ган торосон утас монголчууд хийхэд хол санагдаж магадгүй ч эцсийн бүтээгдэхүүнээ бид борлуулаад байх боломжтой бус уу.

Төмөрлөгийн салбарын ирээдүйд өгч болох нийгэм эдийн засгийн өгөөж ►►



Хүнд аж үйлдвэр

Төмрийн хүдэр төрсөн нутагтаа тоосоо шилгээн, өмнө зүг рүү урссаар

...Үйлдвэржилтийн эрин үеийг өнөө эхлүүлж, ирээдүйд үр шимийг нь хүртээ. Газрын хэвлийн баялгаа хэдий болтол түүхийгээр нь зарж, амны хишгээ ардаа гаргах билээ. Зуун дамжиж эх орныхоо эрдэс баялгийг хаана л авна гэнэ тийшээ нь

зөөлөө, Монгол Улс. Одоо харин үр ашигтайг нь бодож, үндэсний төмөр боловсруулах үйлдвэр байгуулъя. Байгаагаа өөд нь татъя, өрхийг нь тэгшилж гэгээ оруулъя. Баялгаа өөрсдөө баялаг болгож хувиргахад түүхий эд Монголд хангалттай бий.

► нь маш өндөр гэдгийг ШУТИС-ийн Уул уурхайн төсөл, судалгааны төвийн дэд захирал М.Дагва тэмдэглэсэн.

Манайд хариуцлагатай уул уурхай хөгжиж байна уу? Үйлдвэржилтийн сураг чимээ хаана хүрээд “зэрэглээтэв”. Хар төмөрлөгийн цогцолбортой болох талаар Засгийн газар дөрвөн жилийн хугацааны “Мөрийн хөтөлбөр”-төө тусгасан ч ярихаас хэтэрсэнгүй. Тэгээд хар төмөрлөгийн боловсруулах үйлдвэртэй болох хэтийн зорилго, алсын харааг хаанаас олох вэ. Манай улс “түүхий эдийн бөөний төв” мэт урд хөршдөө нүүрс, жонш, төмрийн хүдрээ нийлүүлсээр. Өдөр, шөнөгүй тээвэрлэж байна. Яагаад бид үйлдвэрлэгч бус олборлогчийн “хувь заяа”-тай эвлэрээд сууна вэ.

Жилдээ 25 сая тонноор нь олборлохнүүрсээрхид. “Тавантолгой”-н ордыг дагаж АНУ-ын “PeaBody Energy”, Японы “Mitsui & Co” компаниудын консорциум, БНСУ-ын “Корес” групп ирчихсэн байхад нүүрсээрээ “нүүрээ будах” гээд яах вэ. Харин хаягдаж, гээгдсэн хар төмөрлөгийн ордуудаа эдийн засгийн эргэлтэд оруулж, хар төмөрлөгийн үйлдвэртэй болох арга замыг хайя. Өдгөө хар төмөрлөгийн салбарт зургаан мянга гаруй хүн ажиллаж байгаа бөгөөд боловсруулах үйлдвэр барьж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр ажлын байрны тоо багаар бодоход гурав дахин нугарах тооцоо ч байна. Тухайлбал, Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр л гэхэд 700 орчим ажилтантай. “Төмөртэй”-н хүдрийн уурхайд 300, “Болд төмөр Ерөө гол”-д 1000 гаруй иргэн ажиллаж байгаа аж.

Барилгын салбарынхны зовлон өдгөө төмөр болчихож. Замын-Үүдийн ачаа эргэлтийн хэмжээ нэмэгдэж, хавар, намартаа гацах нь энүүхэнд байдаг. Ийм үед нь “100 мянган айлын орон сууц хөтөлбөр” хэрэгжихээр төмрийн эрэлтээ хэрхэн шийдэх вэ? Гарц олох түлхүүр нь гэвэл өөрсдөө төмрийн хүдрээ шууд боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх шүү дээ. Манай улсын гангийн болоод төмрийн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ 300-гаад мянган тонн боловч үүнийхээ 80 гаруй хувийг өмнөд хөршөөсөө импортлож байна. Айлаас эрэхээр авдраа уудал гэдэг. Уул уурхай үүцээ задалсан гэдэг ч хар төмөрлөгийн салбар жинхэнэ үүцээ хэзээ нээх вэ?

Манайд гангийн үйлдвэр байгууллаа гэхэд хүчин чадал нь таван зуун мянгаас нэг сая тонн байхад л хангалттайг учир мэдэх хүмүүс тайлбарлав. Монголд хар металлургийн чиглэлээр мэргэшсэн 10 гаруй мэргэжилтэн байгаагийн цөөнгүй хэсэг нь хувийн бизнес эрхэлж яваа бол зарим нь Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрт ажиллаж буй аж. Өөрөөр хэлбэл, хар төмөрлөгийн үйлдвэр байгууллаа гэхэд зааж, зөвлөх, мэргэжилтэн хамгийн түрүүнд дутагдах бололтой.

Зэрэглээтсэн бодлого

“Шинэ төмөр зам”-аар бүтээн байгуулалт эхэлж, “100 мянган айлын орон сууц”-аар өртөөлөн “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор”-оор үргэлжилнэ. Хүссэн хүсээгүй төмрийн хэрэгцээ бий болж, өмнөд хөршөөс импортлох төмрийн хэмжээ огцом нэмэгдэх зах зээлийн хандлага байгааг ЭБЭХЯ-ны холбогдох мэргэжилтнүүд хэлж байсан. ЗТБХБЯ-ныхан ч төмрийн эрэлт хэрэгцээ өснө гэдэгтэй санал нэг байна. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээс олох ашиг эргэх холбоогоор сангийн төсвийг зузаатгах болохоор Сангийн яам ч хар төмөрлөгийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд хөрөнгө хаях учиртай. Бүтээн байгуулалтын хөтөлбөрүүд хөрсөн дээр буугаад ирэхээр төмрийн хэрэгцээ нэг сая тоннд хүрч, барилгын арматурын хэрэгцээ одоогийнхоос 70 хувь өсөхөөр байгаа нь чих дэлслээ.

Төмөр авахын тулд орд газраа наймаалцах уу? Эсвэл, түүхийгээр нь төмрийн хүдрээ зөөгөөд байх уу. Энэ бүгдээс гарахын тулд л төмрийн хүдрээ дотооддоо дахин боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн гаргаж, түүгээрээ бүтээн байгуулалтаа урамтай гэгч нь урагшлуулах боломж манайд байгааг М.Дагва хэлсэн юм.

Өнөөгийн байдлаар манай улсын хар төмөрлөгийн салбарыг төлөөлж байгаа нь Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, мөн Хятадын хөрөнгө оруулалттай “Дөл түшиг” компани юм. Дарханы хар төмөрлөгийг бодохдоо манайх ганц ч гэсэн хар төмөрлөгийн үйлдвэртэй нь яамаадай гэж “бахархдаг”. Гэтэл бидний баярлан боддог тус үйлдвэр нь жилдээ 100 мянган тонн барилгын 40 гаруй нэр төрлийн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай боловч

үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник технологи нь шинэ зууны стандартад тэнцэхгүй ажээ. Уг нь тэртээх он жилүүдэд Японы технологиор байгуулсан боловч үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт гэдэг мартагдаад уджээ. 80 төрлийн эрдэс баялгаараа дэлхийд гайхуулаад буй манай улсад орчин цагт хаягдал хар төмөр хайлуулаад хэвэнд цутгах төдий үйлдвэрлэл явуулдаг биш, төмрийн хүдрээ төмөр, ган болтол нь боловсруулж чаддаг эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ус агаар мэт хэрэгтэй байна.

“Төрөөс хар төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлого байхгүйтэй адил гэж хэлж болно. Төмрийн хүдрээ түүхийгээр нь экспортолж байна. Тиймээс түүхий төмрийн хүдрийн татварыг 30, 40 хувиар нэмэх хэрэгтэй. Харин хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүнээ экспортлох тохиолдолд татварыг нь хөнгөлөх зохицуулалт хийх шаардлагатай” хэмээн Монголын экспортлогчдын холбооны тэргүүн Д.Галсандорж тэмдэглэсэн. Тэрбээр “Төмрийн хүдрийн ордуудаа дахин судалгаа хийж, бүс нутгийн төмрийн хүдрийн нөөцийг эцсийн хувилбараар тогтоох хэрэгтэй байна” гэлээ.

Манайх төмрийн хүдрийн нөөцөө олон улсын “Жорк буюу 43101” стандартаар үнэлж, дэлхийн жишигт ойртуулах шаардлага бийг санхүүгийн салбарын мэргэжилтнүүд ч сануулдаг. Хэрвээ ингэсэн тохиолдолд энэ салбарт орж ирэх хөрөнгө оруулалт болоод үйлдвэр барих техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад ч дөхөмтэй аж. Эсвэл нөөцөөрөө шилдэг технологи, шинэ менежмент, хөрөнгө оруулагчдыг Монголдоо даллаж болох биш үү.

Төмөр зам, орон сууц, гүүр, хийн хоолой гээд дэд бүтцийн салбарт төмөр хэрэглэхгүй бүтээн байгуулалт гэж бараг үгүй. Нэг үгээр хэлбэл, төмрийн эрин үе иржээ гэлтэй. Эхний шатнаас эцсийн бүтээгдэхүүн хүртэл боловсруулдаг үйлдвэртэй болохыг хар төмөрлөгийн салбарынхан дуу нэгтэй дэмжицгээх ажээ.

Монгол төмрийн хүдрээр баян уу

Монгол хэчнээн тоннын төмрийн хүдрийн нөөцтэй вэ? Нөөцөө тодорхой тогтоохгүй бол эргэлзээтэй тоонууд ►

хөвөрч мэдэх нь. Харин урд хөрш төмрийн хүдрийн нөөцөөрөө дэлхийд тэргүүлдэг орнуудын тоонд багтдаг. Тэгсэн атлаа тус улс Монголоос төмрийн хүдэр импортлосоор. Албан ёсны статистик мэдээгээр тус улсад 1940 төмрийн хүдрийн орд илэрчээ. Үүний 99 орд нь томоохонд тооцогддог бөгөөд төмрийн хүдрийн нөөц нь 100 сая гаруй тонн. Ойролцоогоор дунд хэмжээний 500 орчим ордын нөөцийн хэмжээ нь 10-100 сая тоннын хооронд хэлбэлзэх аж. Өөрөөр хэлбэл, Хятадын төмрийн хүдрийн нийт нөөц нь дэлхийн батлагдсан нөөцийн 9.6 хувьтай тэнцэж байгаа юм. Тэгвэл Монголын төмрийн хүдрийн нөөц ямар хэмжээнд байх бол.

“Манай хар төмөрлөгийн таамаг нөөц нь хоёр тэрбум тоннд дөхнө. Одоогийн байдлаар баталгаажсан нөөц нь 600 гаруй сая тонн. Үүний 450 сая тонн нь Дархан, Сэлэнгийн бүс нутагт бий. Харин Говь-Алтай, Дорнодод бага хэмжээний хүдрийн ордууд илэрсэн” хэмээн ЭБЭХЯ-ны Уулуурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Батхүү хэллээ. Өнгөрсөн оны байдлаар хамгийн их төмрийн хүдрийг “Болд төмөр Ерөө гол”, “Алтайн хүдэр”, Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр экспортолжээ. Одоогоор хар төмөрлөг олборлох 30 компанид лиценз олгосноос 15 нь өөрийн талбайгаа бүрэн ашиглаж, уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж.

Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд олборлох, баяжуулах, цувимал, ширэм, ган, төмөрт хайлш үйлдвэрлэх. Түүнчлэн нүүрсийг коксжуулах, галд тэсвэртэй материал үйлдвэрлэх, шохойн чулуу, магнетит олборлох, боловсруулах зэрэг үйлдвэрийн дотоод технологит шаадлагатай металлург эрчим хүчний цогцолборууд дагалдан бий болохыг ШУА-ийн эрдэмтэд учирлаж байна.

Өнгөрсөн онд манайх гурван сая 584 мянган тонн төмрийн хүдэр экспортолсон бөгөөд нэг тонн төмрийн хүдрээ 80 ам.доллараар экспортолжээ. “Олборлосон төмрийн хүдрээ хуурай баяжуулалтын аргаар шороо тоосноос нь салгаад, төмрийн агууламжийг 30-40 хувь болтол нь цэвэрлээд өгдөг” хэмээн хүдэр олборлогчдын төлөөлөл сонирхуулсан юм. Зарим уурхай хуурай баяжуулалтын технологио ч төгс ашигладаггүй байна. Гэхдээ

нойтон баяжуулалтын үйлдвэрийг байгуулахаар одооноос хэд хэдэн компани төлөвлөж байгаа нь тэмдэглүүштэй. Сүүлийн үед “Хөх ган” компани төмрийн хүдрийг баяжуулах улмаар ангижруулсан төмөр үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлж байгаа аж. Эднийх шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэх боловч төмрийн агуулга тун бага болохоор олон улсын стандартад дөхдөг бололтой.

Төмөрлөгийн үйлдвэр барих том саналууд ирсээр...


Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр нь 2008 онд төсөвт 8.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, 5.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Зэсийн үнийн “зэс нь цухуйж”, дэлхий нийтээрээ эдийн засгийн хямралд хөл алдсан дээрх жил төмөр үүргээ сайн биелүүлсэн нь энэ. Өнгөрсөн онд л гэхэд 30 мянган тонн бэлдэц, 21 мянган тонн цувимал үйлдвэрлэжээ. Дархан, Сэлэнгийн бүсэд Төмөртэй, Төмөртолгой, Баянголын орд бий. Уурхайн үйл ажиллагаа эхэлсэн энэ гурван үндсэн ордоос гадна хайгуулын арав орчим талбайд таван компани ажиллаж байгаа ажээ.

Төмөр толгой уурхай нь хоёр жилийн өмнөөс эдийн засгийн эргэлтэд орсон бол стратегийн орд болох Төмөртэйг энэ оноос ашиглахаар болжээ. Хуст -Уулын ордод ирэх жилээс хөрс хуулалт эхлэх юм байна. Энэ бүсэд үйлдвэр байгуулахаар Солонгосын “Фоско”, Японы “Коби стийл”, Хятадын МСС корпораци саналаа ирүүлсэн байна. Хятадууд

уламжлалт ширэм үйлдвэрлэх арга, энэтхэгчүүд шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэх технологиор үйлдвэр барихаар ЭБЭХЯ-тай санал солилцжээ. Ширэм үйлдвэрлэх аргыг манайхан анхан шатны хөрөнгө оруулалт ихтэй. Байгаль орчинд хор хөнөөлтэй учраас “No” гээд буцааж. Харин ангижруулсан төмөр гаргах технологи нь ерөнхийдөө дэлхийн “гангийн гуравдагч үе” хэмээн өөрийгөө тодорхойлоод байгаа нь манайхны хараанд өртөж амжжээ. Энэ төрлийн үйлдвэр Япон, АНУ-д бий.

“Дархан, Сэлэнгийн бүсэд ангижруулсан төмрийн үйлдвэрт тохирох нүүрсний Шарын гол, Цогтын гол, Улаан-Овоогжордуудбайна. Гиймээс хар төмөрлөгийн боловсруулах үйлдвэрийг Дархан, Сэлэнгийн бүсэд барих нь үр ашигтай” хэмээн Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн уурхайн мэргэжилтэн О.Болор-Эрдэнэ ярилаа. Одоогийн байдлаар Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр нь төмрийн хүдрийн хоёр уурхай ашиглаж, анхан шатны боловсруулалт хийн экспортолж байгаа. Ирэх жил нэг сая тонн хүчин чадалтай нойтон баяжуулалтын үйлдвэрээ нээхээр ажиллаж буй аж. Иймэрхүү хүчин чадалтай нойтон баяжуулалтын үйлдвэрийн өртөг нь зургаан тэрбум орчим төгрөг гэнэ. Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийнхэн ч тоног төхөөрөмжөө шинэчлэхээр төлөвлөж буй аж. Ийнхүү хаягдаж, гээгдсэн хар төмөрлөгийн салбараа анхаарч эдийн засгийн эргэлтэд оруулъя. Боломж дэргэд байна. ■

Төмрийн хүдрийн олборлолт болон экспорт /мян.тонн/



Эх сурвалж: Ашигт малтмалын газар



Ч.Отгочулуугийн булан

Иргэдэд өгөөжтэй уул уурхай

Монгол Улс салаа замын уулзварт ирээд байна гэхийг олонтаа сонсох боллоо. Эхний зам нь чинээлэг иргэдтэй, ардчилсан төртэй, хүчирхэг эдийн засагтай, сайн засаглалтай, онгон дагшин байгалиа хадгалж үлдсэн оронд хүргэх бол нөгөө зам нь ядуу иргэдтэй, оюун санаа, сэтгэлгээний хувьд боолчлогдсон, авлигад идэгдсэн төртэй, байгаль орчин нь сүйдсэн байх тийм нийгэм рүү аваачих гэнэ.

Зам мөр маань иймэрхүү байх аж. Гэвч замдаа бус замнагчдад учир их байна. Монгол Улс маань хэдий нэгдмэл төртэй ч эдийн засаг, зах зээл маань бие биенээсээ хамааралгүй салангид хэсгүүдэд хуваагдан унах шинж ажиглагдах боллоо. Үүнд, албан ба албан бус, хотын ба хөдөөгийн мөн түүнчлэн уул уурхайн ба уул уурхайн бус хэмээн дурдаж болно.

Нэгдүгээрт, албан эдийн засаг өсөөд байгаа мэт харагдаж байвч, цаана нь бичил, жижиг бизнес эрхэлдэг хүмүүсээ бүртгэж чадахгүй байна. Тэд эдийн засагт ямар их хувь нэмэр оруулж байгааг эсвэл байгаль орчинд хэр их хор хохирол учруулж байгааг хэмжиж, хянаж чадахгүй л байна.

Хоёрдугаарт, хот, хөдөөгийн ялгаа ихэссээр. Ялангуяа зах хязгаар нутгууд эзгүйдэж байхад Улаанбаатарт хэт төвлөрлөөс үүдэн амьдрах орчин өдөр бүр дордож байна. Өнөөдөр төрөөс тэгшитгэх бодлого явуулж буй ч, амьдрал дээр тэгш бус байдал улам газар авч байгаа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнээс харж болно.

Гуравдугаарт, эдийн засаг

маань уул уурхайн ба уул уурхайн бус гэсэн хоёр хэсэгт хуваагдлаа. Уул уурхайн компаниуд ихэнх бүтээгдэхүүнээ гадагш экспортолж, харин тоног төхөөрөмж, материал, түүнчлэн хүний нөөцөө ч ихэвчлэн гаднаас импортолж байна. Гэтэл Монголд ажлын байр олноор бий болгох чадавхтай уул уурхайн бус худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарууд өндөр инфляци болон ханшийн хэлбэлзэл, бэлтгэгдсэн ажиллах хүчнээ уул уурхайнханд алдах, эсвэл алдахгүйн тулд цалингийн зардлаа огцом өсгөх зэрэг хүндрэл бэрхшээл дор үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр салбар уул уурхайн салбарын сүүдэр дор хатаж, мөхөх аюул дор амь зууж байна.

Уул уурхайн салбар ядууралтай холбоотой бүх бэрхшээлийг арилгана, уул уурхайг дагаад ажлын байр олноор бий болно, уул уурхайн ашгаа хүн бүрт хүргээд, монголчууд удахгүй Арабын баян орны иргэд шиг зүгээр сууж байгаад тансаг амьдарна гэх сурталчилгаа газар авч байна. Улс төрийн их туршлагатай том хүчин маань ч сонгуулийн халууралд автан энэ төөрөгдлийг өөгшүүлэх боллоо.

Гэтэл байдал ямар байна вэ? Уул уурхайд хариуцлагагүй, эмх замбараагүй байдал нүүрлэлээ. Лицензийн асуудал дээр л гэхэд чадавхгүй төрийн уршиг их харагдаж байна. Улс даяар олон мянган лиценз тараагдсан хэрнээ тэднийгээ хянаж чадахгүйд хүрчихсэн байгаа бүх хяналтыг төвлөрүүлсэн төр маань иргэддээ, орон нутагтаа итгэхгүй байгаа учир эзэнгүйдэл хаа сайгүй үүссээр байгаа юм. Уул уурхайг

дагасан их мөнгөө зөв удирдаж чадахгүй байгаагаас инфляци хэмээх зардлыг ард түмэнд давхар үүрүүлж байна. Гадаад худалдааны алдагдал нэг тэрбум ам.доллар боллоо. Бид гаднаас илүү ихийг худалдаж авч байна. Зөвхөн гадаад орчинтой бизнес эрхэлдэг гэдэг утгаараа өмнөд бүс буюу говийн аймгууд тун удахгүй манай мэдлээс гарах нь ээ.

Манай Засгийн газар, түүний төсвөөс ч том бас баян уул уурхайн компаниуд Монгол Улсын бодлогын бүсэд орж ирлээ. Жилийн төсөв нь хоёр тэрбум ам.долларт эргэлдэх энэ оронд гаднын зах зээлээс 25 тэрбум доллар босгож чадсан баян компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн байгаль орчин, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг тэр бүр сахиад байдаггүй дунд хэмжээний гадаадын хөрөнгө оруулалтын тоо ч өсөх хандлагатай байгаа ба дундчуудын эгнээнээс үндэсний компаниуд шахагдах шинжтэй байна. Харин монголчууд хамгийн их ажиллаж буй уул уурхайн хэсэг нь нинжа нар буюу албан хэллэгээр бичил уурхай эрхлэгч нарын арми юм. Ингээд харахад уул уурхайн салбарт гурван тэс өөр ертөнц зэрэгцэн оршиж байна. Нэгдүгээрт, гаднын томоохон хөрөнгө оруулагчид, хоёрдугаарт, дунд хэмжээний хөрөнгө оруулагчид. Харин гурав дахь ертөнц нь бичил уурхайчид буюу монгол нинжа нар юм.

Үнэн хэрэгтээ даяарчлалын энэ эрин үед Монголын пүүс компаниуд жижгээс том руу дэвшиж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болон өсөх боломжтой. Гэвч бодит байдал үүний эсрэг байна. Гаднынхан хүч түрэн орж ирж, монголчуудыг нэгээс хоёр руу, улмаар хоёроос гуравдагч ертөнц рүү түлхэх болжээ. Учир нь, тэдэнд мөнгө, мэдлэг, гарц байна.

Дэлхийнажуйлдвэртүүхий эдээр цангаж эхэлж байгааг бид бэлхнээ харж байгаа билээ. Дэлхийн хүн ам өсөхийн хэрээр, нүүрс, зэсийн хэрэгцээ өсөх нь тодорхой боллоо. Нийлүүлэлт нь ч эрэлтээ гүйцэхээ болих нь. Гадаад орчноо зөв ашиглаж чадвал Монголын уурхайчид өнөөдөр нинжа биш, харин их гарын хөрөнгө оруулагчид болон өсөх боломжтой юм. Өөрөөр ▶

хэлбэл, бид уул уурхайн баялгаа огт өөр өнцгөөс харж, залж чадвал дэлхийн том тоглогч болж чадна. Эс бөгөөс дотроо үзсээр баялгийн хараалд автах болно.

Хамгийн гол нь уул уурхайн энэ их өсөлт энгийн иргэн, нийгэмд ямар өгөөжтэй вэ? Өнөөдөр бид өгөөжийг хүлээгээд суулгүй харин өөрсдөө зөв орчноо бүрдүүлэх учиртай.

Эдийн засгийн төрөлжилт, сайн засаглал, иргэдийн оролцоог шинэ түвшинд гаргах нь уул уурхайн хараат

байдлаас ангижрах гол хэрэгсэл болно. Аймаг, сумын Засаг даргын хажууд иргэний танхим, холбоо байгуулах замаар уул уурхайд хяналт тавих, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь хамгийн эрүүл, зөв, үр дүнтэй арга болох ёстой.

Түүнчлэн гаднын том уул уурхайн компаниудаас суралцаж, засаглал, менежментээ сайжруулах замаар уул уурхайгаас үүдэлтэй гадагшаа харсан цонхыг бусад салбарынхандаа зориулж онгойлгож өгөх нь зүй. ■

түүхий эд болсон зэсийн эрэлт хэрэгцээ буурах нь эдийн засгийн байдал маруухан байгааг илтгэх нь элбэг. Тухайлбал, санхүү, эдийн засгийн хамралын эхэн үед зэсийн үнэ навс унаад, дэлхий хямралыг гэтэлж эхлэхээс урьтаад ханш нь өсөж эхэлсэн дээ. Тэгвэл өнөөдөр Америк, Европын төсвийн доройтол, Хятадын үнийн өсөлттэй зэрэгцэн улаан металлын ханш дахиад л буурч эхлээд байна. Лондоны металлын бирж дэх тонн зэсийн үнэ өнгөрсөн хоёрдугаар сард 10190 ам.долларт хүрч рекорд тогтоосон боловч саяхан 7370 ам.доллар болтлоо навс унаад, эргээд бага багаар сэргэх хандлагатай болсныг графикаас харна уу.

Монголчуудын хувьд зэсийн үнэ хоногийн хоолтой нь холбоотой гээд хэлчихвэл Та гайхаж магадгүй. Өмнө нь дан ганц “Эрдэнэт”-ээс хамааралтай байсантай харьцуулахад одоо бид нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн экспортоос овоо мөнгө олоод эхэлсэн нь үнэн. Гэхдээ л нүүрсний экспорт зэсийн баяжмалаас илт давсан хэдий ч төсөвт төвлөрүүлж байгаа орлогыг нь аваад үзвэл зэс тэргүүлсэн хэвээр байна. Тухайлбал, энэ онд нүүрснээс 402.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр байгаа бол зэсийн баяжмалаас 561.2 тэрбумыг авахаар байгаа юм. ▶

Санхүүгийн зах зээл

Зэсийн үнэ унавал...

Д.Мөнх

Дэлхийн эдийн засгийн байдлыг урьдчилан харуулдаг чадвараар нь зэсийг “Dr Copper” хэмээн нэрлэдэг болсон. Энэхүү улаан металлын үнийн хэлбэлзэл эдийн засгийн төлөв ямар байгаагаас шалтгаалдаг гэсэн онол ч бий.

Зэсийн эрчим хүч болон дулаан дамжуулах чадвар юутай

ч зүйрлэшгүй бөгөөд дэлхийг хэрсэн кабель утаснаас эхлээд бидний амьдарч буй байшин барилга, өдөр тутам хэрэглэж буй гар утас, компьютер гээд хаа сайгүй оршин тогтноно. Нэг автомашин л гэхэд дунджаар 25 кг зэс агуулдаг аж. Тиймээс барилга болон үйлдвэрлэлийн амин чухал



Эх сурвалж: Лондоны металлын бирж

► Хятадаас хамаарах ханш

Дэлхийн зэсийн хэрэглээ жилд 16 сая тонн байдгийн 40 хувийг Хятад улс дангаараа бий болгож буй. Тиймээс улаан металлын үнийн өсөлт, бууралтад урд хөрш хүчтэй нөлөө үзүүлэхээс аргагүй. Гэвч Америк болон Европыг тойрсон асуудлууд Хятадын зэсийн эрэлтийг бууруулах талтайг “BNP Paribas” банкны шинжээч Стефен Бриггс онцолжээ. “Хүн бүр л Хятад дэлхийн зэсийн хэрэглээний 40 хувийг бий болгож буйг ярьдаг. Гэхдээ хятадууд зэс худалдан авч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боловч эцсийн хэрэглэгчид нь ихэвчлэн Америк, Европт л байж таардаг шүү дээ” хэмээн Стефен Бриггс тайлбарласныг “China Briefing” мэдээлсэн байна. Үнэхээр хөгжингүй орнуудын санхүүгийн асуудал хүндрэхийн хэрээр Хятадын үйлдвэрлэл ч саарч байгааг харуулах баримт олон. Урд хөршийн аж үйлдвэрлэл өнгөрсөн аравдугаар сард 2009 оны хоёрдугаар сараас хойших доод түвшиндээ хүрсэн тухай “Блүүмберг” мэдээлсэн байна. Тус улсын үйлдвэрлэлийн салбар дахь худалдаа эрхлэгчдийн индекс буюу PMI өнгөрсөн есдүгээр сард 51.2 нэгж байсан бол аравдугаар сард 50.4 болтлоо буурчээ. Үүний хажуугаар Хятадын эдийн засгийн өсөлт ч саарч байгаагийн зэрэгцээ инфляцийн өсөлтөө зогсоохын тулд тус улсын Төвбанк мөнгөний бодлогоо “чанга атгаж” байгаа нь зэсийн ханшид сөргөөр нөлөөлөх талтай. Энэ бүхнээс болоод шинжээчид ч зэсийн үнийн таамаглалаа ээлж дараалан бууруулж эхлээд буй.

Америкийн “Goldman Sachs” хөрөнгө оруулалтын банк таваарын ханшийн таамаглалаа дандаа л өөдрөгөөр гаргадаг учраас өрсөлдөгчид нь түүнийг “байнгын бух” хэмээн хочлох нь бий. Гэтэл тус банк хүртэл зэсийн үнийн таамаглалаа эргэн харж, ирэх онд тонн нь 10790 ам.доллар байна хэмээн тооцоолж байсныгаа 9200 ам.доллар болгон бууруулжээ.


Харин “Reuters” агентлаг 23 шинжээчээс судалгаа авахад ирэх онд зэсийн дундаж үнэ 8950 ам.доллар байна гэж гарсан байна. Энэ нь долдугаар сарынхаас 10.5 хувиар буурсан үзүүлэлт аж. Тэгвэл макро эдийн засгийн судалгааны “Capital Economics” компани зэсийн үнийн ирээдүйг бүр ч бүрхэгээр харж байгаа юм. “Ирэх онд тонн нь 7500 ам.доллар байна хэмээн бид үзэж байсан боловч эдүгээ зэсийн үнэ хэдийнэ дээрх хэмжээнд хүртэл буурчихлаа. Зах зээл нэг хэсэгтээ тайвшрахтай зэрэгцэн уг металлын ханш ялимгүй сэргэж болох ч ирэх онд тонн нь 6000 ам.доллар, бүр түүнээс ч доош орж магадгүй гэж бид үзэж байна” хэмээн “Capital Economics”-ийн шинжээчид тэмдэглэжээ.

Тогтворгүй сан


Гурван жилийн өмнө зэсийн ханш навс унахад монголчууд хуримтлуулсан юмгүйгээ мэдэж, яадгаа алдсан. Дахиад ийм байдалд орохгүйн тулд УИХ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Энэхүү хуулийн гол агуулга нь дэлхийн зах зээл дэх түүхий эдийн ханш өндөр байх үед нөөц бүрдүүлж, хэцүү цагт түүнийгээ хэрэглэхэд оршдог. Ер нь ашигт малтмалаас хамааралтай орнууд ихэвчлэн ийм арга хэрэглэж амжилтад хүрсэн байдаг. Монгол Улсын хувьд энэ жилээс л Тогтворжуулалтын санд мөнгө хуримтлуулж эхэлсэн бөгөөд оны эцэс гэхэд 219 тэрбум төгрөг төвлөрнө хэмээн Сангийн яамныхан хүлээж буй. Харин ирэх жил уг санд 381 тэрбум төгрөгийн орлого орно хэмээн төлөвлөсний 168 тэрбум нь зэсээс бүрдэхээр байгаа юм. Гэвч энэхүү тооцоог хэр бодитой гаргасан байна вэ?

2012 оны төсвийн төлөвлөгөөнд дэлхийн зах зээл дэх зэсийн үнийг 9760 ам.доллараар, тэнцвэржүүлсэн үнийг 6663 ам.доллар тооцож тусгасан байгаа юм. Өөрөөр хэлбэл, зэсийн үнэ 6663 ам.доллар хүртэл унавал Тогтворжуулалтын санд мөнгө хуримтлуулж чадахгүй болно. Харин ханш 6663 ам.доллараас доош буурвал юун хуримтлал манатай, бүр улсын төсөв улайсаж, бэлэн мөнгөө ч тарааж чадахгүйд хүрнэ. Гэтэл олон улсын шинжээчид ирэх онд зэсийн үнэ буурна гэсэн таамаглал гаргаад байдаг. ■

Зэс (тонн/ам.доллар)



Хар тугалга (тонн/ам.доллар)




Никель (тонн/ам.доллар)




Цагаан тугалга (тонн/ам.доллар)



Цайр (тонн/ам.доллар)



Хөнгөн цагаан (тонн/ам.доллар)



Хөрөнгийн зах зээл



Хөрөнгө оруулалт

Монголд юу үлдэх ёстой вэ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн ганц, хувийн 14 банк хамаг хөрөнгөө нийлүүлээд халаасаа гүвээд ч Оюутолгойг хоёрхон долоо хоног л санхүүжүүлэх эдийн засгийн чадамжтай. Тийм болохоор Оюутолгой, Тавантолгой зэрэг томоохон төслийг санхүүжүүлэхийн тулд гадаадаас хөрөнгө босгох нь ойлгомжтой юм. Харин энэ босгож буй мөнгөний багахан хувийг л Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаахэлбэрээр худалдвал манай улс мөнгөжих боломжтой гэнэ. Уул уурхайгаас орж ирсэн мөнгийг хэрхэн зөв зохистой зарцуулах гэх мэт асуудлаар Хойд Америк, Монголын хамтарсан бизнесийн зөвлөлийн 14 дэх удаагийн хурлын үеэр хэлэлцсэн юм. Уул уурхай дагасан их мөнгөний түрлэг нэгэнт хүн бүрийн хэтэвчинд “Хүний хөгжлийн 21 мянга” гэдэг нэрээр ороод эхэлсэн энэ үед ямар салбарт хөрөнгө оруулах, хэрхэн зарцуулах, эрдэс баялгаа ашиглаж дууссан тэр үед Монгол Улсад юу үлдэх ёстой зэрэг асуудал энэ удаагийн хурлын гол агуулга байсан. Зочдын олонх нь “Хүмүүст бэлэн мөнгө тараах бус

бодит бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах хэрэгтэй” гэдэгт санал нэгтэй байлаа. Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд тулгамдаад буй, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулах, аж үйлдвэрийн парк байгуулах, боловсролын салбарыг дэмжих, логикийн асуудлыг шийдэх гээд хөрөнгө оруулах зайлшгүй шаардлагатай салбаруудыг нэрлэж байсан юм. Мөн тус хурлын үеэр MCS группын барьж буй дэлхийн жишигт нийцсэн эмнэлэг, Сайншандын аж үйлдвэрийн парк гэх мэт дээрх тулгамдсан асуудалд эерэгээр нөлөөлж чадахуйц төслийг танилцуулсан. Гэхдээ эдгээр асуудлыг шийдэхийн тулд нөгөө л хөрөнгө босгох ажилтай тулгарна. Гэтэл манай хөрөнгийн биржийн хөгжил дорой байна гэдэгт хүн бүрийн санаа зовсоор. . .

Монголын хөрөнгийн биржийн ерөнхийлөгч Билл Горман “Монголын хөрөнгийн бирж ил тод бус, боловсон хүчний хөгжил муу, техник технологийн явдал дорой мөн арилжаа хийх явц хэтэрхий төвөгтэй байна” гэсэн. Гэхдээ энэ бүгдийг Монгол Улс болоод

Лондоны хөрөнгийн бирж хамтран ажилласнаар өөрчилж тэр ч бүү хэл, хамтарсан сүлжээг бий болгож чадна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн ерөнхийлөгч Эдвард Т.Стору “Бид өмнө нь хурал болоход хөрөнгө оруулалтын хэрэгцээний тухай л ярьдаг байсан. Харин өнөөдөр тогтвортой байдлын талаар тогтож ярьж байна. Гэрээ байгуулаад хөрөнгө оруулалт нэгэнт орж ирсэн л бол тухайн гэрээний нөхцөлд заасан зүйл заалтыг хүндэтгэн үзэх нь чухал юм. Эрдэс баялгийг ашиглах гэдэг нь өөрөө маш их хөрөнгө оруулалт мөн урт хугацаа шаарддаг ажил. Тийм учраас яарах хэрэггүй. Тухайлбал, нэг орд газар нээлээ гэхэд түүнийгээ ашиглахын тулд 10 хүртэлх жил ч шаардлагатай байж болно. Тийм болохоор энэ төрлийн бизнес хийж байгаа талууд гэрээ байгуулах, үйл ажиллагаа явуулахдаа маш хариуцлагатай байх нь чухал юм. Нэгэнт ашигт малтмалыг ашиглаад эхэлсэн тохиолдолд маш их хэмжээний баялаг бүрдэх нь ойлгомжтой. Энэ үед Монгол Улсад хамгийн чухал нь юу вэ гэхээр тэр их баялгаас олсон орлогыг хэрхэн яаж зөв зарцуулах гэдэг юм. Жишээ нь иргэдийн эрүүл мэндийн асуудалд зөв зохицуулалт хийх хэрэгтэй. Мөн дэд бүтэц, боловсрол гээд чухал салбарт хөрөнгө оруулах нь ач холбогдолтой хэмээн ярилаа. Мөн ▶▶

▶ “Женерал Электрик энтернэйшнл” компанийн Монгол дахь Суурин төлөөлөгч Ц.Түмэнцогт “14 жилийн өмнө маш цөөхөн хүн Монголыг мэддэг байлаа. Ийм хурлын үеэр анхандаа Монголд хөрөнгө оруулах боломжуудыг танилцуулж, хөрөнгө оруулагчдын Монголын талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга ажиллагаанд түлхүү анхаардаг байсан. Харин одоо бидний хэлэлцэж байгаа асуудлууд өөр болсон байна” гэв.

Энэхүү хурлын үеэр Оюутолгойн гэрээний заалтыг өөрчлөх шуугиан дэгдэж байсан болохоор дээрх хуралд оролцогчдын амнаас хөрөнгө оруулалтад чиглэсэн санаа оноо илүү гарч байсан юм. Учир нь, Оюутолгойн гэрээний өөрчлөлтийн талаар гэнэтхэн шуугисан нь гаднын тэр дундаа уул уурхайн салбарт хөрөнгө хаясан, хөрөнгө оруулахыг сонирхсон хүмүүсийн хувьд таагүй мэдээ байсан нь мэдээж. ■

зохицуулах хороо/СЗХ/ “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг 2007 оны 83 дугаар тогтоолоор баталсан байна. Ер нь бол листинг хийх улсынхаа хууль, зохицуулах байгууллага, биржийн шаардлагыг хангаж байгаа бол гадаадад үнэт цаасаа гаргах боломж нээлттэй байна. /Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-гийн тухай жич ярилцаж болно/. Харин гадаадын хуулийн этгээд Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэхтэй холбоотой ямар ч зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловч гадаадын бирж дээр хувьцаагаа бүртгүүлэн арилжиж байгаа компаниуд Монгол Улстай давхар татвар үл ногдуулах хэлэлцээр байгуулсан /DTA-Double Taxation Agreement/ улсад компанийнхаа толгой компанийг байгуулж, мөн уг компанийнхаа толгой компанийг /Listco-listed company/ листинг хийхийг хүссэн улсынхаа эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн /Approved jurisdiction / улсад байгуулах замаар уг ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Энэ нь Монгол Улс болон үнэт цаасаа бүртгүүлсэн улсад оршин сууж буюу оршин байгаа хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагч нь хоёр улсад давхар татвар төлөхгүй байх нөхцөлийг хангадаг. Түүнчлэн томоохон хөрөнгийн биржид бүртгүүлэхэд зохицуулагч байгууллагын зүгээс үнэт цаас гаргагчийн харъяалах улстай мэдээлэл солилцох нөхцөл бүрдсэн эсэх зэргийг харгалзан эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн /Approved jurisdiction/ улсуудын жагсаалтыг гаргаж, гадаад улсын хуулийн этгээд тухайн улсын биржид үнэт цаасаа бүртгүүлэх ажиллагааг хялбарчилсан байдагтай холбоотой. Монголчууд бид “Энержи ресурс”-ийн хувьцаа Хонконгийн бирж дээр арилжаалагдаж байна гэж ярьж байгаа ч тэнд ММС-ийн хувьцаа арилжигдаж байгаа нь ийм учиртай.

Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд гадаад улсын хуулийн этгээд манай бирж дээр үнэт цаасаа гаргах тухай ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Тэр байтугай гадаад ▶

Хууль

Давхар бүртгэлийн эрх зүйн орчныг бүрдүүлье

Д.Дүгэржав /судлаач/

Яагаад энэ сэдвийг ярилцах хэрэгтэй вэ?

Монголын уул уурхайн баялгийг түшиглэн манайд үйл ажиллагаа явуулж байгаа 30 гаруй компани гадаадад үнэт цаасаа гаргаад байна. Эдгээр үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээс манай иргэд, хуулийн этгээд худалдан авч, эх орныхоо баялгаас ашиг хүртэж чадахгүй байгаа тухай сүүлийн жилүүдэд нэлээд шүүмжлэл өрнөсөн. Тэдгээр компани хүссэн хэмжээний хөрөнгөө Монголын зах зээлээс босгох асуудал хүндрэлтэй гэх мэтээр эдийн засгийн агуулга талаас олон тайлбар гарах нь мэдээж. Иймд үнэт цаас гаргагч нь төлөвлөсөн хөрөнгөө гадаад, дотоодын захаас татах, монголчуудад тэдгээр компанийн хувьцааг биржээсээ худалдан авч, баялгийнхаа үр шимийг хүртэх боломж олгохын тулд Монгол Улсад давхар бүртгэл /dual-listing/ хийх эрх зүйн орчныг авч үзэх шаардлагатай.

Эрдэнэс Тавантолгойн хувьцааг Монголын хөрөнгийн бирж, Лондон, Хонконгийн биржид бүртгүүлэн арилжаалах асуудал олны анхаарлын төвд байна. Төр, засгийн байгууллагууд ч зарим шийдвэр

гаргасан. Гадаадад үнэт цаасаа гаргаад байгаа дээр дурдсан компаниудын зарим нь Монголд давхар бүртгүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлдэг. Эрдэнэс Тавантолгойн хувьцааг гурван бирж дээр гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зөвхөн уг асуудлыг яаравчлан шийдвэрлэх гэж явцууралгүйгээр харин ч цаашид монголчууд олон улсын хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг нээх алхам болгох нь зүйтэй санагдаж байна. Эрх зүйн орчноо бүрдүүлэх асуудлыг орхигдуулж захиргааны аргаар зүтгүүлэх нь хожмоо шүүмжлэл, хохирол дагуулахыг үгүйсгэхгүй.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зохицуулах байгууллагууд, яамдын түвшинд бэлтгэн өргөн барихаар зэхэж байгаа нь энэ асуудлыг хөндөх бас нэгэн шалтгаан болж байна.

Гадаад улсын хуулийн этгээд манай биржид үнэт цаасаа бүртгүүлэн гаргах эрх зүйн орчин бүрдсэн үү?

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.2-т үнэт цаас гаргагч гадаад орны зах зээлд өөрийн үнэт цаасаа арилжаалж болно гэж заасан бөгөөд Санхүүгийн



► улсын хуулийн этгээд гэдэг тодорхойлолтыг эдгээр хуульд тусгаагүй байна. Иргэний хуулийн 544.1-д: “Гадаадын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадамжыг харьяалсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн зөвшөөрнө”, Компанийн тухай хуулийн 2.1-д: “Энэ хууль болон Монгол Улсын бусад хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө” гэж заасан бөгөөд хуульд өөрөөр заасан зохицуулалт нь одоогоор аль ч хуульд байхгүй байна. Иймд Listco нь Монгол Улсын хуулийг дагаж мөрдөнө гэж ойлгогдож байна. Гэтэл Listco-ийн харьяалсан улсын хууль болон Монгол Улсын хууль нь ялгаатай зохицуулалттай байх тохиолдолд Listco нь хоёр улсын хуулийг нэгэн зэрэг дагаж мөрдөх боломжгүй болно. Үүнийг зөрчилдөөний хэм хэмжээ /Conflict of law/-ээр зохицуулдаг. Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банкны тухай зэрэг бизнесийн гол хуулиудад гадаадын хуулийн этгээд Монгол Улсад бизнес эрхлэх /түүний дотор санхүүгийн бизнес эрхлэх/, гэрээ хэлцэл байгуулах, салбар нээн ажиллуулах, хөрөнгийн биржид бүртгүүлэх зэрэг тохиолдолд зөрчилдөөний хэм хэмжээг хангалттай тодорхой тусгаж өгөөгүй нь олон улсын зах зээлд чиглэсэн төрийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхэд оролцож буй бизнес эрхлэгчдэд бэрхшээл учруулж байна.

Торонто болон Хонконгийн биржид давхар бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа “South Gobi Resources” компани Монголын хөрөнгийн биржид гурав дахь бүртгэлээ хийх сонирхолтойгоор олон улсын болон дотоодын зөвлөх баг бүрдүүлж, манай улсын эрх зүйн орчинд судалгаа

хийж, тайлан гаргасан байна. Энэхүү баг тайландаа “Монгол Улсын хууль, зохицуулах дүрэм журмууд нь “South Gobi Resources” компанийн энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид листинг хийхэд хараахан бэлэн болоогүй байна” гэсэн гол дүгнэлт гаргажээ.

Зөрчилдөөний хэм хэмжээ /Conflict of law/-г хэрхэн шийдвэрлэх вэ?

Аливаа хуулийн этгээд нь гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн бол гадаадын хуулийн этгээд гэж үздэг. Гадаад улсын хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа харьяалах улсынхаа хуулийг дагаж мөрдөх үндсэн зарчмыг Иргэний хуулийн дээр дурьдсан 544.1-д тодорхойлсон. Харин Компанийн тухай хуулийн хоёрдугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн агуулгаас үзвэл давхар бүртгэлийн онцлог зохицуулалтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзэж болохоор байна. Давхар бүртгэлийн зохицуулалтын талаар олон улсын жишиг нэгэнт тогтсон байна. Энэхүү жишгийг харгалзан үзвэл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад үнэт цаасаа анх удаа буюу давхар бүртгүүлэх гэж байгаа гадаадын үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын хүрээг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно. Ийнхүү тогтоохдоо хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлийн өрсөлдөх чадвар, хууль тогтоомжийн зөрүүтэй байдлыг харгалзан үзнэ” гэсэн агуулгатай зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

Нийтлэг жишгээс үзвэл гадаадын хуулийн этгээд нь оноосон нэр, альтернатив нэр хэрэглэх, төрийн болон зохицуулах байгууллагад гаргаж өгөх баримт бичиг, тайлан баланс, аудитын дүгнэлт, ханшид нөлөөлөх болон татан буугдах тухай мэдээлэл өгөх, төрийн болон зохицуулах байгууллагатай төлөөлөн харилцах этгээдийн талаар мэдээлэл өгөх зэрэг дотоодын хуулиар тогтоосон нийтлэг зохицуулалтыг дагаж мөрдөхийг шаарддаг байна. Мөн хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор бусад нарийвчилсан зохицуулалтыг тодорхойлсон байдаг. Жишээ нь, үнэт цаас гаргагч гадаадын компани нь үнэт цаасны ханшид нөлөөлөх мэдээллийг нийт хөрөнгө оруулагчдад мэдээлэхдээ Монголын хөрөнгө оруулагчдад нэгэн зэрэг монгол хэл дээр мэдээлж байх үүрэгтэй гэх мэт.

Хэрэв үнэт цаасны зах зээлийн тухай хуульд ийм зохицуулалт шинээр орж, СЗХ журам тогтоовол гадаад улсын үнэт цаас гаргагчийн хувьд тухайн улсынхаа хөрөнгийн биржид бүртгүүлсний дараа Монгол Улсад хоёр дахь бүртгэлээ давхар хийлгэх, тухайн улсынхаа болон Монгол Улсын биржид нэгэн зэрэг бүртгүүлэх, тухайн улсынхаа биржид бүртгүүлээгүй байхдаа Монгол Улсын биржид шууд бүртгүүлэх тохиолдлуудын онцлог зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Орчин үед хөрөнгийн зах зээл нь нэгэн улсын хилээр хязгаарлагдахгүйгээр улам бүр глобалчлагдаж байна. Үүнийг дагалдан санхүүгийн хямрал, манипуляцид ч хил хязгаар гэж байхгүй. Иймд хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх боломжийг ►



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn

Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард
“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот
Утас: 98907234

САЛБАНУУД:

Баруун 4 зам

Зуун айл

Түгээмэл

Утас: 98626587 todtamga2@yahoo.com

Утас: 98907912 todtamga1@yahoo.com

Утас: 98630499 todtamga3@yahoo.com

► Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бүрдүүлэх шаардлагатай. Иймд уг хуульд гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллахтай холбоотой зохицуулалтыг дараах байдлаар тодорхойлох нь зүйтэй.

СЗХ нь үр нөлөө бүхий хяналт, шалгалтыг гүйцэтгэхтэй холбогдсон мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг дэмжих зорилгоор гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг болон гэрээ байгуулах боломжтой гэдгийг заах нь зүйтэй. СЗХ нь гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагад туслалцаа үзүүлэхдээ хүсэлт гаргагч байгууллагатай хамтран ажиллах талаар санамж бичиг болон гэрээ байгуулсан эсэх, уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх боломжтой эсэх, мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх, Монгол Улсын хууль тогтоомж болон нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх, мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг төлсөн эсэхийг харгалзан үзэх бөгөөд харин гадаад улсын

зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллага нь Хорооноос туслалцаа хүсэхдээ түүний зорилго, мэдээллийг ашиглах зориулалт, нууцлалын талаар дурдсан байвал зохино. Хороо гадаадын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагаас хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг этгээдээс хүсэж болох ба уг хүсэлтэд хариу ирүүлээгүй тохиолдолд Хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. СЗХ-ноос өгсөн мэдээллийг зөвхөн хүсэлтэд заасан, эсхүл тогтоосон зорилгод ашиглах ба тус байгууллагын зөвшөөрөлгүйгээр уг мэдээллийг бусад зорилгоор ашиглах буюу бусад шилжүүлэх, мэдээлэхийг хориглоно гэх мэт зохицуулалт бий болгох шаардлагатай. Тэгж гэмээ нь Монгол Улс эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн /Approved jurisdiction / улс болох боломжтой. Монголчууд “Саалиа хураахаар саваа бэлд” гэдэг. Монголын иргэд байгууллагууд олон улсын хөрөнгийн зах зээлд оролцох, гадаадын бирж дээр арилжигдаж байгаа үнэт цаасыг МХБ-ээс авч, эх орныхоо баялгийн үр шимийг хүртэх зэрэг нь бидний “сааль” юм гэж үзвэл бэлдвэл зохих “сав” нь олон улсын жишигт нийцсэн эрх зүйн орчин билээ. ■



Фотог Э.Зоригт

Made in Mongolia

Эсгий урлалаас загварын төгс шийдлийг харж болно

Х.Хулан

Эсгий туургатан гэдэг нэрээр алдаршсан монголчууд эрт дээр үеэс малынхаа ноосоор эсгий болон амьдрал ахуйдаа хэрэгцээтэй эдлэл хийж ирсэн түүхтэй билээ. Хэдэн мянган жилийн турш нүүдэлчдийн соёл иргэншлийн салшгүй хэсэг болж хөгжижирсэн эсгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнөөдөр дэлхий дахинаа урлагийн хэмжээнд хүрч төгөлдөржсөн байна. Энэ удаагийн “Made in Mongolia” буландаа “Фэлт Монголиа” урлангийн эсгий урлаач Д.Майрагийн уран бүтээлийг танилцуулж байна.

Д.Майрагийн эмээ нь Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумандаа гайхагдсан уран хүн байжээ. Түүний эмээ нь өнгө өнгийн хээ угалзаар чимсэн ширмэл ширдэг хийхийг зуны амралтаараа эмээ өвөөдээрээ очсон ач охин нь сониучирхан хажууд нь харж суухдаа, том болоод эсгий урлаач болно гэж төсөөлж байгаагүй буй за.

“Discover Mongolia” чуулганыг анх санаачлан зохион байгуулагчид өнгөрсөн есдүгээр сард манай сэтгүүлийн “Редакцийн уулзалт”-д оролцохдоо “Монголын уул уурхайг гаднынхан төдийлөн сонирхдоггүй байсан есөн жилийн өмнө уг хурлыг хийхдээ төлөөлөгчдөд тараах цүнхэндээ нэлээд ач холбогдол өгдөг байсан тухайгаа амуралдуулан ярьж билээ. Нэг үгээр хэлбэл, Монголын гэсэн онцлогийг гаргахын тулд эсгий цүнх хийлгэх мэргэн санаа олж байжээ. Гэхдээ зүгээр ч нэг эсгий цүнх биш, үндэсний хэв шинжийг агуулсан өвөрмөц шийдэл загвартай цүнх хийлгүүлэх гэж толгойгоо гашилгадаг байсан гэдэг. Д.Майра “Discover Mongolia”-гийн цүнхийг урладаг байсан хүмүүсийг даргалж ажилладаг байжээ. Тэрбээр мөн дээрх хурлын “Ажил хэргийн ажилсаг цүнх” нэртэй захиалгын талаар дурсамж сонирхуулахдаа “Цүнхний арын хэсэг дээр чуулганд оролцогч бүх

компанийн логог байрлуулсан. Өмнө нь хийж байгаагүй цоо шинэ ажлыг туршилт маягаар хийсэн ч амжилттай болж, шинэ технологийн үндэс болсон” хэмээн ярисан. Тус аргыг одоо Монголд маш өргөнөөр ашиглаж, ямар ч хээг эсгийн дээр хэвлэх аргаар буулгаж байгаа тухайгаа өгүүлсэн.

Д.Майра “Фэлт Монголиа” урлангаа 2008 онд байгуулсан бөгөөд 2010 оноос бие дааж эсгий урлалыг хөгжүүлэхээр зориг шулууджээ. Түүний хамгийн том зорилго чанартай, орчин үеийн хийц загвартай Монгол эсгий бүтээгдэхүүнийг дэлхийн түвшинд түгээн таниулах, эсгийг хэрэглээ болгох явдал аж. Урлангийнх нь ажлын өрөөний модон тавиур дээр самнасан сэвсгэр ноос овоолгоостой байв. Түүний урлан “22-ийн товчоо” орох замд “Монос” дээд сургуулийн хойхно байдаг бөгөөд сонирхсон хүмүүс энд ирж эсгий бүтээгдэхүүн худалдаж авахаас гадна өөрсдөө бүтээл урлах боломжтой. Одоогоор хийсэн бэлэн бүтээгдэхүүн гэвэл резинэн ултай эсгий углааш, гутал, гоёлын силкэн болон өдөр тутмын загвартай ороолт, эсгий шаахайнуудыг байрлуулжээ. Нарийн ноосоор хийсэн бүтээгдэхүүн нягтаршил сайтай байдаг бөгөөд эдний эсгий шаахай, гутлыг угаалгын машинаар угааж болдог байна. Хамгийн сүүлд давхар өсгийтэй шаахай бүтээжээ. Хүний биеийн нийт жин нь тулгуур эрхтэн болох хөлний өсгийн дээр таардаг учраас гутлын өсгий амархан элэгддэг талтай. Тиймээс Майра үүнийг бодолцож давхар өсгийтэй шаахай хийжээ.

Хонины ноос, эсгийгээр баян монголчуудад үндэснийхээ хэв шинжийг хадгалсан, өвөрмөц шийдэлтэй эсгийн гоёлоор гангарах боломж байна. “Фэлт Монголиа”-д чанар сайтай резинэн ултай эрэгтэй, эмэгтэй шаахай 37,000 төгрөгийн, хүүхдийн гутал 18,000 төгрөгийн, хүүхнүүдийн чамирхах дуртай гоёмсог торгон эсгий ороолтыг/Nuno felt scarf нэртэй/ 64,000 төгрөгөөр тус тус зарж байна билээ.

Тэрбээр “Эсгий бүтээгдэхүүнээ хэрэглээний болон загварын ▶

▶ судалгаа хийсний үндсэн дээр гаргадаг. Аливаа шинэ загварыг маш сайн бодож боловсруулсан тохиолдолд ирээдүйн бүтээгдэхүүний 80 хувь нь бэлэн болсонтой адил, үлдсэн 20 хувь нь цэвэр урлан хийх үйл ажиллагаа болдог гэж хэлсэн юм. Түүнээс загварынхаа санааг яаж олдог вэ гэхэд мод, цэцэг тарих дуртай Майра урлангийнхаа гадаах хашаанд ургах чацарганы бутны арзгар дүрсийг хүртэл эсгийн д буулгасан тухайгаа сонирхуулсан. Тэрбээр “Ер нь санааг бол хаанаас ч юунаас ч олох боломжтой. Жишээ нь саяхан би хүүхдүүдтэйгээ “Аватар” кино үзэж байгаад том бөөрөнхий хээтэй ороолт хийсэн” гэлээ.

Хавар дөнгөж нахиалан гарах туяхан ногоон навчис, өвөл будран орох цас, шиврэн орох бороо гээд байгалийн үзэгдэл юмсын мөн чанарыг дизайнер хүн өөрийн загвартаа шингээж, тухайн үеийн бодол, сэтгэл хөдлөлтэй уялдуулан бүтээдэг аж. Майра индианчуудын өмсдөг моккасин шаахайг харж байгаад өмсөхөд хөлөнд эвтэйхэн, дулаахан шаахай хийе гэсэн бодолдоо хөтлөгдөн “Халзан” шаахайны загварыг 2003 онд гаргасан байна. ЮНЕСКО-гоос хоёр жил тутамд шалгаруулдаг “Зүүн Хойд Азийн шилдэг бүтээгдэхүүн”-д энэхүү шаахай 2010 онд орсон байжээ.

Ажлынхаа анхны гарааг Норвегийн тусламжийн байгууллагын “Ноосны өрхийн үйлдвэрлэл, маркетингийн төсөл”-д эсгий урлалын багш мэргэжлээр 2001 онд эхлүүлсэн тэрбээр дээрх төслийг 2007 онд дуустал нь ажиллажээ. Улаанбаатар, Дархан-Уул аймагт хэрэгжсэн уг төсөл сургалт явуулахаас гадна өрхийн үйлдвэрлэгчдийг “Ноосон зангилаа” нэртэй дундын хоршоонд нэгтгэж, бүтээгдэхүүнийг борлуулах “Цагаан алт” дэлгүүрийг байгуулсан билээ. Нийт арваад жилийн хугацаанд хэрэгжсэн “Ноосны өрхийн үйлдвэрлэл, маркетингийн төсөл” нь Монголын эсгий урлагийг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж, эсгийн хэрэглээг бий болгосон гэж хэлж болно. Мөн Майра Монголд нэг хэсэг хийхээ больсон байсан ширмэлийн урлагийг сэргээж, “моодонд” оруулсан. Хонины бүдүүн ноос нь гэрийн эсгий болон хивсэнд сонгомол сайн

чанартайд тооцогддог бол нарийн нарийвтар ноос нь хувцас эдлэл, төрөл бүрийн хэрэглээнд хамгийн тохиромжтой юм. Нарийн ноос нь хялгасгүй, зөөлөн зэрэг давуу талтай.


Норвегийн ноосны хөтөлбөрт олон жил төслийн менежер хийсэн Д.Хишгээгээс чамин ганган хувцас эдлэл хийдэг нарийн, нарийвтар ноосны нөөцийг хэрхэн сайжруулж болох талаар сонирхоход, нарийн болон нарийвтар ноост хонины үүлдрийг сайжруулах бодлого дутагдаж байгааг тэмдэглэсэн. Тэрбээр “Түүхий эдийн хомсдол үүсэхийн хэрээр эсгий урлалд орлуулах эсвэл хослуулах материал, хэмнэлттэй технологийн талаар бодолцох ёстой. Түүхий эдээ өөрсдөө бэлтгэхийн тулд хоршоо өөрийн гэсэн малтай болох ч арга байж болно” гэж хэллээ.

Майра төсөлд ажиллах хугацаандаа шаахай, ширдэг, цүнх, малгай зэрэг эсгий ноосон бүтээгдэхүүний нийт гурван зуугаад загвар бүтээснээс, хорин загвар, хоёр технологитоо Оюуны өмчийн газраас бүтээгдэхүүний патент авчээ. Анх гадаадад бүтээгдэхүүнээ экспортлохын тулд загваруудаа баталгаажуулж, патент авах шаардлага гарсан гэнэ. Хоёр технологийнх нь патентыг танилцуулъя. Эхнийх нь ноос будах жор буюу рецептийг эмхтгэж ноосыг жорлож будах хүснэгтийг байгуулсан. Ингэснээр арван кг ноос будах, нэг зуун грамм ноосыг будахад гардаг тооцооллыг хялбарчилж, будалт хоорондын тооцооноос гардаг алдаа багасжээ. Хоёр дахь технологийн патентыг эсгийн дээр дүрс буулгадаг аргад авчээ. Нийтийн хүртээл болгосон түүний гол загваруудад “Халзан” углааш, “Хелена” шаахай, “Уянга” болон “Эмма” нэртэй хүүхдийн бойтог орно. Эдгээр шаахайг анх Халиунаа /Хелена/, Цагаадай /Эмма/ гэж нэрлэж байсан боловч төсөлтэй хамтарч ажилладаг байсан Норвегийн “ШинКон” компаниас их хэмжээний экспортын захиалга орж ирж, загварын нэрийг европ хүмүүст ойлгомжтойгоор өөрчлөхийг санал болгосны дагуу монгол нэрсийг өөрчилж, патент авсан түүхтэй гэнэ.

Майра өнгөрсөн долдугаар сард анхны бие даасан үзэсгэлэнгээ

“Эсгий онгод” нэртэйгээр Зана-базарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд зохион байгуулжээ. Үүнд тус музейн үзмэрүүд болох буган хөшөө, хадны сүг зураг, ус болох галан хээ мэтийн элементээс санаа авч, эсгий болон хүр хорхойн торгоор өвөрмөц бүтээгдэхүүнийг урласан байна. Тэрбээр монгол эсгий урлагийг зөвхөн дотооддоо хөгжүүлээд зогсоогүй гадаад зах зээлд ч олон хэрэглэгчидтэй болжээ. Онлайн дэлгүүрээр гадаадаас багагүй захиалга авч үйлчилдэг байна.

Гар урлал нь үнэ цэнэтэй, хүний хөдөлмөр болон сэтгэл шингэсэн, загварын төгс шийдэлтэй байдгаараа бусад бүтээгдэхүүнээс ялгаатайг Майра онцоллоо. Гар аргаар хийсэн урлалын гайхамшигийг олон нийтэд таниулах мөрөөдлөө биелүүлэх эхлэлээ хэдийнэ тавьсан энэ залуухан эмэгтэйд олон сайхан загвар гаргахын ерөөлийг сэтгүүлийнхээ нэрийн өмнөөс дэвшүүлж байна. ■



PPP түншлэл

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон МҮХАҮТ-аас “Хөгжилд хүрэх түншлэл” чуулганыг зохион байгуулахаар ажиллаж байгаа билээ. Энэхүү чуулганы талаар холбогдох хүмүүсээс товч тодруулга авсан юм.

Төр нь хувийн хэвшлээсээ хоцорч байна



МҮХАҮТ-ын Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Нэрбуй:

-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа буюу PPP гэдэг ойлголтын талаар иргэд хэр мэдээлэлтэй байна вэ?

-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа буюу PPP гэсэн ойлголтыг анх оруулж ирсэн байгууллага нь Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим. 1999 оноос өнөөг хүртэл төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар байр сууриа илэрхийлж, ярьсан маань өдгөө ажил хэрэг болоод явж байна. Нийгмийг үүрч яваа хүмүүс нь хувийн хэвшил. Тиймээс ч Монгол Улсын эдийн засагт хувийн хэвшил давамгайлж байна. Иймээс хувийн хэвшлийнхэн төрийн бодлого, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох шаардлагатай байгаа юм. Өөрөөр хэлбэл, төр нь хувийн хэвшлээ сонсдог, санал хүсэлтийг нь хүлээж авдаг, хамтран ажилладаг, итгэл үзүүлдэг байх нь төр, хувийн хэвшлийн хамтран ажиллаж байгаагийн нэг илэрхийлэл. Эдийн засгийн холбоотой шийдвэр гаргахдаа хувийн хэвшлийн санаа бодлыг сонсдог болох нь төр, хувийн хэвшлийн түншлэж буйн илрэл юм.

-Хувийн хэвшлийнхэн өөрсдөө хэр санаачлагатай байна вэ?

-Хувийн хэвшлийнхний оролцоо нь байгаа хэдий ч идэвхгүй хандлага ажиглагдаж байна. Асуудлыг мэдэж байгаа мөртлөө санаачлагатай оролцдоггүй. Төрөөс гарч буй хууль, дүрэм, журмыг хянаад, шаардаад байвал уг нь байдал улам л сайжрах учиртай шүү дээ.

-“Хөгжилд хүрэх түншлэл” чуулганаар ямар асуудлыг хөндөх вэ?

-Төр, хувийн хэвшил хоёр талаасаа уулздаг, асуудлаа хэлэлцдэг байнгын механизм хэрэгтэй. Энэ механизм нь Төрийн талаас Сангийн сайд, хувийн хэвшлээс Танхимын даргаар Төр, хувийн хэвшлийн хамтын хороо тэргүүлдэг. Хорооны анхны ажил нь “Хөгжилд хүрэх түншлэл” чуулган. Чуулганаар асуудлаа нээлттэй хэлэлцэж, дараа дараагийн ажлаа төлөвлөх юм. Төрийн үйл ажиллагаа сайжирна. Ил тод байна. Өнгөрсөн онд Засгийн газрын тогтоолоор хувийн хэвшлийн үндэсний стратеги гэж баталсан. 2009 онд Төр, хувийн хэвшлийн төрөөс баримтлах бодлого гэж гарсан. Бидний санал санаачлага удаан ч гэсэн хэрэгжиж байна. Хөдөө орон нутагт төр, хувийн хэвшлийн салбар хороо байгуулагдах юм. Яамдууд мөн салбар комисс байгуулна.

-Танхимын зүгээс төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд дэмжлэг болохуйц ямар ажил хийсэн бэ?

-2009 оноос Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Хууль зүй дотоод хэргийн яам, Танхим хамтраад “Хуулийн их цэвэрлэгээ” хөтөлбөр хэрэгжүүлсэн. Манай хууль эрх зүйн орчин чинь бие биенээ үгүйсгэдэг. Хоорондоо зөрчилдөх зүйл, заалт цөөнгүй бий. Иймэрхүү зүйл заалтыг нь цэвэрлэсэн. Эхний ээлжинд 81 хуулийн болохгүй байгаа заалтыг нь гаргаж ирлээ. Дараагийн алхам нь засаж, шинэчлэх. Мөн 2010 оныг Бизнесийн орчныг шинэтгэлийн жил болгон зарласан нь тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгсөн. Төр нь хувийн хэвшлээсээ хоцроод байна. Зэрэгцээд явж байх ёстой. Төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгэмд шилжүүлэх шаардлагатай. Барилгын салбарт л гэхэд 140 гаруй гарын үсэг авч байна. Үүнийг хөнгөлөх үүднээс мэргэжлийнх нь холбоодод өгчих хэрэгтэй. Барилгын салбарын долоо, найман гарын үсэг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ гэсэн шийд гарсан боловч одоо болтол хүчин төгөлдөржөөгүй байна.

Бүхнийг төр хийхгүйгээр хамтраад хийх арга замыг хайна



Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийн дарга Б.Ариунбаяр:

-Төр, хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллахаар болж байгаа нь сайшаалтай санагдлаа. Чуулганы гол зорилго ч ийшээ хандах байх.

-Өнгөрсөн жилийг бизнесийн орчны

шинэтгэлийн жил хэмээн зарласан. Шинэтгэлийн жилийн хүрээнд “Хөгжилд хүрэх түншлэл” чуулганыг зохион байгуулах гэж байна. Засгийн газраас хувийн хэвшлийг хөгжүүлэх үндэсний стратегийг баталсан. Тиймээс бодлогын хүрээнд үндэсний үйлдвэрүүдээ хөгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн хоорондын яриа хэлэлцээрийг өрнүүлнэ. Тулгамдаж байгаа асуудлаа шийдэх, төрийн хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагын

Уншигчийн булан

Хичээл заалгасан мэт мэдлэг олж авах боломжтой

Д.Дагиймаа /Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч/:

-Монгол Улсын эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа өнөө үед “Mongolian Economy” сэтгүүл мэндэлсэн нь сайшаалтай. Уг сэтгүүл нь эдийн засагт хамаарах тодорхой нэг сэдэв дээр тулгуурлан, олон талын байр суурийг гарган бичдэг нь чухал ач холбогдолтой юм. Энэ нь нэгдсэн цогц мэдлэгийг өгөх сайн талтай. Тухайлбал, нийгмийн хариуцлагын

тухай тодорхой мэдээлэлгүй байсан хүн “Mongolian Economy” сэтгүүлийг уншсанаар энэ талын багц ойлголттой болж чадах жишээтэй. Өөрөө хэлбэл, хичээл заалгасан мэт мэдлэг олж авах боломжтой гэсэн үг.

Хэдийгээр тухайн сэтгүүл эдийн засгийн мэдээ, мэдээллийг түлхүү бичдэг ч олон талын ач холбогдолтой, унших сонирхлыг өдөөсөн номын булан, эрүүл мэндийн зөвлөгөө гаргадаг нь таалагддаг.

Бодит эдийн засагт үзүүлэх ач холбогдол нь өндөр

Оливер Белфитт-Наш /“Монет Капитал” хөрөнгө оруулалтын банкны судлаач, шинжээч/

“Mongolian Economy” сэтгүүл асуудлын гүнд нь орж, мэдээллийн хувьд дотоод болоод гадаадын уншигчдын аль элэнд нь хүртээмжтэй байх бололцоог хангаж өгсөн байдаг. Ниймтлэлийн

сэдвийн хувьд өргөн хүрээг хамарч, нягт нямбай боловсруулалт хийж чадаж байгаа нь сайшаалтай. Мөн жирийн иргэнээс эхлүүлэн шийдвэр гаргагч түвшинд ч ард түмний санаа бодлыг тусгадаг болохоор тус сэтгүүлийн бодит эдийн засагт өгөх үр өгөөж нь ч өндөр юм.

“Шинэ санаа ба бизнес” булангаа тогтмол явуулахыг хүсье

С.Байгальмаа /“Батбайгаль” ХХК-ийн ерөнхий захирал/:

-Би “Mongolian Economy” сэтгүүлээс эдийн засгийн олон талын мэдээллийг авч чаддаг болохоор захиалан унших дуртай. Завгүй ажилтай бидэн шиг хүмүүст хялбархан аргаар өөрт хэрэгтэй мэдээллийг авах боломжийг энэ сэтгүүл олгодог

юм. Түүнчлэн сэтгүүл дээр гарсан санхүүгийн зах зээлийн үнэ, ханшийн талаарх мэдээллийг тогтмол хардаг.

Мөн сэтгүүлийн “Шинэ санаа ба бизнес” гэдэг миний хамгийн унших дуртай булан билээ. Тиймээс та бүхнээс уг булангаа тогтмол гаргахыг хүсье.

Гадаадынханд Монголыг таниулах гарын авлага болж чаддаг

Г.Баттөр /“Оюутолгой” ХХК-ийн аяллын хэсгийн ажилтан/:

-Англи, монгол хэл дээр гардаг нь маш их таалагддаг. Энэ нь нэг талаар эдийн засагтай холбоотой гадаад үг мэдэж авахад тус болдог. Нөгөө талаар гаднынхан манай орныг туйлаас сонирхож байгаа өнөө үед Монголын эдийн засаг,

бизнесийг танилцуулах гарын авлага болж чаддаг байх. Мөн нийтлэлүүдээ шинэ шинэ баримтаар баяжуулж чаддаг болохоор сонирхолтой санагддаг. Танай сэтгүүлийг уншдагтаа сэтгэл хангалуун байдаг. Цаашдаа ч “Mongolian Economy” сэтгүүлийг байнга захиалан унших болно.

» төлөөлөл хоорондоо зөвлөлдөж, ярилцах юм. Санаа бодлоо нэгтгээд цаашид хийх ажлаа ч төлөвлөнө. Нэгдсэн ойлголттой болох юм.

-Бизнесийн орчин сайжирсан уу?

-Оролцооны аргад тулгуурлаж нийгмийн хөгжил явдаг болжээ. Төр, хувийн хэвшлийн хамтын оролцоог идэвхжүүлэхийн тулд чуулганаар үндсэн хоёр чиглэлээр ярилцана.

Бизнесийн орчин таатай болсон уу гэдэгт ч үнэлэлт, дүгнэлт өгөх юм. Татварын шинэтгэл хийж, татварын ялгавартай бодлого явуулах, үйлдвэрлэгчдээ дэмжихэд энэ удаагийн чуулган томоохон ач холбогдолтой. Мөн бизнест үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэх, зээлийн нөхцлийг сайжруулах асуудлыг чуулганаар хэлэлцэнэ. Хөрөнгө санхүүгийн орчин хувийн хэвшилд

хэрхэн наалдаж, үр өгөөжтэй байгаа эсэхийг чуулганаар дүгнэх учиртай. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг томоохон бүтээн байгуулалтад татан оролцуулах, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод хэрхэн шилжүүлэх асуудлыг ч хөндөх юм. Бүхнийг төр хийхгүйгээр хамтраад хийж болох арга замыг хайна гэсэн үг. ■



Амьдрал

Харанхуй дундах гэрэл

Э.Зоригт

Түүний амьдрал харанхуй ямар ч гэрэл сүүдэргүй. Өөрийгөө толинд харж үзээгүй. Долоохон настай тэр үеийн бүдэгхэн төсөөллийг тархиндаа цоожилсон нэгэн залуугийн амьдрал өнгөгүй. Гэхдээ гэрэлтэй. . .

Хотын энхэл донхол замаар дохиогоо хангинуулж, амандаа ямар нэг юм үглэсэн ууртай жолооч нар гэрэлт ертөнцийг харах хараагүй хүн зам гарч байна гэж тоосон шинжгүй дайрах шахам давхина. М.Цэнгэлийн хувьд хамгийн аймаар мөч энэ юм. Энэхүү нийтлэлийн маань эзэн М.Цэнгэл “Би сүүлийн үед жолооч нарыг жолооч гэж хэлэх дургүй болсон. Тэд жинхэнэ утгаар нь машин барьж чаддаггүй, дээрээс нь ямар ч хүн чанаргүй хүмүүс. Би амьдралынхаа гол хөтөч болсон таягаа жилдээ цөөнгүй удаа машинд дайруулдаг. Зарим ууртай нэг нь таягаа зориуд дайруулж мөнгө авах гэлээ гэж ч загнах тохиолдол бий” хэмээн хараагүй иргэдийн зовлонгоос хуваалцсан билээ.

Сохор аз, сонсох мэдрэмжиндээ найдаж арай хийн зам гараад автобусны буудал дээр М.Цэнгэл ирлээ. Хүн тээвэрлэдэг мөртлөө

мах ачсан мэт явдаг нийтийн тээврийн хэрэгслийн хүнд дугуй тоормосоглох дуунаар тэр “Энэ аль чиглэлийн автобус вэ” гэж хэн нэгнээс хариу эрэн асууна. Харин хэн ч үл хариулна. Бидний хувьд наран ээж, үүл хөвөрсөн цэлмэгхэн өглөө ч Цэнгэлийн хувьд олон янзын дүр төрхтэй иргэдийн царайг ч төсөөлөхгүй бадар харанхуй орчинд “Нисэх-Багшийн дээд” чиглэлийн унаа хайн тэмтчинэ. “Нийтийн тээврийнхэн нэгэн хэсэг аль чиглэлд явах, хаана зогсож байгаагаа хоолойгоо сөөтөлорилдог нь бидэнд ядаргаатай санагддаг байсан бол хараагүй хүмүүсийн хамгийн хэрэгтэй үйлчилгээ байж.

Хоёр ч автобус дамжин байж Цэнгэл Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн харъяа хараагүйчүүдийн DAISY номын сангийн ажилдаа хожигдохгүйг хичээн ийн яаран ирэв. Тэрбээр хамгийн түрүүнд компьютерийнхээ ард суугаад “Yahoo” цахим шуудангийн хаягаа шалгаж, “Facebook”-ээр зочилно. Гадна, дотнын анд нөхдөөс нь олон зурвас илгээжээ. Олон улсын зарим нэг томоохон байгууллагаас ч ажил

төрлийн холбоотой захидал ирсэн харагдана. Бүгдтэй нь уншиж танилцаад, хариу бичиж ч амжлаа. Тэрбээр яг л хараатай хүмүүсийн адил ажиллах юм. “Бидний хэрэглэдэг энгийн компьютерт хараагүй хүмүүст зориулсан дэлгэц, уншигч тусгай программ суулгасан тул ажрах зүйлгүй. Гэхдээ ийм компьютер дээр ажиллахын тулд багагүй хөдөлмөрлөх хэрэгтэй” гэсэн юм.

Цэнгэл багын л мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшихийг мөрөөддөг хүүхэд байжээ. Хэдийгээр долоохон насандаа өвчний улмаас хараагүй болсон ч мөрөөдөлдөө хүрэхийн тулд уйгагүй хөдөлмөрлөсөн байна. Шантрах, өөрийн хувь заяандаа гомдох, бачимдах үе олон тохиолдсон ч зовлон бэрхшээлийг давж гарах, мэдэхийн төлөөх хүсэл эрмэлзлэлээсээ ухарч байгаагүй. Монгол Улсын хувьд хараагүй хүмүүст зориулсан ном тун ховор, тэрдундаа мэдээллийн технологийн талаарх гарын авлага огт байхгүй. Тиймээс мэдлэгийн хүрээгээ тэлж, интернэтийн ертөнцөөр аялж, мөрөөдлөө биелүүлэхийн тулд англи хэл сурахаар зорьжээ. Өнөөгийн зарим залуус англиар “зүүдэлдэг” болох мөрөөдлөө биелүүлж чадахгүй явахад, Цэнгэл аль 2000 оны үед бие даан англи хэл сурч эхэлжээ. Дэлхийн хэлийг сурч мэдэж, шар толгойтнуудтай чөлөөтэй ярьж харилцахад нь Монгол-Америкийн хамтарсан “Сантис” төвийнхөн багагүй туслалцаа үзүүлсэн байна. Түүнд багш нар нь тусгай программаар биш энгийн хүмүүст зориулсан заах аргын дагуу л хичээл заадаг. Юунд ч түүртэхгүйгээр сурдаг сайн сурагч байсан гэсэн шүү. Тэрбээр “Бурхан надад тусалсан байх. Англи хэл сурах талаар бодож явтал 2002 оны үед нэгэн хурал дээр Ц.Оргилмаа захиралтай таарсан. “Сантис” төвийн захирал явж байна гэдгийг дуулаад гүйхээгээрээ очиж уулзаад л би англи хэл сурмаар байна, та туслаач гээд хэлчихсэн. Гэтэл захирал дуртайяа зөвшөөрч, сургалтын төлбөрөөс ч чөлөөлсөн гээд бод доо. Гадаад, дотоодын сайн багш нар, сургалт сайтай энэ төвд суралцах эрх өгч, миний амьдралд гэрэл нэмсэн “Сантис”-»

ын захирал Ц.Оргилмаа эгчид үнэхээрийн баярлаж явдаг” гэсэн юм. Оргилмаа захирал ч түүнийг тэвчээртэй, маш шаргуу зүтгэлтэй хүн гэж дүгнэсэн. Өвлийн тэсгэм хүйтэн, халтиргаа гулгаатай үед ч таягаараа газар тогшиж, унаж туссаар хичээлдээ ирдэг. Гэтэл ертөнцийг харах нүдтэй мөртлөө сурахын төлөө хичээхгүй залхуу хүмүүс олон байна” хэмээн тэрбээр хэлсэн.

Цэнгэл хувь заяатайгаа эвлэрээд гар хумхин сууддаггүй, хөдөлмөрч залуу. Англи хэл сурч эхэлснээсээ хойш интернэтээс өөрийн хүссэн мэдээллээ олж авахын зэрэгцээ багын мөрөөдөлдөө хүрч, Монгол Улсын хамгийн анхны хараагчүүдийн компьютерийн багш болжээ. Мөн АДРА олон улсын байгууллагатай хамтран 116 дугаар сургуулийн дэргэд хараагүй хүүхдүүдэд зориулсан сонсдог номын студи байгуулж амжжээ. Хараагчүүдийн үндэсний төвийн дэмжлэгтэйгээр гаднын олон оронд мэдээллийн технологийн сургалтад хамрагдсан байна. 2008 онд Тайландад сургалтаар явахдаа одоо ажиллаж байгаа DAISY номын талаар ойлголттой болж технологийг нь эзэмшсэн аж. Энэхүү сонсдог номыг технологийн дэвшлийг ашиглаж хараагүй уншигчдад яг л хэвлэмэл ном уншиж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх үүднээс өөрийн дуртай бүлэг, хуудсаа сонгох боломжийг хялбаршуулсан байдлаар хийжээ.

Цэнгэл сонсдог номын тухай 2008 оны үед мэдсэн хэдий ч хөрөнгө мөнгөний дутагдлаас болж зорьсон ажлаа эхлүүлж чадахгүй 2010 оныг хүрсэн гэнэ. Хоёр жил орчим дээгүүр доогуур явж, хандив мөнгөгүйгаад бүтээгүй байна. Харин 2010 оны нэгдүгээр сард Слованы номын санг дэмжих байгууллагаас олон улсын хэмжээнд номын сангийн төслийн шалгаруулалт зарласныг интернэтээс олж мэдээд ойр дотныхоо хэдэн хүнтэй хамтраад төсөл бичээд явуулчихаж. Төслийн шалгаруулалтын дүн гарах хүртэл “Ямар мэдээ сонсох бол гэхээс сэтгэл нь түгшээд унтаж ч чадахгүй байсан гэдэг. Тэгвэл өнөөдөр бурхан ивээж түүний төсөл тэнцээд ажил хэрэг болоод ийн явж байна. Ингээд энэ төслөөс ном

уншигч 40 төхөөрөмж, мөн тухайн номыг хийдэг программ дагалдах хэрэгслийн хамт өгчээ. Одоогоор аймгуудын хараагчүүдийн номын сан, зарим хараагчүүдийн байгууллагад дээрхийн адил 25 ном уншигчийг тараагаад байгаа. Түүний 15 нь DAISY номын санд байдаг. Гэвч эдгээр нь хүрэлцээтэй байж чаддаггүй тухай Цэнгэл сэтгэл дундуур ярилаа. Хараагүй хүмүүс мэдээ мэдээллээс хэтэрхий хоцорч байгаад тэрбээр ихэд санаа зовнидог тул цаашид ч тусалцаа үзүүлэх байгууллага, хүмүүс хайх эрэлд явах гэнэ.

Тэрбээр өөрийн орны хөгжил, хүмүүсийн харьцаа зэрэгт сэтгэл дундуур явдгаа нуусангүй.

хэмээн ярьсан юм.

Өнөөдөр Цэнгэл DAISY номын мэргэжилтэн, мэдээлэл технологийн ажилтан багш, англи хэлтэй, мөн сайн хань, сайн эцгийн үүргийг биелүүлж, өөрийн бардам түүхийг бүтээж явна. Тэрбээр “Би амьдрал гэдгийг хийж бүтээхийн нэр гэж ойлгодог. Хэдийгээр бусад хүнийг бодвол хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн хүнээс гуйхгүй болж өгвөл хэн нэгэнд тус хүргэх юмсан гэж хичээдэг” гэсэн юм.

30 насны босгон дээр ирсэн энэ залууд ирээдүйд сурах, хийх зүйл их байна. Тэрбээр гэргий Т.Мөнхтуултайгаа анх “Хараагчүүдийн нөхөн сэргээх сургалтын төв”-д танилцжээ.



“Тухайлбал, хаана ч явсан хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа хараагүй иргэдэд зориулсан зам, гарц юу ч алга. Гаднын ихэнх оронд замын гэрлэн дохио нь ярьдаг, түүнчлэн гарцан дээр ирэхэд налуу болох аль эсвэл таягаар тэмтрэгдэх хэмжээний нүхтэй байдаг. Телевизийн мэдээ сонсохоор манай орон хөгжөөд байгаа тухай яриад л байх юм. Гэтэл бидэн шиг хүмүүст хөгжиж буй эсэх нь мэдэгдэхгүй байна. Хотын хөгжил яах вэ гэхэд хүмүүс нь хотын соёлгүй, олон нийтийн үйлчилгээний газар нь ямар ч хүнлэг харьцаа байхгүй. Адаглаад эхнэр бид хоёрыг ойр зуурын хэрэглээгээ залгуулахаар дэлгүүрт ороход та юу авах вэ гээд асуух хүн ховор. Бид чинь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шүү дээ”

Зовлон жаргалаар ойролцоо өөрөөр хэлбэл, эхнэр нь мөн л хараагүй, гэхдээ нөхрийгөө бодвол бүдэг бадаг юм хардаг аж. Тэд өдгөө хоёрдугаар ангийн хөөрхөн охинтой. Алаг нүдэн охиныхоо дүр төрхийг аав нь хэзээ ч хараагүй ч хорвоог харах нүдтэй болж төрсөнд нь баярлаж, сэтгэл зүрхэндээ төсөөлөн хайрлаж, хамгаалж явна. Охиноо хүний зэрэгтэй сайн хүн болгож хүмүүжүүлэх том үүрэг хүлээсэн энэ гэр бүл ирээдүйд дөрвөн хүүхэдтэй болохыг хүсдэг. Хүний биеийг олж төрсөн л бол хүн шиг сайхан амьдрах туйлын хүсэл сэтгэлийнхээ галаар хорвоог харж, гэрэлтүүлж яваа түүний хичээл зүтгэл гайхалтай. Тэрбээр мөрөөдлөөр жигүүрлэн түүндээ хүрч яваа эр хүн. ■



Иргэний нисэх

Ирээдүйдээ итгэл төгс “Изинис Эйрвэйз”-ийнхэн

Х.Хулан

Изинис Эйрвэйз” компани үйлчилгээндээ хоёр онгоц шинээр нэмлээ. Орон нутгийн нийслэгийн 75 хувийг гүйцэтгэж буй тус компанийн хувьд агаарын хөлгөө ийнхүү нэмэгдүүлж байгаа нь сайн мэдээ. Тиймээс ч “Изинис Эйрвэйз”-ийн хамт олон нэлээд хүч хөрөнгө зориулж авсан шинэхэн хөлгүүдээ танилцуулах үүднээс сэтгүүлчдийг урьж, Улаанбаатар хотын дээгүүр 50-иад минутын нислэг үйлдсэн юм.

“Avro RJ 85” маркын дээрх хоёр тэнгэрийн хөлөг нь шороон болон хатуу хучилттай зурвас дээр нислэг үйлдэх чадвартай, 93 зорчигчийн суудалтай, тийрэлтэт хөдөлгүүртэй аж. Тус компани өнөөдрийн байдлаар Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл, Ховд, Увс, Завхан, Өвөрхангай зэрэг арван аймгийн 14 чиглэлд, мөн олон улсын хоёр чиглэлд Өвөр Монголын өөртөө засах орны Хөлөнбуйр аймгийн Хайлаар хот,

ОХУ-ын Буриадын нийслэл Улаан-Үд хот руу тогтмол болон захиалгат нислэг үйлдэж байна. Өнөөгийн байдлаар нийт зургаан / дөрвөн СААБ 340Б, хоёр Авро Ар Жэй 85 маркийн онгоц/ агаарын хөлөгтэй болсон “Изинис Эйрвэйз” компани боловсон хүчний асуудалдаа маш их анхаарал хандуулдаг. Нисгэгчийн мэргэжлээр арван хүнийг АНУ-д сургаж бэлтгэхээс гадна, дотоодын их дээд сургууль төгсөгчдөөс сонгон шалгаруулалт хийж, эхний ээлжинд таван залуусыг Тайвань дахь “Люфтханза”-гийн техник үйлчилгээний сургалтын төвд явуулжээ.

Иргэний агаарын тээвэр нь мэргэжлийн өндөр ур чадварын түвшин, байнгын сургалтыг шаардсан салбар юм. Монгол Улс хүн ам цөөтэй, жижиг улс гүрэн гээд олон улсын стандарт дүрэм журмыг мөрдөхгүй эсхүл доод түвшинд байлгана гэсэн ойлголт байхгүй. Иймээс ч “Изинис Эйрвэйз” ▶

► нь Америк, Швед, Англи, Швейцарь, Хятад, Солонгос зэрэг улс оронд зохион байгуулагддаг мэргэжлийн сургалтуудад ажилтнуудаа байнга оролцуулж, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж иржээ.

2012 онд ашиглалтад орох Ангар

“Изинис Эйрвэйз” компани “онгоцны гараж” буюу өөрөөр хэлбэл, агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ хийх томоохон барилгыг 2012 оны эхээр ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Английн “Жон Рэйд энд Сонс” компанид тусгай захиалгаар хийсэн ган хийцэн энэхүү Ангар нь 74 метрийн өргөн, 66 метрийн урттай, зургаан онгоц байрлуулах багтаамжтай, 3600 ам.метр талбайтай аж. Тус компанийн гүйцэтгэх захирал С.Мөнхсүх “Маш их хөрөнгө оруулалтаар босож байгаа энэ байшинг бид олон жил хүлээсэн. Иргэний агаарын тээвэрт хямд юм гэж байдаггүй. Багаж төхөөрөмжөөс авахуулаад бүгд өндөр стандарттай байх шаардлагатай. Бид ирээдүйдээ итгэлтэйгээр иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт хийж байгаа юм” гэв.


Агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” компани нь 2006 онд “Ньюком” группын хөрөнгө оруулалттайгаар үүсэн байгуулагдаж, Улаанбаатар-Чойбалсангийн чиглэлд анхны хуваарьт нислэгээ хийжээ. Өнөөгийн байдлаар нийтдээ 360 гаруй

ажилтантай. Иргэний агаарын тээврийн салбарт хувийн хэвшлийг төлөөлөн анхлан “Изинис Эйрвэйз”-ийг орж ирэхэд иргэний нисэхийн зах зээл нэлээд хүндрэлтэй байсан гэдэг. Цөөхөн онгоцтой, мөн зорчигч тээвэрлэлтийн урсгал бага байсан энэ үед тус компани дотоодын зах зээл дээр өөрсдийн эрс шийдэмгий үйл ажиллагаа явуулснаар агаарын тээврээр зорчих зорчигчдын урсгалыг нэмэгдүүлж чадсан гэж үздэг. Төрөл бүрийн шинэчлэл хийж, жуулчдын урсгалыг ч сайжруулан, өөр шинээр нисэх чиглэлийн тоог ч нэмсэн байна. Одоо тус компани боловсон хүчин, техник технологийн өөрөөр хэлбэл, олон улсын чиглэлд нисэх бүх л бэлтгэлээ базааж буй аж. Өөрөөр хэлбэл, төрөөс боломж нөхцөлийг бүрдүүлээд өгвөл итгэл дүүрэн хариуцлагатай ажиллах боломж нөхцөлөө бүрдүүлээд буй тухайгаа удирдлагууд нь дуулгасан.

Тэд үйл ажиллагаандаа дэвшилт техник технологи, ур чадварыг нутагшуулахыг Германы “Люфтханза” ба Японы “АНА” болон бусад түнш байгууллагуудтайгаа хамтран зорьж ажилладаг нь тэдний давуу тал гэж хэлж болно.

Эцэст нь тэнгэрийн хүлгээр дүүлэн нисэж, зах хязгааргүй орчлонгийн холыг хором минутаар ойртуулан хосгүй эрхэмсэг ажил эрхэлдэг “Изинис Эйрвэйз”-ийн хамт олонд “Mongolian Economy” сэтгүүлийн хамт олноос амжилт хүсье. ■

Хуваарьт зорчигчийн тоо



Монгол улсын дотоодын зорчигчдын тоо ирэх арван жилд 10 дахин өсөх магадлалтай



Эх сурвалж: “Изинис Эйрвэйз” компани

Амьсгалдаг байшин

<http://www.mongolianeconomy.mn>



Идэр есийн хүйтэнд цас орж, хүчтэй шуурга тавих ажээ. Дулмаа ажилдаа явахаас өмнө гал түлж, гэрээ дулаацуулахаар зуухныхаа өмнө бөхөлзөнө. Түлсэн гал нь ч урамтай дүрэлзэж, Дулмаа ч ажилдаа гарлаа. Түүний ажил өглөө 08:00 цагт эхэлж, оройн 18:00 цагт тарах бөгөөд нийтийн тээвэр хүлээх, замын түгжрэлд орж явсаар нэгээс хоёр цагийн дараа арай хийж гэрийн бараа харна. Харин өдөржин эзэнгүй байсан гэр нь түүнийг ороод ирэхэд нь дөнгөж саяхан гал түлсэн мэт дулаахан угтах.

Дулмаа энэ зун “М-солид” компанийн Монголд шинээр нэвтрүүлж буй дулаан алддаггүй магnezитэн хавтан/SIP/-гаар 30 ам метр байшинг 10 мянган ам доллараар бариулсан аж. Энэ хавтангаар барьсан байшин нь дулаан алддаггүй бөгөөд дулааныг бүтэн өдөр хадгалах чадвартай гэсэн шүү.

Өвөл болохоор л Улаанбаатарын утаа хоолой хорсгодог өнөө үед бид хямд, эрүүл мэндэд хоргүй аргаар хэрхэн дулаацаж болох олон аргыг хайж утаагүй зуух, боловсруулсан түлш зэргийг хэрэглээнд нэвтрүүлж эхлээд байгаа билээ. Эдэн дундаас дулаанаа хадгалах гэдэг хамгийн чухал нь. Манайхны мод, тоосго болон бусад материалаар барьсан байшин нь дулааны гуравны хоёрыг цонхоор, гуравны нэгийг нь хаалгаар алддаг аж. Түүнчлэн хана, тааз, шал зэргээрээ ч тодорхой хэмжээний дулаан алддаг байна. Тиймээс бид хэчнээн бүрэн шаталттай зуух хэрэглэсэн ч гэсэн бий болгосон дулаанаа алдсаар байвал гал түлсээр, утаа гарсаар байх болно гэдгийг учир мэдэх хүмүүс хэлж байна.

“М-солид” компани магnezитэн хавтанг хоёр жил гаруйн өмнөөс үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд Монголын хатуу ширүүн уур амьсгалд тохирсон, байгальд ээлтэй бүтээгдэхүүн гаргаж авахын тулд шаргуу хөдөлмөрлөжээ. Уйгагүй ажилласны үр дүнд тухайн компанийн хамт олон саяхнаас чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг өөрсдийн гэсэн

шинэ технологиор хийж чадаж. Байгальд ээлтэй уг бүтээгдэхүүнийг хийхийн тулд юуны өмнө гол түүхий эд байгалийн гаралтай цагаан чулуунаас гаргаж авсан магнийн исэл(MgO) нь магnezитийн(MgCO₃) задралын дүнд үүссэн цагаан өнгийн нунтгийг урд хөршөөс оруулж ирэх шаардлагатай. Гэхдээ тэд ойрын хугацаанд өөрсдөө түүхий эдээ гаргаж авах төлөвлөгөөтэй байгаа юм байна. Ийнхүү импортоор авчирсан түүхий эдийг барьцалдуулагч болон өөр бусад химийн бодистой хольж зуурмагийг бэлдэнэ. “Ямар нэмэлт бодис хийдэг нь ерөнхий инженерийн нууц” гэсэн юм. Бэлэн болсон зуурмагаа дараагийн дамжлага руу явуулж, зуурах машинд хийнэ. Үүний дараа зуурмагийг хэлбэржүүлэх машинд оруулдаг юм байна. Мөн дээвэр, хана, шал аль эсвэл траншейны таг зэргийн алийг нь хийхээс хамаарч өөр орц, өөр аргаар зуурмагийг бэлтгэж хэлбэрт оруулна. Тодорхой өгөгдлийн дагуу гарч ирсэн мөлгөр гадартай ба даавуун артай магnezитэн хавтангийн хооронд галд тэсвэртэй хөөсөнцөрийг сэндвич хэлбэрээр жийрэглэж барьцалдуулан хатаасны дараа дулаан алддаггүй барилгын материал бэлэн болно.

Ийнхүү бэлэн болсон материал нь хөнгөн, зөөвөрлөхөд хялбар, бат бөх гээд олон давуу талтай. Түүнчлэн, эрчим хүчний хэмнэлттэй учраас түлшний зардлыг бууруулаад зогсохгүй шөнө CO₂-ыг шингээж, өдрийн цагаар O₂ ялгаруулж “амьсгалдаг” тул ногоон байгууламжийг хамгаалдаг гэсэн үг гэнэ. Мөн уг хавтангаар барьсан байшинг салгаж зөөвөрлөхөд чанараа алддаггүй ажээ.

Одоогоор “М-солид” компани, “Мянганы сорилтын сан”-тай хамтран гэр хорооллын айлуудад монгол гэрийн үүдний, манайхны ярьдгаар амбаар захиалгаар хийж буй бөгөөд энэ нь нэлээд эрэлттэй байгаа гэнэ. Тус компанийн хэтийн зорилго сэргээгдэх эрчим хүч болоод хүний биеэс ялгарч буй дулаанаар халдаг бөгөөд дулаанаа алддаггүй байшинг зохион бүтээх аж. ■

Бизнесээ бодитойгоор үнэлж сурцгаая!

Бизнесийн гараагаа эхлүүлэхийн өмнө Та эхний ээлжинд бизнес тань бодит амьдрал дээр хэр зэрэг үр ашигтай болох вэ гэж онолын хувьд үнэлэн дүгнэх хэрэгтэй. Дараах асуултууд Таныг цаг хугацаа, хүчин зүтгэл болон өөрийн хөрөнгө мөнгөөрөө дэнчин тавьж аз туршихаас өмнө төлөвлөсөн санааны үнэлгээг хийхэд тус болно. Аливаа бизнес санаанд дүн шинжилгээ хийхдээ практик хэрэглээн дээр хэрхэн бууж болохыг нь онол дээр туршиж үзээрэй. Гаргаж буй санаа бүр баталгаатай хэрэгцээнд зориулагдсан, бэлэн байгаа зах зээлд тохирсон, Та болон бусдын зүгээс гаргасан хөрөнгө оруулалтад найдвартай ашиг орлогын үндэс суурь болохуйц байх шаардлагатай. Эдгээр “түлхүүр асуулт” таны бизнес санааг хамгийн зөв үнэлж чадна. Бизнес эрхлэх сонирхолтой хүн бүр дараах асуултаар бизнесээ үнэлээрэй.

1. Таны бизнес санаа ямар эрэлт хэрэгцээг хангах вэ? Төлөвлөж байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ тодорхой нэгэн асуудал бэрхшээлийг шийдвэрлэх үү?
2. Таны зорилтот зах зээл хэн бэ? Та үйлчлүүлэгчдийнхээ дунд хүн ам зүйн судалгаа явуулах зайлшгүй шаардлагатай. Тэдний нас, хүйс, гэрлэлтийн байдал, оршин байгаа газар, үндэс угсаа, шашин шүтлэг, орлого, худалдааны зуршил, амьдралын хэв маяг, боловсролын түүх, ажил мэргэжлийг нь бодолцоорой. Тэднийг өөртөө дотно байдаг хүмүүсийн адил таньж мэдээрэй.
3. Та энэ бизнесээс яг яаж мөнгө олох вэ? Боломжит орлого хаанаас орж ирэх бол?
4. Танайхтай ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгодог бусад компаниас юугараа ялгаатай вэ? Та бизнесээ бусад компаниас юугаар нь ангид авч үзэх вэ?
5. Тодорхой зах зээл юм уу аж үйлдвэрт нэвтрэхэд Танд чухам ямар бэрхшээл тохиолдож болзошгүй вэ? Амархан зохицож орж чадах уу эсхүл хүссэн зах зээлээ эзлэхэд асуудалтай байна гэж үзэж байна уу?
6. Та хэдэн өрсөлдөгч компанитайгаа мэдэх үү? Таны явуулах гэж байгаа бизнесийн төрөлтэй ижил өрсөлдөгч олон байдаг уу?
7. Таны төлөвлөсөн зах зээлийн мөнгөний хэмжээ ямар вэ? Таны зарах гэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрэглэгчид жилд хэдий хэмжээний хөрөнгө зарцуулдгийг мэдэх үү?
8. Таны зорилтот зах зээл өсөж байна уу, буурч байна уу?
9. Та өөрийн талдаа оруулж болох нийт зах зээлийн хувийг бодож гаргана уу?
10. Та бизнесээ ямар хэлбэрээр явуулах вэ? Аж ахуй эрхлэгч, компани, нэг хүний өмчлөл, корпораци?
11. Бизнесээ эхлүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө хэрэгтэй вэ?
12. Та бизнесээ эхлүүлэхэд зээл авах уу эсхүл хөрөнгө оруулалтын хэлбэрийг ашиглах уу? Нийт хэдий хэмжээний хөрөнгө шаардлагатай болох вэ?
13. Та хөрөнгийн биржид бүртгүүлэх үү, эсхүл бизнесээ зарах уу?
14. Та хөрөнгө оруулагчдаа хэдий хэмжээний ашиг өгөхөөр төлөвлөж байна вэ?

Дээрх асуултууд бизнесээ эхлэхээс өмнө анхаарах дараах гол хэсэгт Таныг чиглүүлнэ:

- Аж үйлдвэр дэх асуудал
- Зах зээлийн бүтэц
- Зах зээлийн хэмжээ
- Зах зээлийн өсөлтийн хувь
- Зах зээлийн багтаамж
- Зардлын бүтэц
- Суурь эдийн засаг
- Гарцын стратеги
- Гарч болзошгүй зардал
- Зах зээлд нэвтрэх бэрхшээл ■

Эх сурвалж: Gaebler.com

Дэлхийн түүх

Ертөнцийг захирсан нь

Дэлхий ертөнц эдүгээг хүртэл тэр аяараа хэний ч өлмий дор сөгдсөн удаагүй. Тэгвэл аль улс газар нутгийхаа хэмжээгээр хамгийн том буюу дэлхийн хэмжээнд дөхөж очсон юм бол?

Манай гаригийн газрын гадаргын хүн, амьтан суурьших боломжит хэсэг (Антарктидийг оролцуулалгүйгээр) ойролцоогоор 136,433,400 ам дөрвөлжин км талбайг эзэлдэг байна. Харин улс гүрнүүдийн дотроос бүх цаг үеийн хамгийн өргөн уудам нутгийг өөртөө нэгтгэж чадсан орон хэмжээгээрээ дэлхийн гуравны нэгийг эзэлж байжээ. Уншигч та бүхэнд улс төр, эдийн засаг, цэрэг армийн хувьд ялгуусан байлдан дагуулалт хийж газар нутгийн хэмжээгээрээ түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн орнуудыг буурах дарааллаар хүргэж байна. ▶

1 Их Британийн хамтын нөхөрлөлийн хаант улс



Их Британийн хаант улс нь 1917-1922 оны хооронд асар их хүчирхэгжиж, түүхэнд хэний ч бүтээж чадаагүй агуу гүрнийг бий болгож чаджээ. Бүх цаг хугацааны туршид газар нутгийн хувьд хамгийн том байх

• Тодорхой цаг хугацаанд эзэлсэн газар нутгийн дээд хэмжээ 1917-1922 он (36,666,630 ам дөрвөлжин км)

• Бүх цаг хугацааны туршид газар нутгийн тэлсэн дээд хэмжээ (39,808,890 ам дөрвөлжин км)

үедээ АНУ-ын зүүн тэнгисийн эрэг орчим болон бусад өөртөө нэгтгэсэн бүс нутгийг багтааж байв. Хожим нь задран бутарч, XIX зууны сүүл XX зууны эхэнд дахин өргөжин тэлсэн байна.

2 Социалист эзэнт гүрэн



Коммунист улсууд хэзээ ч нэг удирдагчийн ташуур дор байгаагүй хэдий ч Жозеф Сталин 1948-1953 оны хооронд ЗСБНХУ-ын төрийн удирдлагыг бие даан гартаа барьж байсан юм. Тухайн үед үзэл суртлын дор нэгдсэн эзэнт гүрэн нь Орос

• Нийт коммунист үзэл сурталтай орнууд (35,742,000 ам дөрвөлжин км)

• Социалист орнуудын нэгдэл (25,598,500 ам дөрвөлжин км)

тэргүүтэй социалист орнууд болон Хятадаар ахлуулсан зүүн зүгийн орнууд хэмээн хуваагдаж байжээ. Нийт коммунист ертөнцийн орнуудын газар нутгийн хэмжээнд эвсэлд үл нэгдсэн коммунист орнууд болох Ангол, Танзани, Лаос багтаагүй болно.

3 Монголын эзэнт гүрэн




• Монголын нийт газар нутгийн хэмжээ Юань гүрний үед (33,152,000 ам дөрвөлжин км)

Монголын эзэнт гүрний ноёрхол 1238-1268 оны хооронд оргил цэгтээ хүрчээ. Зарим түүхэн газрын зургууд Сибир нутгийг бүхэлдээ Монголын байсан хэмээн тэмдэглэсэн байдаг байна. Гэхдээ үгүй ч байх магадлалтай гэнэ. Нүүдэлчин монголчууд тухайн үед Сибирийн баруун хэсэг дэх үлэмж хэмжээний нутаг руу нэвтэрч чадсан гэдэг. Гэхдээ Монгол ямар ч цэргээ Якут, Магадан руу илгээгүй бөгөөд Арктикийн бүс нутгийн ойролцоо дөхөж очсон гэх түүхэн баталгаа байдаггүй аж. Ази, Европыг нэгтгэсэн байлдан дагуулалтын энэ үеийг Монголын түүхэн дэх алтан үе гэж үздэг.

4

Испанийн колонийн эзэнт гүрэн



Испани улс нь 1740-1790 оны хооронд хамгийн өргөн уудам газар нутгийг эзэмшиж байжээ. Өмнөд Америкийн тэн хагас, Хойд Америкийн гуравны нэг нь болон Номхон далайн сав газар тухайн үеийн тус улсын мэдэлд байв. Испани Португалын колоничлолын

• Газар нутгийн дээд хэмжээ (19,425,000 ам дөрвөлжин км)

нэгдсэн улс гээд бодоод үзвэл харьцангуй том байх ёстой биш гэж үү хэмээн эргэлзэж байвал үгүй гэнэ. Тус хоёр улс 1580-1640 оны хооронд нэгэн титмийн дор нэгдсэн хэдий авч, Португал Бразил улсын зөвхөн эрэг хавийн нутаг, зарим өмнөдхэсэг газрыг эзэмшиж байжээ. Тухайн үед Амазоны сав газрыг бүхэлд нь илрүүлээгүй байсан учир тус хэсэг Испанийн газар нутагт багтах үндэслэлгүй. Өмнөд Африкийн хувьд ч Португалын байлдан дагуулалт дээрхтэй ижил нөхцөл байдалд байжээ.

► *Үзэл суртлын хувьд улс гүрнүүдийг нэгтгэн авч үзэж доорх жагсаалтад нэмэн оруулсан байна. Бие даасан тусгаар улс болохынх нь хувьд авч үзвэл “Их Монгол” улс газар нутгийн хэмжээгээрээ дэлхийн түүхийн ихэнх жагсаалтад хоёрт бичигддэг. Харин зарим түүхч Монголын эзэнт гүрэн нь (1206-1405) түүхэн дэх хамгийн том, үргэлжилсэн газар нутагтай эзэнт гүрэн байсан гэж үздэг. Манай өвөг дээдэс хамгийн өвчирхэг үедээ 40 саяас илүү хавтгай дөрвөлжин км газар нутгийг эзэмшиж байжээ. Түүхчид “Британийн эзэнт гүрэн”-ий газар нутгийг Монголоос хамаагүй том байсан хэмээн үзэж түүхэн дэх “хамгийн том эзэнт гүрэн” гэж тэмдэглэсэн байдаг нь дагаар орсон болон хараат овог аймгуудын газар нутгийг оруулаагүй тооцсон байдагтай холбоотой гэж үзэх тал ч байдаг байна.*

5

Оросын холбооны улс



• Газар нутгийн дээд хэмжээ (17,073,280 ам дөрвөлжин км)

Дээр дурьдсанчлан Орос нь холбооны улсуудын нэгтгэгч хүчин буюу социалист ертөнцийн төв цэг байсан билээ. Хэдийгээр тус улсын харьяанд байсан олон улс гүрнүүд салан тусгаарлаж, ганцаараа шахам үлдсэн ч ОХУ өнөөдөр дэлхий дээрх хамгийн том газар нутагтай орон хэвээр байгаа юм.

Фашист дэглэмийн орнууд



Дэлхийн II дайны үеийн фашист хүчнийхэн нэгдсэн нэг хүний захиргаан дор хэзээ ч байгаагүй билээ. Тэдгээр улсыг тулгуур гурван орон ба жижиг туслагч гүрнүүд хэмээн авч үздэг аж. Үнэн хэрэгтээ зарим нэг жижиг улсын хувьд зөвхөн нэр төдий холбоотой байсан байдаг. Тухайлбал, хоёр орны хоорондох дайсгалд гуравдагч хүчний бага ч гэсэн дэмжлэг, хамгаалалт хэрэг болох нөхцөлд тэдний сунгасан гарыг ашигладаг байж. Фашизмын дэглэмт гүрнүүдийн хийсэн

- Японы газар нутаг, байлдан дагуулалт (7,417,760)
- Германы газар нутаг, байлдан дагуулалт (3,898,000)
- Италийн газар нутаг, байлдан дагуулалт (3,732,341)
- Бусад фашист холбоотон орнууд (646,982 ам дөрвөлжин км)
- **Нийт фашист холбоотон орнуудын газар нутгийн хэмжээ (15,695,083)**

хамгийн том дайралт бол 1942 оны 8-10 дугаар сарын хооронд Германы арми Сталинградын хаалганд тулан ирж, бүслэлтэндээ байлгах хугацаандаа Египт улс руу дайрч, тус улсын боомт хот болох Александрт 70 км-ээс багагүй зайд дөхөн ирсэн удаатай аж. Харин Японы арми Соломоны арал руу дайрах оролдлого хийсэн хэдий ч АНУ-ын хариу давшилтад Guadalcanal-т бууж ч чадалгүй далай дээр бут цохиулж, багагүй хохирол амссан байдаг.

6 Уйгур улс



• Газар нутгийн нийт хэмжээ
(7,770,000 ам дөрвөлжин км)

Эх захгүй нутгийн эзэн нь болон амьдарч байсан Уйгур улсын газар дэвсгэр Өмнөд Сибир, Монгол, Манжур, Казахстан, Шиньжаны зарим хэсгийг багтааж байжээ. Уйгурууд (эртний Түрэг хүмүүс) Шиньжаны хэсэг газрыг манай эриний 630 онд Хөх Түргийн салан

тусгаарлалтын дараах үе хүртэл захирч байсан түүхтэй. Тэдний ялгуусан байлдан дагуулалтын хүчирхэг үе ойролцоогоор манай эриний 760-795 оны хооронд үргэлжилсэн байдаг. Улмаар тус улс МЭ 850 онд хагаран бутарчээ.

7 Төмөрийн эзэнт гүрэн



• Газар нутгийн нийт хэмжээ
(3,742,550 ам дөрвөлжин км)

Төмөрийн (Доголон Төмөр) эзэнт гүрний үүсэл нь Монголын нүүдэлчин аймаг Барлабаас улбаатай. Тус улс Трансоксиана (одоогийн Төв Ази), Хорасаны (одоогийн Иран, Афганистан, Узбе-

кстан, Тажикстан)-ы ихэнх хэсгийг эзэмшсэнээр байгуулагдсан түүхтэй. Төмөрийн эзэнт гүрэн 1380-1405 оны хооронд оршин тогтнож байжээ.

8 Алтан ордны улс (Зүчийн улс)



• Газар нутгийн дээд хэмжээ
(тусгаар улс болсны хойно) 3,742,550 ам дөрвөлжин км

• Газар нутгийн дээд хэмжээ
(Монголын эзэнт гүрний харьяанд 3,431,750 хавтгай дөрвөлжин км)

Алтан ордны улст баруун монголчууд давамгайл байсан бөгөөд Орос, Украины ихэнх газар нутгийг эзэлж улмаар Европ тив рүү нэлээд гүн нэвтэрч чадсан байна. Монголын эзэнт гүрний нэг хэсэг байх үед, салан тусгаарлаж бие даасан статустай оршин тогтнож байх үе хэмээх хоёр

өөр газар нутгийн хэмжээтэй байж. Зүчийн улсыг Кипчакын тал нутагт оршин суудаг байсан учир "Кипчакын хаант улс" ч гэж нэрлэдэг байжээ. Тус улсын удаах хаанаар дэлхийд гавьяа нэрээ дуурсгасан Бат хаан тодорсон билээ.

9 Цагаадайн улс



• Газар нутгийн нийт хэмжээ
(3,367,000 ам дөрвөлжин км)

Монголын эзэнт гүрний харьяа орд улс болон 1227 онд байгуулагдсан бөгөөд эзэнт гүрний нэгдмэл байдал үгүй болох хүртэл буюу 1335 оныг дуустал Монголын ноёрхолд байжээ. Үүний дараагаар

Цагаадайн улс богино хугацаанд Шиньжаны Узбекистаны ихэнх хэсгийг, Казахстан, Киргизстаны газар нутгийн тал орчим хувийг Зүүн ба Баруун ордны улс руу хуваагдахаасаа өмнө захирч байжээ.

9 Хөх Түрэг



• Газар нутгийн нийт хэмжээ
(3,367,000 хавтгай дөрвөлжин км)

Сибир орчимд голчлон суурьшиж байсан орд улс бөгөөд эртний Жу Жан гүрний залгамжлагч юм. Тэд одоогийн Турк ард түмний өвөг билээ. Хөх Түрэг нь V, VI зууны эхэн үе, VII зууны сүүл үе хүртэлх хугацаанд Өмнөд Сибир болон

Монголын тал нутгийг захирч байжээ. Улмаар Зүүн ба Баруун орд улс руу салан хуваагдаж хөрш аймгуудын удаа дараагийн дайралтад өртөж хүч чадал нь тарамдсан гэдэг. Харин XI зууны үед хүчирхэгжин дахин гарч ирсэн түүхтэй.

9 Хүннү гүрэн



• Газар нутгийн
нийт хэмжээ
(2,849,000 хавтгай
дөрвөлжин км)

Хүннү улс Төв Азийн баруун хэсэгт оршин сууж байсан хүчирхэг нөлөө бүхий томоохон овог аймаг байв. Хятадын ард түмэн тэднийг Сүннү хэмээн дууддаг байсан бол энэтхэгчүүд Хуна хүмүүс хэмээн гэдэг байжээ. Хэдийгээр “Хүннү” нэрийг “Нарны хүн” хэмээн утгачилдаг боловч хятадуудын судар бичигт “Хэрцгий боол” гэж бичиж үлдээсэн байдаг байна. Гэвч энэ нь хятадуудын өөрсдийн өгсөн нэр байх магадлалтай аж. Баруун хүннүчүүд IV зуунд Волга мөрөнг гатлан Украйнд очиж улмаар Европт суурьшжээ.

Хүннү гүрний хойч Атилла 450-455 оны үед Европыг чичрүүлж байсан түүхтэй. Хүннү гаралтай овог аймгууд ялангуяа урд талын хил орчимдоо нэлээдэмх цэгцгүй байсан бөгөөд Атиллагийн захиргаанд бүрэн нэгдэж чадаагүй тул тэднийг хаант улс гэж дуудахад учир дутагдалтай хэмээн үздэг. Гэсэн хэдий ч Хүннү гүрэн газар нутгаа хүчирхэг Төв Европ тийш хүртэл тэлэн, Балканыг өөрийн эрхшээлдээ оруулж, олон үндэстэн ястны хувь заяаг гартаа атгасан агуу улс байсныг түүх гэрчилдэг билээ.

Дээрх жагсаалтад бүх цаг үеийн дотор тодорхой цаг хугацаанд хүчирхэгжиж газар нутгаа үлэмж хэмжээнд тэлж чадсан улс орнуудыг багтаажээ. Ийм төрлийн жагсаалт нэлээдгүй олон байх боловч өөр өөрийн онцлог, түүхэн баримт бичгийн маргаантай асуудлуудаас үүдэн ондоо байх талтай аж. Ямартай ч энэхүү жагсаалт 47 улс орныг байр эзлүүлсэн байгаагаас бидний өвөг дээдэс Чингис хааны бий болгосон Монголын эзэнт гүрэн гуравдугаарт оржээ. Энд ажиглагдсан бас нэгэн сонирхолтой зүйл нь Монголоор овогдсон олон үндэстэн ястны бүрдүүлсэн улс гүрнүүд уг жагсаалтад багтсан байгаа юм. Хоёроос дээш нэр нь гарсан улс Монголоос өөр байгаагүй нь бидний өвөг эцэг зөвхөн Чингис хаан гэлгүй бүх цаг үеийн туршид ямар агуу сэцэн мэргэн ухаантай байсныг харуулж байгаа хэрэг болов уу.

Нийт 47 улсаас тэр дундаа томоохон гэж үзвэл 37 орноос монгол гаралтай улс найм байна. Гайхаж бишрэм түүх, соёл, үзэсгэлэнт байгальтай Монгол орон өнөөдөр 1,5 сая гаруй ам дөрвөлжин км газар нутагтай бол Чингис хааны ач Хубилай хаан тэртээх XIII зуунд өнөөгийнхөөс 22 дахин том газар нутгийг өөрийн мэдэлдээ захирч байжээ.

Бизнесийн завсарлага

Та ямар ном уншиж байгаа вэ?


С.Оюун

/Улсын Их Хурлын гишүүн/:

Тэрбээр Дан Сенор, Саул Сингер нарын бичсэн “Гарааны үндэстэн: Израилийн эдийн засгийн гайхамшгийн түүх” номыг уншиж байгаа аж. Израиль улс нийт 7.1 сая хүн амтай, 60 жилийн түүхтэй, үүсгэн байгуулагдсан цагаасаа байнга дайн дажинд өртсөн, байгалийн баялаггүй орон атал Канад, Япон, Хятад, Энэтхэг, Англи хэмээх том улс гүрнүүдээс илүү олон бизнес эрхлэгчдийг төрүүлжээ. Энэхүү ном нь тус орны шилдэг зохион бүтээгчид болон хөрөнгө оруулагчдын жишээн дээр геополитикийн мэргэжилтнүүд Израиль улс хэрхэн шинэ сэдэл ба бизнес

эрхлэлтийг дэмждэгийг дүрслэн харуулсан байна. Зохиолчид нь номоо бичихийн тулд 100 гаруй хүмүүсээс ярилцлага авчээ. Тэдгээрт Израилийн тэргүүлэх хөрөнгө оруулагч, түүхч, Америкийн цэргийн удирдагч болон Израиль улсын удирдагчид орсон аж. Зохиолчид “Израиль улсад бусад улс гүрнээс суралцах зүйлс их байхад, дэлхийн бусад гүрэнд ч гэсэн Израилиас суралцах юм их байна” хэмээн дүгнэжээ.

“Гарааны үндэстэн,” “Нью-Йорк таймс”, “Уолл стрийт журнал”-ын шилдэг номын жагсаалтад хэдийнэ орсон байна.




Дийтер Саломон

/Германы Брайсгау дах Франкфурт хотын захирагч/:

Дэлхийн ногоон хотын захирал Вийнфрид Кретшманн намтрыг уншихыг санал болгож байна. Тэрбээр Баден-Вюртемберг мужийн Ерөнхий сайдаар энэ оны тавдугаар сараас эхэлж ажиллах болсон Германы Ногоон намын анхны төлөөлөгч юм. “Вийнфрид Кретшманн-Херөг” нэртэй номыг бүсийн улс төрийн асуудлаар олон жил дагнасан Петер Хенкель, Йоханн Хенкель-Ваидхофер нар бичжээ. Тэрбээр “Вийнфрид Кретшманныг би сайн танина, мөн түүнийг шударга, шулуун, найрсаг, даруухан зантай гэж үнэлдэг учир надад энэ ном таалагдсан. Түүний энэ зан чанар хүмүүст

итгэл үнэмшил төрүүлдэг. Ландтаг буюу мужийн Парламентын гишүүнээр ажиллаж байсан Вийнфрид Кретшманн нь 1979/1980 онд Германы Ногоон намыг үүсгэн байгуулсан хүмүүсийн нэг юм. Бид хоёр Ландтагд хамт ажилласны сацуу сайн найз нөхөд болж үлдсэн. Түүнд би сайн сайхан бүхнийг хүсэж байна” гэв.

Дийтер Саломон Германы Ногоон намын сонгуулийн амжилтын учир шалтгаан, мөн одоогоос 30-аад жилийн өмнөөс өнөөг хүртэл хөгжиж буй ногоон улс төрийн бодлогын хөгжлийг сонирхсон хүн бүрт энэхүү номыг уншихыг зөвлөж байна.



Н.Батбаяр /Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын газрын дарга/:

“Уул уурхайн үйлдвэрийн техник эдийн засгийн шинжилгээ” номыг саяхан уншсан. Уул уурхайн үйлдвэр бол олон жилийн турш хөгжсөн шинжлэх ухаан юм. Ордыг ашиглана гэдэг бол маш том эрсдэл. Иймээс ордыг худалдаж авахаас өмнө энэ ажлыг хийснээр ямар хэмжээний хохиролбайгальдучруулахвэ, ашиг орлого болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг сайн судалж, тооцоолсны үндсэн дээр шийдвэрээ гаргах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Та тус ордод хөрөнгө оруулах

итгэлтэй байна уу гэдгээ тал бүрийн шинжилгээ хийж байж гаргах нь чухал. Тэгэхгүй бол нөхөн сэргээлт хийгдээгүй хаягдсан орд нэгээр нэмэгдэнэ. Энэхүү номыг тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хүмүүс уншаасай хэмээн Батбаяр дарга ярьсан аж.

Ж.Бямба-юу, С.Цэдэндорж нарын бичсэн “Уул уурхайн үйлдвэрийн техник эдийн засгийн шинжилгээ” ном 2009 онд Улаанбаатар хотод хэвлэгдэн гарчээ. ■



www.mongolianeconomy.mn

 MONGOLIAN
ECONOMY